

Бүртгэлийн  
дугаар: .....

Нууцын зэрэглэл:  
А

Аравтын бүрэн  
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний  
дугаар:

**БАТЛАН ХАМГААЛАХ  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ЦЭРГИЙН УРЛАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ,  
ТҮҮНИЙ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА**

(операц, тактикийн түвшинд)

Шифр: “Операцын урлаг”

**Төслийн удирдагч:** Ш.Паламдорж. - Доктор (Sc.D), профессор,

БХЭШХ-ий н эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан;

**Төслийн гүйцэтгэгчид:** Ц.Гандорж. - БХЭШХ-ийн Цэргийн урлдаг судлалын төвийн дарга, доктор (Ph.D), хурандаа;

Г.Бүлтэн - БХУА-ийн зөвлөх багш, доктор (Ph.D), профессор;

Ц.Дашзэвэг - БХЭШХ-ийн ЭША, профессор, БХ-ын сайдын цэргийн бодлогын зөвлөх;

Т.Мөнх-Оргил - БХЭШХ-ийн ЭША, доктор (Ph.D), дэд хурандаа.

Ш.Паламдорж. - Доктор (Sc.D), профессор, БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан;

С.Пүрэвдорж - БХЭШХ-ийн ЭША, доктор (Ph.D);

**Санхүүжүүлэгч байгууллага:** БХЯ--ны ШУТЗ

**Захиалагч байгууллага:** БХЯ-ны ШУТЗ, ЗХЖШ, ХЗЦ-ийн командлал;

**Тайлан өмчлөгч:** Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн. 13300 Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16-р хороо, Нянтайсүрэнгийн гудамж, Улаанхуаран. Утас: 453942, Факс: 70150173, Цахим хаяг:

<http://www.mids.gov.mn>;

[mids@mndu.gov.mn](mailto:mids@mndu.gov.mn)

Улаанбаатар. 2019 он.

## АГУУЛГА

|                                                                                                                                                  |     |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| УДИРДТГАЛ .....                                                                                                                                  | 3   |
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЦЭРГИЙН ОПЕРАЦЫН УРЛАГ,<br>ТАКТИКИЙН ХУВЬСАЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ШИНЖИЛГЭЭ .....                                  | 6   |
| § 1.1. Операцын урлагт гарч буй хувьсал, өөрчлөлт .....                                                                                          | 6   |
| § 1.2. Тактикийн урлагт гарч буй хувьсал, өөрчлөлт .....                                                                                         | 16  |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ: ЦЭРГИЙН ОПЕРАЦЫН УРЛАГ, ТАКТИКТ НӨЛӨӨЛЖ БУЙ<br>ГАДААД, ДОТООДЫН ХҮЧИН ЗҮЙЛС .....                                              | 27  |
| § 2.1. Операц, тактикийн урлагт нөлөөлж буй гадаад хүчин зүйлс .....                                                                             | 27  |
| § 2.2. Операц, тактикийн урлагт нөлөөлж буй дотоод хүчин зүйлс .....                                                                             | 41  |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ: ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН<br>ЦЭРГИЙН ОПЕРАЦЫН УРЛАГ, ТАКТИКИЙН ТУРШЛАГА,<br>СУРГАМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА .....                  | 54  |
| § 3.1. Дэлхийн зарим улс орнууд дахь “цэргийн операцын урлаг” хэмээх нэр<br>томъёоны ойлголт, тодорхойлолтын талаарх харьцуулсан шинжилгээ ..... | 54  |
| § 3.2. Дэлхийн зарим улс орнууд дахь цэргийн операцын урлагийн<br>туршлага, сургамжийн шинжилгээ .....                                           | 57  |
| § 3.2.1. АНУ-ын цэргийн хүчний явуулсан “Анаконда” операц .....                                                                                  | 59  |
| § 3.2.2. ОХУ-ын цэргийн хүчний операц .....                                                                                                      | 61  |
| § 3.2.2.1. ОХУ-ын цэргийн хүчний Чеченьд явуулсан операц ..                                                                                      | 61  |
| § 3.2.2.2. ОХУ-ын Сирид явуулсан цэргийн операц .....                                                                                            | 63  |
| § 3.2.3. НАТО-гийн цэргийн хүчний Югославын эсрэг явуулсан операц .....                                                                          | 65  |
| § 3.3. Дэлхийн улс орнуудын операцын урлагт гарч буй<br>хувьсал, өөрчлөлтийн харьцуулалт .....                                                   | 67  |
| § 3.4. Дэлхийн улс орнуудын цэргийн тактикийн<br>туршлага, сургамжийн харьцуулсан судалгаа .....                                                 | 79  |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ОПЕРАЦЫН УРЛАГ, ТАКТИКИЙН<br>ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА .....                                                                      | 86  |
| § 4.1. Операцын урлагийн хөгжлийн чиг хандлага .....                                                                                             | 86  |
| § 4.1. Тактикийн хөгжлийн чиг хандлага .....                                                                                                     | 100 |
| ТӨГСГӨЛ .....                                                                                                                                    | 109 |
| ЭШЛЭЛ АВСАН СУРВАЛЖ,<br>СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ .....                                                                                      | 114 |

## УДИРДТГАЛ

Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар ихээхэн өөрчлөгдөж, түүнийг явуулах арга, хэрэгсэл - зэвсэглэл, цэргийн техник болон арга, тактикийн ажиллагаа өмнөх үеийнхээс өөр болж байна. Дайн, зэвсэгт мөргөлдөөний агуулга, хэлбэр шинэчлэгдэж байна.

Дайны талаар судалгаа шинжилгээний ажил манайд багагүй явагдаж нийтийн хүртээл болоод байна. Тухайлбал, “Дайны тухай онол, сургамж”<sup>1</sup>, “Дайны хувьсал өөрчлөлт, цэргийн урлагийн хандлага”<sup>2</sup>, “Мэдээллийн дайн, түүнээс хамгаалах”<sup>3</sup>, “Хүч тэнцвэргүй дайн”<sup>4</sup>, “Цэрэг, армийн тухай-II”<sup>5</sup>, Олон улсыг терроризм, түүнтэй тэмцэх онол, арга зүйн үндэс<sup>6</sup> зэрэг бүтээлийг нэрлэж болох юм. Дайн, зэвсэгт мөргөлдөөний хэлбэр, агуулга хувьсан өөрчлөгдөж буй нь зэвсэгт тэмцлийг явуулж буй тэмцлийн хэрэгслийн хөгжил, түүнийг явуулах стратеги, операц, тактикийн өөрчлөлт, хүний хүчин зүйлийн нөлөө зэрэгтэй холбогдож байна.

Цэргийн стратеги, операц, байлдааны агуулга, хэлбэр шинэчлэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд цэргийн урлагийн чиглэлд судалгаа, шинжилгээний ажил хийгдэж, “Хорьдугаар зууны Монголын цэргийн урлагийн түүх”<sup>7</sup>, “Стратеги”<sup>8</sup>, “Цэргийн стратегийн үндэс”<sup>9</sup>, “Еранхий тактик”<sup>10</sup>, “Тактикийн суурь онол”<sup>11</sup>, “Тактик-I”<sup>12</sup>, “Тактик-II”<sup>13</sup>, “Операцын онол”<sup>14</sup>, “Батлан хамгаалах стратеги”<sup>15</sup>, “Зэвсэгт хүчний стратеги”<sup>16</sup>, “Операцын урлаг судлал”<sup>17</sup>, “Цэргийн урлагийн онолын эх сурвалжийн гурван ноён оргил”<sup>18</sup> зэрэг нэг сэдэвт онол, арга зүй, шинжилгээний бүтээлүүд болон сурах бичиг, гарын авлага хэвлэн нийтлэгдсэн байна.

Гэсэн хэдий ч “Операцын урлагт гарч буй өөрчлөлт, түүний хөгжлийн хандлага” (операц, тактикийн түвшинд)-ыг цогц байдлаар системтэй, дагнан судалж, гадаадын улс орнуудаас явуулсан операц, тактикийн ажиллагааг харьцуулан үнэлж, дүгнэлт хийсэн,

<sup>1</sup> Ш.Паламдорж, Л.Бямбасүрэн. Дайны тухай онол, сургамж. УБ., 2001 он. – х;

<sup>2</sup> Ш.Паламдорж. Дайны хувьсал өөрчлөлт, цэргийн урлагийн хандлага. УБ., 2011 он. –184 х; ISBN 978-99962-50-25-5;

<sup>3</sup> Ш.Паламдорж. Мэдээллийн дайн, түүнээс хамгаалах. УБ., 2003 он. –162х;

<sup>4</sup> Хүч тэнцвэргүй дайн, байлдаан. УБ., 2018 он. – 186х; ISBN 978-99978-848-3-1;

<sup>5</sup> Ц.Дашзэвэг. Цэрэг, армийн тухай-II. УБ., 2015 он. -324;

<sup>6</sup> Ш.Паламдорж, Ц.Дашзэвэг. Олон улсыг терроризм, түүнтэй тэмцэх онол, арга зүйн үндэс. УБ., 2006 он. -232х; ISBN 99929-4-024-7;

<sup>7</sup> Хорьдугаар зууны Монгол цэргийн урлагийн түүх. УБ., 2009 он. -240х;

<sup>8</sup> Б.Шагдар. Стратеги. Б., 2018 он. – х;

<sup>9</sup> Д.Доржготов. Цэргийн стратегийн үндэс. УБ., 2008 он. – 243х; ISBN 978-99978-922-4-7;

<sup>10</sup> Г.Бүлтэн. Ерөнхий тактик. УБ., 2012 он. – 278х; ISBN 978-99929-804-9-4;

<sup>11</sup> Г.Бүлтэн. Тактикийн суурь онол. УБ., 2012 он. – 198х; ISBN 978-99962-50-00-2;

<sup>12</sup> Б.Шагдар. Тактик-I. УБ., 2011 он. – 160х; ISBN 978-99962-50-15-6;

<sup>13</sup> Б.Шагдар. Тактик- II. УБ., 2013 он. – 214х; ISBN 978-99962-50-16-3;

<sup>14</sup> Д.Доржготов. Операцын онол. УБ., 2010 он. - ; ISBN 978-99929-804-6-X;

<sup>15</sup> Батлан хамгаалах стратеги. УБ., 2017 он. – 400х;

<sup>16</sup> Зэвсэгт хүчний стратеги. УБ., 2017 он. – 444х;

<sup>17</sup> Операцын урлаг судлал. УБ., 2018 он. – 130 х; ISBN 978-99978-848-4-8;

<sup>18</sup> Ц.Дашзэвэг. Цэргийн урлагийн онолын эх сурвалжийн гурван ноён оргил. Уб., 2016 он;

өөрийн үндэсний цэргийн урлагийн хөгжилд тэдгээрээс заримыг нь нэвтрүүлэх арга замыг тогтоосон буурь суурьтай судалгаа шинжилгээний ажил явагдаагүй, бүтээл туурвил нийтлэгдээгүй байна.

Өнөө үеийн цэргийн операц, байлдаан хүч тэнцвэргүй талуудын хооронд, тодруулж хэлбэл, зургаа дахь болон дөрөв дэх үеийн зэвсэглэл бүхий талуудын хооронд явагдах нь түгээмэл болжээ. Энэ бүхнийг судалж, өөрийн орны цэргийн урлагийн онол, практикт нэвтрүүлэх, үндэсний цэргийн урлагийг хөгжүүлэх шаардлага, хэрэгцээ зүй ёсоор тавигдаж байна.

Энэ жилээс эхлэн “Үндэсний цэргийн урлагийн: операцын урлаг, ерөнхий тактик” гэсэн сэдэвт судалгааны ажлыг явуулж, нэг сэдэвт онол, арга зүй, шинжилгээний бүтээл туурвихаар судалгааны ажил эхлээд байна. Үүнд урьтал болгож, БХЯ-ны ШУТЗ-өөс “Операцын урлагт гарч буй өөрчлөлт, түүний хөгжлийн хандлага” (операц, тактикийн түвшинд) судалгааг явуулах даалгаврыг БХЭШХ-ийн Цэргийн урлаг судлалын төвд өгсөн юм.

Иймд дээрх “Үндэсний цэргийн урлагийн: операцын урлаг, ерөнхий тактик” гэсэн судалгааны ажлын эхлэл, үндэс суурь болох дэлхийн улс орнуудын цэргийн операц, тактикийн урлагийн хувьсал өөрчлөлт, түүний хөгжлийн хандлагыг болон үндэсний цэргийн урлагийн операц, тактикийн онол, практикт нэвтрүүлэх асуудлыг судлахаар энэхүү судалгааг явуулсан болно.

Энэхүү судалгааны ажил нь урд өмнө явуулж байсан адил төстэй судалгааны ажлын үр дүнд болон бас ашиглагдаж байгаагүй эх сурвалж, судалгааны бүтээлүүдэд ч үндэслэгдсэн болно.

Төслийн ажлыг шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D), эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, профессор Ш.Паламдорж удирдаж, төслийн зохицуулагчаар БХЭШХ-ийн Цэргийн урлаг судлалын төвийн дарга, доктор (Ph.D), хурандаа Ц.Гандорж ажиллав,

Төслийн багт: цэргийн урлаг судлалын төвийн судлаач: доктор (Ph.D), хурандаа Ц.Гандорж, судлаач профессор, дэслэгч генерал Ц.Дашзэвэг, доктор (Ph.D), дэд хурандаа Т.Мөнх-Оргил, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ш.Паламдорж, доктор (Ph.D), дэд профессор С.Пүрэвдорж, БХУА-ийн зөвлөх багш, доктор (Ph.D), профессор Г.Бүлтэн нар оролцлоо.

Үндэсний цэргийн урлагийг операц, тактикт ашиглах, нэвтрүүлэх практик ажиллагааны явц, өрнөлийг дэлгэрүүлэн задалж тайлбарласан, зөвлөсөн хэсгийг нийтэд мэдээлэхгүй учир судалгааны ажлын тайлан хязгаарлагдмал хүрээнд ашиглагдах, албан хэрэгцээний зэрэглэлд хамаарах болно.

Судалгааны ажлын үр дүнгийн тайланг бичих онол, арга зүйн удирдамжийг БХЭШХ-ийн Эрдмийн Зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан (Протокол №4)-аар хэлэлцүүлж батлуулан дагаж мөрдөж ажилласан болно.

Судалгааны ажлын тайланг БХЯ-наас ирүүлсэн даалгаврын агуулгад нийцүүлж: удирдтгал, гурван бүлэг, ерөнхий дүгнэлт, эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээлийн жагсаалттай, 118 хуудасанд багтаан бичлээ.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**  
**ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЦЭРГИЙН ОПЕРАЦЫН УРЛАГ,**  
**ТАКТИКИЙН ХУВЬСАЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ШИНЖИЛГЭЭ**

**§ 1.1. Операцийн урлагийн хувьсал, өөрчлөлт**

Операцийн урлаг дэлхийн улс орнуудын цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсэг дотроос хамгийн хурдтай хувьсан хөгжиж буй хэсэг нь юм. Энэхүү урлагийн хувьсал өөрчлөлтийн өнөөгийн байдлыг түүний үүсэл, хөгжлийн тоймоос ангид авч үзэх боломжгүй юм. Цэргийн урлагийн үүсэл, хөгжлийн судалгаа шинжилгээний ажилд диалектик арга зүйг баримтлах нь энэ асуудлыг шинжлэн судлахад шинжлэх ухаанч чанарыг хангах үндэс болж өгдөг. Өнгөрсөн зууны болон өнөө үеийн Монголын үндэсний цэргийн операцийн урлаг нь Оросын цэргийн операцийн урлагтай салшгүй холбоотой хөгжиж ирсэн түүхэн уламжлалтай. Иймээс дэлхийн улс орнуудын цэргийн операцийн урлагийн хувьсал өөрчлөлтөд шинжилгээ хийхдээ Оросын цэргийн операцийн урлагийн хувьсал өөрчлөлтөөс эхлэн нь логикийн хувьд оновчтой хэмээн үзэж байна.

Оросод цэргийн урлаг үүсэн хөгжих бодит нөхцөл ХҮШ зууны төгсгөл, XIX зууны эхээр бүрдсэн гэж үздэг байна<sup>19</sup>. Энэ үед өргөн уудам орон зайд, нэгэн зэрэг, дараалсан олон байлдааныг харьцангуй урт хугацаагаар явуулдаг болсон байна. Энэ нь янз бүрийн бүрэлдэхүүнтэй, явган болон морин цэрэг, артиллериас бүрдсэн цэргийн нэгдэл, нэгтгэл, ангиудыг нэгэн командлалд оруулж, нэгдсэн бодлого, төлөвлөгөөгөөр өргөн уудам орон зайд дайн, байлдаанд оролцуулах шаардлага, хэрэгцээг бий болгожээ.

Цэргийн операцийн урлагийн үүсэл, хөгжил нь цэргийн урлагийн үүсэл хөгжилтэй холбоотой ч стратеги, тактикийг бодвол, нэлээд хожуу үед дайтах, байлдах урлагийн бие даасан мэдлэгийн тогтолцоо, практик үйлдэл болж төлөвшсөн түүхтэй. Ялангуяа, *операцийн урлагийн үүсэл, хөгжил нь цэргийн стратеги, тактикийн нэгэн адил эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас хамааралтай байх бөгөөд шинжлэх ухаан танин мэдэхүй, соёл, техникийн ололт, түвшинөөс бас шалтгаалж* иржээ. “Энэ нөхцөл, шалтгаан нь нийгмийн хөгжлийн янз бүрийн үе шат, улс үндэстэн бүрд өөр өөр байх бөгөөд цэргийн урлаг нь улс тус бүрд үндэсний шинж, онцлогтой байдаг”<sup>20</sup>.

Харин цэргийн урлагийн онол (стратегийн, тактик), ө.х. дайн, байлдаанд бэлтгэх, түүнийг явуулах тухай цэргийн шинжлэх ухааны үндсэн судлагдахуун болж, ХҮШ, XIX зууны заагаас бүрэлдэж хөгжсөн гэж оросууд үздэг. Үүнийг ХҮШ зууны төгсгөл, XIX зууны

<sup>19</sup> Большая Российская Энциклопедия. Авторы: А.Д.Борцов. “История оперативного искусства”.

<sup>20</sup> Постигение военного искусства: Идеиное наследие А.Свечина.т.48;

эхэн үеэр аж үйлдвэр өндөр хөгжсөн улс орнуудад тухайн цаг үеийнхээ шинэ зэвсэглэл, цэргийн техникээр цэрэг, армия бүрэн хангаж эхэлсэн бодит нөхцөлтэй холбон тайлбарладаг.

Шинэ тулгар бүрэлдэн тогтносон ЗХУ (хуучин нэрээр)-ын хувьд иргэний дайн, түүний дараа үеэс цэргийн операцын урлаг бүтээлч сэтгэлгээтэй цэргийн жанжнуудын туршлага сургамж, онол, арга зүйн бүтээл туурвилаар цэргийн шинжлэх ухаан болон хөгжих суурь дэвсгэр нь тавигдсан байна.

Операцын урлагийг ОХУ-д оперативын урлаг гэж, барууныхан “бага стратеги” эсвэл “их тактик” гэж нэрлэж байсан юм. Нэг юмыг янз янзаар нэрлэдэг хэдий ч ойлголтын агуулга нь нэг байх тохиолдол шинжлэх ухаан, практикийн аль алинд байдаг. Тухайн нэр томьёо, категорийн тодорхойлолт нь мэргэжлийн хүмүүс болон шинжлэх ухааныг нэгтгэх үндэс болж өгдөг. Энэ үүднээс бид “операцын урлаг” гэсэн үндэсний цэргийн урлагийн нэр томьёо, категорийг ашиглаж байна. Бид нэг хэсэгтээ “оперативын урлаг – оперативное искусство – operational art” гэсэн нэр томьёог хуулбарлан ашиглаж байлаа<sup>21</sup>. “Оперативный”, “операция” гэсэн орос үгс монголоор адилхан биш агуулгатай байдаг бөгөөд монголоор бол “оперативный” гэсэн үг нь “шаламгай, шуурхай” гэсэн<sup>22</sup>, “операц” нь - “гардан биелүүлэх (гүйцэтгэх)”, “(байлдааны) ажиллагаа” гэсэн утгатай<sup>23</sup> буулгагддаг байна. Харин “операц” гэсэн орос үгийг цэргийн урлагтай холбон монголчилвол, “байлдааны ажиллагаа” гэж буух бөгөөд ийм нэр томьёоны агуулга нь аль эрт тогтсон тодорхойлолт бүхий ойлголт юм. “Байлдааны ажиллагаа” – (боевые действия – Fighting (the action of fighting; violence or conflict.) бол ЗХ-ний ай, төрлийн цэргийн нэгдэл, нэгтгэл, ангиудаар операц, тактикийн түвшний байлдааны үүргийг гүйцэтгүүлэхийн тулд тэдний хүч, хэрэгслийг зохион байгуулалттай хэрэглэх үйл явц гэж ойлгож ирсэн юм.

Тиймээс “операц” гэсэн монгол хэлнээ нэвтэрсэн<sup>24</sup> гадаад үгийг ашиглаж “цэргийн операцын урлаг” гэж нэрлэх нь оновчтой байгаа юм. Энэ нэр томьёог ОХУ-ын томоохон эрдэмтэд “операционное искусство”<sup>25</sup> гэж өөрчлөн ашигласан бүтээл сүүлийн үед гарч байна. Мөн Оросын цэргийн урлаг судлаач зарим эрдэмтэд<sup>26</sup> “Стратегия, Оператика и Тактика” гэсэн нэр томьёог урьд өмнө ашиглаж, стратеги, оператик, тактик бол дайныг явуулах аргууд юм. Стратеги нь дайнд цэргийн дээд командлалын эрхлэх ажил - оператик,

<sup>21</sup> Хорьдугаар зууны Монгол цэргийн урлагийн түүх. УБ., 2009 он. т.31-50; Цэргийн нэр томьёоны тайлбар толь. УБ., 2014. т.219, 427;

<sup>22</sup> Ц.Дамдинсүрэн, Л.Лувсандэндэв. Русско-монгольский словарь. УБ., Госиздат. 1982г. – 840с; т.378;

<sup>23</sup> Ц.Дамдинсүрэн, Л.Лувсандэндэв. Русско-монгольский словарь. УБ., Госиздат. 1982г. – 840с; т.378;

<sup>24</sup> Большой академический монгольско-русский словарь. Четырех томах. Москва. “Academia”. 2001г. Том II. – 536с; т.486;

<sup>25</sup> Вестн. Моск. ун-та. Сер. 25: Международные отношения и мировая политика. 2015 № 3. Стр. 3-22. Кокошин А.А, Балувевский Ю. Н, Потапов В. Я. “Влияние ядерного фактора на развитие отечественной военной мысли”;

<sup>26</sup> А.А.Свечин. Стратегия. Военный вестник. Москва. 1927. -265с;

тактикийг ашиглах ухаан; оператик нь армийн командлагчийн эрхлэх, тулалдааны явуулах ухаан; тактик нь захирагчийн эрхлэх, байлдааныг явуулах аргууд гэсэн байдаг.

Дэлхийн I дайн, иргэний дайнаас операцын урлагийг системтэй авч үзэж ирсэн бөгөөд 1919-1920 онуудад хуурай замын цэргийн операцын ерөнхий зарчмуудыг тодорхойлон гаргасан байна. Иргэний дайны туршлагаас Б.Барски, Н.Сулейман нар операцын ар тал, материал техникийн хангалтын тулгамдсан асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар судалж эхэлсэн байдаг. Харин А.Свечин, В.Новицки, А. Заянчковски, Н.Капустин, А.Базаревски, Н.Какурин болон В.Меликов нар гүнзгий, өргөн хүрээнд судалсан байна<sup>27</sup>. Мөн Герман, Францын дэлхийн I дайны туршлага, сургамжийн талаар дурдсан Лүдендорф, Фалкенхейн, Кулман нарын ажлыг орос хэлнээ орчуулж судалж эхэлсэн байна.

Операцын онолыг ихэвчлэн стратегийн асуудалд, цөөн тохиолдолд тактикийн асуудалд тусган авч үзэж ирсэн бөгөөд операцын удирдлага, операцын асуудал, операцын арга, техник, их хэмжээний армийн тактик, операцын стратегийн урлаг, операцын ажиллагаа зэргээр нэрлэж тэмдэглэж иржээ. Стратеги, тактикийн асуудлын аль алинд операцын онол хөндөгдөж холимог ойлголт төрүүлж байгаа байдал нь ихээхэн хүндрэл, маргааныг бий болгож ирсэн байна. Яваандаа жижиг хэмжээний арми дангаараа байлдааны ажиллагаа буюу операц явуулах, түүнд тэдгээрийн зэвсэглэл, хөдөлгөөн, ар тал, завсар, үзүүрүүдийг халхлах зэргийг багтаан ойлгож, операцыг явуулахдаа 2 хэсгээс бүрдүүлж ойлгож байсан бөгөөд эхний хэсэгт гол хүчийг ашигтай байрлалд байрлуулахын тулд маневр буюу хөдөлгөөн хийх, хоёр дахь хэсэгт гол байлдааны ажиллагааг хамруулан ойлгож иржээ.

Оросын цэргийн операцын урлагт үнэтэй хувь нэмэр оруулсан профессор А.Свечин 1924 онд “Цэргийн урлагийн талаарх ойлголт” гэсэн лекцийг Фрунзийн цэргийн академи дээр уншихдаа “Цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсэг болох стратеги, тактикийн ойлголт өнөө цагт хоцрогдож, ямар ч утга, учиргүй болоод байна. Үнэн хэрэгтээ энэхүү ойлголтоор явагддаг байсан байлдааны ажиллагаа ор мөргүй алга болоод байна” гэжээ<sup>28</sup>. Үүний дараахан М.Н. Тухачевскийгээр удирдуулсан судалгааны баг дайнд операцыг хэрхэн явуулах талаар судалж эхэлсэн байна.

АНУ-д операцын урлагийн асуудал анх 1982 онд хэвлэсэн ХЗЦ-ийн хээрийн дүрэм болох “Операц (байлдааны ажиллагаа) явуулах үндэс” (FM 100-5)<sup>29</sup>-д цэрэг (байлдаан)-ийн ажиллагаа нь: тактик, операц, стратеги гэсэн гурван түвшинд явагдана хэмээн тусгагдаж байжээ.

<sup>27</sup> Harold S. Orenstein. “Selected Readings in The History of Soviet Operational Art”. Fort Leavenworth, Kansas May 1990. Pg 10;

<sup>28</sup> Мөн тэнд Pg 12;

<sup>29</sup> FM 100-5. Operations, 1982;



XX зуунд дэлхийн хоёр том дайн, бүс нутагт улс хоорондын болон иргэний дайн олон улс оронд гарч цэргийн операцын урлагийн хөгжлийг огцом өөрчлөн шинэчилсэн үе байлаа. Дөрвөн арван жил үргэлжилсэн хүйтэн дайны үе дэх зэвсэглэл, цэргийн техник, технологийн хөгжил нь операцын урлагийг урьд өмнө үзэгдээгүйгээр өөрчлөгдөн хөгжих суурь, үндэс болж өгсөн байна. Операцын урлаг шинжлэх ухаан болж, цэргийн урлагийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг болж төлөвших үйл явц ийнхүү дууссан байна.

***Операцын урлаг нь тактикийн харьцуулахад, харьцангуй урт удаан хугацаанд явагдах цэргийн кампани, цэргийн байлдааны ажиллагаа, дараалсан хэд хэдэн тактикийн ажиллагааны үр дүнд биелэлээ олох зүй тогтолтой нийгмийн үзэгдэл, дайны үйл явцын нэгэн хэсэг, ай, төрөл, тусгай мэргэжлийн цэргийн нэгдэл болон тактикийн нэгтгэлийн нэгдмэл ажиллагаа, дараалсан ажиллагааны цогц юм.***


Үндэсний цэргийн операцын урлагийн онолыг хөгжүүлэх, практик ажиллагааг боловсронгуй болгохыг өнөө үеийн дэлхий дахинаа өрнөж буй дайн, байлдааны ажиллагааны туршлага, сургамж, Зүүн хойд Ази дахь цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн байдал нөхцөлдүүлж байгаа болохоос биш судлаач, мэргэжилтэн нарын хүсэл, зоригийн асуудал биш юм. Операцын урлагийн хөгжилд ач холбогдол бага өгөх, “манай үндэсний цэргийн урлаг нь үндэсний стратеги, тактикаас бүрдэнэ”, “манайд операц явуулах үндсэн нэгж - нэгдэл байхгүй” гэх зэрэг гэнэн ойлголт, практик үйлдэл гаргах нь арга зүйн хувьд алдаатай, практикийн хувьд уршигт үр дагавартай төдийгүй онолын үүднээс ч буруу юм.

Стратегийн давшилт, хориглолт гэсэн цэргийн шинжлэх ухааны категориор бол эдгээр нь хэд хэдэн дараалсан операцаар хэрэгждэг стратегийн операц юм. Стратегийн операц, армийн (армийн корпусын) операц нь далайц хэмжээ, хүч хэрэгсэл, цаг хугацааны хувьд ихээхэн ялгаатай ойлголтууд. Энэ тухай бид 2018 онд эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцэж, нэгэн сэдэвт “Операцын урлаг судлал” гэсэн бүтээл хэвлүүлсэн болно<sup>30</sup>.

***Цэргийн операцын урлаг бол цэргийн урлагийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Зэвсэгт хүчний ай, төрлийн цэргийн нэгдлийн хүч хэрэгслээр бие даан болон хамтран цэргийн операцад бэлтгэх, түүнийг нэгдсэн бодлого, төлөвлөгөөгөөр явуулах онол, практикийн хүрээний асуудлыг хамардаг цэргийн шинжлэх ухааны үндсэн судлагдахууны нэг юм. Үүнийг 1.1 бүдүүвч зургаас харж болох юм.***

---

<sup>30</sup> Операцын урлаг судлал. УБ., 2018 он. – 130 х; ISBN 978-99978-848-4-8;



1.1 дүгээр зураг. Цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн агуулга

Операцын урлаг цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсэг мөнийн хувьд түүнд тодорхой байр эзэлдэг, цэргийн шинжлэх ухааны танин мэдэхүйн тодорхой хүрээний асуудлыг диалектикаар нээн илрүүлж, практикт нэвтрүүлэх, иновацлах бүтээлч сэтгэлгээний үр дүн юм. Үүгээрээ байлдаж буй цэрэг төдийгүй цэргийг удирдаж буй хүмүүсийн оюун ухаан, мэдлэг, чадварын илэрхийлэл болдог.

Операцын урлаг дахь өнөөдрийн ялалт, ялагдал маргаашийн ялалтын үндэс болж, жинхэнэ агуулга нь тодорч, дайнд оролцогч өөрийн хүмүүсийн таашаал, урам зориг, эрч хүчийг сэргээж, сэтгэл хөдлөлийн эх сурвалж ч болдог талтай. Ялангуяа саатуулах, тогтоох, хориглох, давших, сөрөг давшилт хийх, тагнах, цохих, маневрлах, цэргийг удирдаж залах үйлдэл, хөдөлгөөн, арга ухаан нь ялан дийлэх урлагийн агуулгыг илэрхийлнэ.

Цэргийн урлаг бол “урлаг” хэмээх өргөн ойлголтын нэг хэсэг учир түүний агуулга, мөн чанар нь нийгмийн ухамсарын бие даасан хэлбэр, цэргийн алба хаагчдын нийгмийн онцгой үзэгдэл (зэвсэгт тэмцэл)-ийг танин мэдэх оюун санааны хөгжлийн онол, практикийн илэрхийлэл юм. Үүгээрээ *цэргийн урлаг цэвэр оюун санааны хийсвэр ухагдахуунаас гадна бодит байдлын мэдрэхүй дэх тусгал, бусдын мэдрэмж, ухамсарын нөлөөлөлд автагдаж байдаг онцлогтой юм.*

Өнөө үеийн операцын урлагийн шинж нь түүхэн цаг хугацаанд хувьсан өөрчлөгдөж байгаа нь хамгийн түрүүнд хөнөөх хэрэгсэл болох зэвсэглэл, хамгаалалтын болон хөдөлгөөн, маневрын хэрэгсэл, цэргийг удирдах, операцын байлдааны болон ар талын хангалтын хэрэгсэл, үйл ажиллагааны хурд, зохион байгуулалтаас хамаарч иржээ.

Хэд дэх үеийн зэвсэглэлтэй<sup>31</sup> улсуудын хооронд тухайн цэргийн операц явагдаж байгаагаас түүний шинж, агуулга хамаардаг.

Операцын урлагийн хөгжлийг оросын эрдэмтэн судлаачид хэд хэдэн үечлэлд хуваан үзсэн байдаг<sup>32</sup>. Мөн манай судлаачид ч монголын цэргийн урлагийн хөгжлийг ерөнхийд нь үечилсэн байдаг<sup>33</sup>. Мөн ОХУ-ын академич В.А.Золотаревын редакторласан “История военной стратегии России” бүтээлд оросын цэргийн стратегийн хөгжлийг мөн үечлэн авч үзсэн байна<sup>34</sup>. Эдгээр үечлэлийн арга зүйг удирдамж болгох юм бол манай үндэсний цэргийн *операцын урлагийн хөгжил дараах үечлэлтэй* хөгжсөн гэж үзэж болохоор байна:

*Нэгдүгээр үе* – өнгөрсөн зууны хориод оны төгсгөлөөс 40-өөд оны эхэн хэсгийг хамрах бөгөөд энэ үе бол монголд ардын хувьсгалын ялалт, бэхжилтийн он жилүүд юм. МАХЦ-т хуягт техник, онгоц нэвтэрч эхэлсэн юм. 1936 оны “хувьсгалын эсэргүү” ардын хөдөлгөөн, Халхын голын дайны Зөвлөлт-Монголын хамтарсан байлдааны ажиллагаа нь операцын онол, практик нэвтэрч эхэлсэн бодит үйл явдал болсон юм. “Түн операцын онолыг практикт анх ирээдүйн маршал Жуков 1939 оны наймдугаар сард Халхын голд Японы цэргийг бут цохих давших операцад амжилттай хэрэгжүүлсэн юм”<sup>35</sup> гэж оросын мэргэжилтнүүд үздэг.

*Хоёрдугаар үе* – дэлхийн II дайн, түүний дараах анхны он жил (1941-1953 он)-үүд бөгөөд энэ үе бол МАХЦ-ийг анх удаагаа дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулж, операц явуулах хэмжээний хүч бүрэлдэхүүнийг бэлэн болгосон, дэлхийн II дайны төгсгөлд явуулсан Зөвлөлтийн армийн Алс дорнод дахь чөлөөлөх дайнд оролцсон он жилүүд юм. МАХЦ нь Зөвлөлтийн Өвөр Байгалийн фронтын бүрэлдэхүүнд дийлэнх нэгтгэл, ангиудаа Монгол, Зөвлөлтийн цэргийн Өмнөд бүлгийн бүрэлдэхүүнд оролцуулсан<sup>36</sup> юм. Энэ үед давших операцыг явуулах, цохилтын үндсэн чиглэлд хүч хэрэгслийг төвлөрүүлэх, морьт болон мотомеханикжуулсан нэгтгэл, ангиудын хүчээр дайсны фронтын жигүүрээр маневрлах, дайсны ар тал, гүн дэх цэргийн бүлэглэлийг бүслэн устгах, Зөвлөлтийн нэгдэл, нэгтгэл ангиудтай харилцан ажиллагааг идэвхтэй явуулах зэрэг операцын ажиллагааг амжилттай

<sup>31</sup> М.И.Слипченко. Войны шестого поколения. т.27;

<sup>32</sup> Военная мысль № 11/2007, стр. 34-44. А.Н.Столяров. Становление и развитие теории и практики оперативного искусства в Военной Академии Генерального Штаба; Военная мысль № 12/2007, стр. 60-67. В.К. Копытко. Эволюция оперативного искусства;

<sup>33</sup> Хорьдугаар зууны Монгол цэрэг. т.196-230; Хорьдугаар зууны Монгол цэргийн урлагийн түүх. УБ., 2009 он. -240х;

<sup>34</sup> История военной стратегии России. /под редакцией В.А.Золотарева/. М., Кучково поле полиграф ресурсы. 2000.-592С; ISBN 5-86090-064-3;

<sup>35</sup> Г.С.Иссерсон. Новые виды борьбы (опыт исследования современных войн). М., 1940г. -144с;

<sup>36</sup> Монгол цэргийн түүхийн товчоон. (1911-1990-ээд он). Дэд дэвтэр. Т.363-382;

явуулсан түүхтэй. Дайны дараах он жилүүдэд дайны туршлага, сургамжаас суралцах, сургалт, цэргийн хээрийн сургуульд нэвтрүүлэх зэргээр операцын урлагийг хөгжүүлж байсан юм.

**Гуравдугаар үе** – дайны дараах “хүйтэн дайн”-ы он жил (1956-1980-аад оны сүүлч)-үүд бөгөөд энэ үе бол МАА морьт цэргээс мотомеханикжуулсан арми болж шинэчлэгдсэн, ерөнхий цэргийн арми (5А)-ийг байгуулсан<sup>37</sup>, цэргийн операцын онол, практикийг хөгжүүлсэн он жилүүд юм. Монголын цэргийн урлагт Зөвлөлтийн Армитай хамтран явуулах команд-штабын болон цэргийн хээрийн сургуулиуд олширч, цөмийн зэвсэг хэрэглэсэн болон хэрэглээгүй үеийн армийн операцын хэмжээний хээрийн сургуулиудаар операцын онол, практикийг хөгжүүлсэн юм. “Өвөр Байгалын цэргийн тойрог болон Монголд байрлаж байсан 39 дүгээр армитай хамтран нэлээд хэдэн жи, жил бүр урьдчилан тохирсон төлөвлөгөөний дагуу фронт, арми, дивизийн хүрээнд команд-штабын болон операц, тактикийн хээрийн сургуулийг янз бүрийн хэлбэрээр явуулж байв”<sup>38</sup>. Цөмийн хэрэгслийн стратегийн нөлөө дор цэргийн нэгдэл, нэгтгэлийн операцын цар хүрээн, далайц хэмжээ, дайсныг устгах арга, хэрэгсэлд томоохон өөрчлөлт орж байлаа.

**Дөрөвдүгээр үе** –бол ардчилсан хувьсгалын он жилүүд буюу монголын төр, нийгмийн байгуулалын их өөрчлөлтийн шилжилтийн цаг хугацааны он жил (80-аад оны сүүлчээс 90-ээд оны төгсгөл)-үүд юм. Монгол Улсын Зэвсэгт хүчнийг улс орны эдийн засгийн чадавх, олон улсын нааштай өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэх, хураангуйлах бодлого доор “цомхон, чадварлаг” болгох практик ажиллагааг хэрэгжүүлсэн үе юм. Энэ үед сонгодог утгаар цэргийн операц явуулах хүч хэрэгсэл багассан бөгөөд тийм хэмжээний операц явуулах шаардлага, хэрэгцээ ч багассан байлаа. Гэсэн хэдий ч “өөрийгөө хамгаалах” эрх ашгийн үүднээс цэргийн урлагийн хөгжилд анхаарч, сургалт, судалгааны ажлыг идэвхжүүлсэн байдаг. Сургалт, судалгааны олон бүтээл туурвил өрнөснийг өмнө тэмдэглэсэн. Цэргийн номлолын үндэс<sup>39</sup>, Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс<sup>40</sup> зэрэг бодлогын баримт бичгээр цэргийн шинжлэх ухааны судалгааны үндсэн чиглэлийг тогтоож, цэргийн урлагийг олон улсын цэргийн зэвсэглэл, техник, технологийн хөгжилтэй уялдуулахыг тогтоож өгсөн юм. Цэргийн ажиллагааны гол үндсийг хориглон хамгаалах, тогтоон барих, түйвээхэд чиглүүлж эхэлсэн байдаг.

**Тавдугаар үе** – бол шинэ ХХI зууны эхэн (2000 оноос хойш) үеэс хойших он жилүүд бөгөөд олон улс орны цэргийн зэвсэглэлд нэн өндөр цэцтэй зэвсэг нэвтэрч, Ойрх Дорнод,

<sup>37</sup> Монгол цэргийн түүхийн товчоон. (1911-1990-ээд он). Дэд дэвтэр. т.436;

<sup>38</sup> Монгол цэргийн түүхийн товчоон. (1911-1990-ээд он). Дэд дэвтэр. т.441;

<sup>39</sup> Монгол Улсын Их Хурлын 1994 оны 56 дугаар тогтоолын хавсралт. “Монгол Улсын Цэргийн номлолын үндэс”;

<sup>40</sup> Монгол Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт. “Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс” ;

Европын зарим улс оронд явагдсан бүс нутгийн болон орон нутгийн дайн байлдааны ажиллагаанд түүнийг өргөн хэрэглэж эхэлсэн цаг хугацаа юм. Цэргийн аюулын уламжлалт шинж өөрчлөгдөж, терроризмын шинэ аюултай дэлхийн бараг бүх улс орон тулгарах болж, хойд, урд хөршүүд тэдний эсрэг тэмцлийг нэлээд хугацаагаар явуулж эхэлсэн цаг үе юм. Мэдээллийн, эдийн засгийн (худалдааны) дайн хэмээн шинэ хэлбэрийн дайн үүсч, явагддаг боллоо. Батлан хамгаалах зорилго, үүрэг өргөжиж, улс орны аюулгүй байдлыг хангах бодлого, зорилтын салшгүй бүрэлдэхүүн хэсэг, түүн дотроо шийдвэрлэх нөлөөтэй нь боллоо. Монгол Улсын “Батлан хамгаалах бодлогын үндэс”<sup>41</sup> хэмээх баримт бичгийн УИХ баталж мөрдүүлж эхэллээ.

Энд дурдсан үндэсний цэргийн урлагийн хөгжлийн асуудал нь хэдийгээр тодорхой хүрээг хамаарч байгаа ч нийгмийн хөгжлийн бодит хуульд захирагдаж буй үзэгдэл юм. Нийгмийн болон үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин нь зэвсэгт тэмцлийг явуулах хүч, хэрэгсэлд шууд нөлөөлж байдаг бодит хууль, зүй тогтол үйлчилдэг.

Бас операц тус бүрийн агуулга тухайн операцын зорилго, үүргээс хамаарч байдаг. Жишээ татахад, 1998 онд Иракт явуулсан “Цөлийн үнэг” операц байна. Энэ операцын ил тодоор зарласан зорилго нь: Ирак үй олноор хөнөөх зэвсэг (ҮОХЗ)-ийг үйлдвэрлэж, олон улсын гэрээ хэлэлцээрийг зөрчиж байгаа тул ҮОХЗ -ийг нь болон түүнтэй холбоотой үйлдвэрлэлийн объект, нөөцийн агуулах, зөөвөрлөх хэрэгслийг нь устгах байв. Харин бодитой гэж үзэх зорилго нь: Ирак дахь улс төрөөс Хусейныг зайлуулах, Ойрх дорнодын бүс, Персийн булан дахь АНУ-ын нөлөөг цаашид бэхжүүлэхэд оршиж байжээ. Операцын үүрэг нь: нэгд, Иракийн аж үйлдвэр, дэд бүтэц, төр засгийн удирдлагад их хэмжээтэй хохирол үзүүлэх, түүн дотроо ҮОХЗ болон түүнтэй холбоотой үйлдвэрлэлийн объект, нөөцийн агуулах, зөөвөрлөх хэрэгслийг устгах; хоёрт, Иракийн Ерөнхийлөгч С.Хусейны нэр төрийг унагаах, арабын социалист сэргэн мандалын намын нөлөөг сулруулах, дотоод дахь сөрөг хүчнийүйл ажиллагааг идэвхжүүлэх байжээ.

Харин операцын агуулга нь: агаарын давших операц; тусгай операцын хүчний тагнуул-хорлон сүйтгэх ажиллагаа; мэдээлэл-сэтгэл зүйн тэмцлийн арга хэмжээ; Кувейт болон Саудын Араб дахь АНУ-ын хуурай замын цэргийн бүлэглэлийн байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэхэд оршиж байжээ.

XX зууны төгсгөл, XXI зууны эхээр явагдаж буй цэргийн операцуудын цэрэг-улс төрийн агуулгын шинжийг танин мэдэхэд хүндрэл оршсоор байна. Энэ нь эдгээр операц нэгд, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэргүй явагдаж байсан, хоёрт, цэргийн хүч хэрэглэх шалтгаан, операц явуулах зорилгын талаарх мэдэгдэл нь мэдээллийн халхавч доор

---

<sup>41</sup> Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт. “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”;

явагдаж байсан учир довтлогч талын бодит шалтгаан, зорилгоос ялгаатай байсан зэргээс болж тухайн операцуудын цэрэг-улс төрийн агуулга, түүний шинжийг танин мэдэхэд хүндрэл учирч байсан юм. Үүний нэг жишээ бол Америкийн цэргийн шинжээчид агаарын цэргийн хүчинд байлдааны хүчирхэг нисэх онгоц, нисдэг тэрэг буй болсноор Иракийн дайн (1991)-ы явцад Дуэ-гийн “Агаарын дайны номлол” -ыг цэргийн хэрэгт нэвтүүлж эхэлсэн байна. Дуэ-гийн “Агаарын дайны номлол”-д ирээдүйн дайн, операцад зөвхөн агаарын цэргийн хүчнээр ялалтад хүрэх санааг дэвшүүлэхдээ дайсны хотуудад агаараас онгоцны бөөгнөрүүлсэн цохилт хийх санаа юм. Дуэ 1921 онд “Агаарт ноёрхох” нэртэй бүтээлдээ үүнийгээ дэлгэрүүлсэн байна. Персийн булангийн дайнд байлдааны ажиллагааны театрын нэн тааламжтай нөхцөл, Баруун Европын өндөр хөгжилтэй улсуудын цэргийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр Америкийн хүчирхэг цэргийн нисэх хүчний бүлэглэл агаарын цэргийн операцыг амжилттай явуулсан юм. Ийнхүү “Дайсны агаарын цэргийн хүчнийг устгаж чадсан улс ялалт байгуулна” гэсэн Дуэ-гийн номлолын үзэл санааг батлагдсан байна. Тэр үед Америкийн Штабуудын дарга нарын нэгдсэн хорооны орлогч дарга адмирал Уильям Оуэнс сансарын хиймэл дагуул, далайн хөлөг онгоц, агаарын нисэх хэрэгслүүдэд байрлуулсан төрөл бүрийн хэрэгслээс хүлээн авсан мэдээллийг боловсруулан байлдааны ажиллагааны аль ч театрт байгаа ямар ч байг найдвартай хөнөөж болох тухай бичиж байв.

1998 онд Иракт явуулсан “Цөлийн үнэг” операц бол бас нэг жишээ болох юм. Үүнтэй адил “Иркийн эрх чөлөө” –ҮОХЗ-ийг хэрэглэх Иракийн аюулыг арилгах; “Нугаршгүй эрх чөлөө” –Аль-Каидын террорист бүтцийг устгах; “Холбоотны хүч” - Косовогийн албанчуудын эрхийг хамгаалах гэсэн ил тод мэдэгдэл нь Персийн булан дахь стратегийн нэн чухал бүс нутаг, түүний нефтийн нөөцөд өөрийн хяналтыг бүрэн тогтоох; Төв Ази дахь бусад улс орны нөлөөг багасгах, АНУ-ын түүнд нэвтрэх боломжийг тогтоох; Балакан дахь НАТО, АНУ-ын ноёрхлыг бэхжүүлэх, НАТО-гийн Зэвсэг хүчний хариуцлагын бүсийг нэмэгдүүлж, хяналтаа тогтооход гэсэн бодит зорилгыг нуун далдалж байлаа.

Цэргийн операцын урлаг, түүний үүсэл, хөгжлийн тойм, олон улс болон ОХУ-ын судлаачдын сүүлийн үеийн бүтээл, туурвилаас<sup>42</sup> харахад, XX зууны дэлхийн цэргийн урлаг түүн дотроо операцын урлаг зэвсэглэл, техник, технологийн хөгжил дэвшилд тулгуурлан хувьсан өөрчлөгдөж байгаагийн зэрэгцээ улс төрийн бодлогыг хэрэгжүүлэгч гол хэрэгслийн нэг болсон хэвээр байна.

---

<sup>42</sup> Военная мысль № 11/2007, стр. 34-44. А.Н.Столяров. Становление и развитие теории и практики оперативного искусства в Военной Академии Генерального Штаба; Военная мысль № 12/2007, стр. 60-67. В.К. Копытко. Эволюция оперативного искусства;

Өнгөрсөн зууны цэргийн операцын урлагийн хөгжилд шинжилгээ хийнэ гэвэл энэхүү бүтээлийн зорилго, агуулгаас ихээхэн хөндийрэхэд хүрэх тул XX зууны сүүлийн хорь гаруй жилийн хүрээгээр асуудлыг хязгаарлаж, нэн хураангуйлан шинжилж үзье.

Цэргийн урлаг дахь операцын урлагийн хөгжлийн дөрөвдүгээр үе (80-аад оны дундаас 90-ээд оны төгсгөл)-д ЗХУ (ОХУ), АНУ-ын хооронд цөмийн зэвсгийг хязгаарлах талаар хэд хэдэн удаагийн гэрээ, хэлэлцээр явагдсан; ОХУ болон социалист гэгдэж байсан улсууд (түүн дотор Монгол Улс багтана)-ын батлан хамгаалах стратеги нь хориглон хамгаалах талдаа болсон; АНУ тэргүүтэй НАТО-гийнхон нэн өндөр цэцтэй зэвсгийг стратегийн операц, операцад ашиглаж эхэлсэн зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч цэргийн операцын урлагийн олон асуудлыг шинээр авч үзэхийг шаардсан юм. Ялангуяа, дайсны түрэмгийллийг няцаах үндсэн стратеги болох хориглох операцад бэлтгэх, түүнийг явуулах болон сөрөг давшилт хийх, давших операц, байлдааны ажиллагаа явуулж эхлэх үеийн онол, практикийг хөгжүүлэхэд голлон анхаарч байлаа.

Операцын урлагийн онол, практикт дайсны түрэмгийллийг няцаах үндсэн хэлбэр болох хориглох операцад бэлтгэх, түүнийг явуулах асуудалд 1980-аад оны төгсгөлөөс илүүтэй ач холбогдол өгч эхэлсэн байна. Давших байлдаан, операцын үндсэн хэлбэр нь сөрөг давшилт хийх операц, байлдаан байна гэж үзэж байв. Үүнтэй зэрэгцээд шууд хариу үйлдэл үзүүлэх хүчин, “хариу шуурхай үзүүлэх хүчин” байгуулах, ашиглах үзэл баримтлалыг боловсруулж эхэлсэн байна. Шинэ зэвсэглэл, цэргийн техник цэргийн хэрэгт нэвтрэх (нэн өндөр цэцтэй зэвсэг, тагнуул-цохилтын цогцолбор, нисэгчгүй нисэх аппарат, тагнуул, удирдлага, радио-цахим тэмцлийн автоматжуулсан систем, хэрэгсэл, түүнчлэн физикийн шинэ зарчимд үндэслэсэн зэвсэг)-ийн хэрээр дайсны цэргийн операцын байгууламжийн гүн дэх цэргийн бүлэглэлийг нэгэн зэрэг хөнөөх боломж нь дээшилсэн байна.

Олон улсын хэмжээнд, операцын урлагт дайсны пуужинт зэвсгийн довтолгооноос сэргийлэх, агаар-сансрын болон пуужингийн довтолгооныг илрүүлэх, зарлан мэдээлэх асуудал нэгдүгээр эрэмбэд тавигдаж эхэлсэн байна. Дайсны агаар (онгоц, пуужингийн)-ын довтолгооны болон агаар-сансрын хэрэгслийн довтолгооныг эсэргүүцэн тэмцэх арга, хэрэгслийг хөгжүүлж эхэлжээ. Операцын урлагийн хөгжилд дайсны агаарын довтолгооны хэрэгсэлтэй тэмцэх нэг чухал хэлбэр нь агаарын операц, Цэргийн Нисэх Хүч (Агаарын хүчин)-ний нэгдлийн байлдааны бие даасан болон хамтарсан ажиллагаа болж байлаа. Цэргийн зэвсэглэлд цоо шинэ авиацын болон агаарын довтолгооноос хамгаалах цогцолбор, автомажуулсан хэрэгслээр хангагдсан удирдлагын систем бий болсон нь ЦНХ (АХ, АЦ) болон операцын урлагийн хөгжлийг нөхцөлдүүлж өгч байлаа. Авиацын бие даасан болон бусад ай, төрлийн цэрэгтэй хамтран агаарын болон АДХ операц явуулах боломж нь дээшилсэн байна. Хуурай замын цэргийг дэмжих авиацын үр өгөөж ч сайжирчээ. Фронтын

авиацын болон армийн авиацын дайсныг галаар хөнөөх, цэргийн тээврийн авиацын агаарын десантын операцыг хангах, шууд хариу үйлдэл үзүүлэх хүчин болон хариу шуурхай үзүүлэх хүчнийг тээвэрлэн буулгах үүрэг, тэдгээрийн багтаамж эрс өргөжижээ. Цэрэг (хүчин)-ийн маневрын ач холбогдол өсөхийн хэрээр агаараар шилжин байрлах цэргийн ач холбогдлол нэмэгдэж, шуурхай байдлыг хангах, галын цохилтын үр дүнг түргэн ашиглах, алс зайд цэргээ хурдан шилжүүлэн байршуулах илүүтэй боломжийг олгох болжээ.

Операцын урлагийн онолд ЗХ-ний ай, төрлийн цэргийн нэгдэл, нэгтгэлийн харилцан ажиллагааг зохион байгуулах, дэмжих асуудал мэдрэгдэхүйц хөгжжээ. Тагнуул, радио электрон тэмцэл болон цэргийн удирдлагын автомажуулалтын систем нь цэргийн байлдах чадварыг илэрхийлэгч нэг үзүүлэлт болж, операц, байлдааны ажиллагааны явц, төгсгөл (үр дүн)-д нэлээд тохиолдолд шийдвэрлэх нөлөө үзүүлэх түвшинд хүрсэн байна. Операц, байлдааны ажиллагааны үр өгөөжид мэдээллийн хангалтын нөлөө ихсэж, улмаар мэдээллийн дайны шинж чанарыг агуулах болжээ. Операц, байлдааны ажиллагааны төлөвлөлт, галын хөнөөл, радиоэлектрон даралт зэрэгт мэдээллийн шинэ системийг нэвтрүүлсэн явдал нь бодит цагт тэднийг хэрэгжүүлэх боломжийг олгодог болжээ.

Цэргийн зэвсэглэлд шинэ үеийн нэн өндөр цэцтэй зэвсэг нэвтэрч байгаа нь операцыг шинэ аргаар явуулахыг нөхцөлдүүлж байна. Зэвсэглэлд шинэ зэвсэг нэвтэрснээр операцын шинж чанарыг зөвхөн өөрчилж буй төдийгүй, энэ шинэ зэвсгийг хэрэглэж буй цэргийн нэгдэл, нэгтгал, ангийн бүтцийн өөрчлөлт ч нөлөөлж байна. Идэвхтэй операцын ажиллагаанд цэргийн тагнуулын болон радиоэлектрон тэмцлийн ажиллагаа, хамгаалах, өнгөлөн далдлах арга хэмжээ зэрэг уламжлалт хангалт улам бүр чухал болсоор байна. Операцын шинж чанарын өөрчлөлтөд давших ба хориглох байлдааны хоорондын, орон зай, цаг хугацааны хоорондын, улмаар хөнөөл учруулах шинж чанар ба манёвр хийх арга хоорондын үндсэн харьцааг ч өөрчилж байна.

Цэргийн түүхээс жишээ татаж үзье. Германы зэвсэгт хүчин 1940 онд танкаар тооны хувьд ч, чанарын хувьд ч Английн болоод Францынхаас давамгайл байгаагүй хэрнээ тэдний зэвсэгт хүчнийг ялан дийлсэн байдаг. Үүний учир нь Германы цэргийн командлал байлдаан явуулах операцыг иж бүрэн үзэл баримтлал боловсруулан мөрдөж байжээ. Энэхүү үзэл баримтлалд нэгд, цэргийн салбарын зохион байгуулалтад өөрчлөлт оруулсан, хоёрт, цэргийг удирдах практикт шинэчлэл хийсэн, гуравт, танкийг холбооны хэрэгслээр хангасан явдал байлаа гэж цэргийн түүхчид үздэг юм.

## **§ 1.2. Тактикийн урлагийн хувьсал, өөрчлөлт**

Тактик бол цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсэг юм. Байлдааны ажиллагааг бүх талаас нь судалж, тулалдааныг шийдвэрлэхэд ашигладаг шинжлэх ухаан бол тактик юм. Тактик нь



цэргийн урлагийн доод шатны асуудал буюу ай, төрөл, тусгай мэргэжлийн цэргийн нэгтгэл, анги, салбаруудыг байлдаанд бэлтгэх, түүнийг явуулах онол, практикийн асуудлыг хамаардаг цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэр нь стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үндсэн арга нь болдог<sup>43</sup>.

Дайны суут онолч К.Клаузевиц: “Дайн бол байлдаан хэмээх цорын ганц хэрэгсэлтэй зүйл”<sup>44</sup> гэж дайны онолыг байлдааны онолгүйгээр төсөөлөх нь утгагүй болохыг баталсан байдаг. Мөн цэргийн онолч А.Жомини: “Стратеги бол армийн ажиллагааны бүсэд байлдааны үүрэг амжилттай биелэх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлдэг. Гагцхүү эрс шийдэмгий бөгөөд ухаалаг, амжилттай тактик л байлдааныг ялалтад хүргэдэг”<sup>45</sup> хэмээн дайны урлагт байлдааны урлаг чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг тодотгосон байна.

Монголын цэргийн урлаг эрт дээр үеэс тактикийг хөгжүүлж ирснийг дэлхийн стратегитчид, цэргийн судлаачид олонтоо тэмдэглэсэн байдаг. Бжезинский.З “Шатрын аварга хөлөг” номондоо: “Монголын эзэнт улс нь түрэмгийллийн явцад цэргийн шилмэл тактик хэрэглэхийг уусан нийлэхээс үл цэрвэх явдалтай хослуулах аргаар засаглалаа хэрэгжүүлж байсан”<sup>46</sup> гэж дүгнэсэн нь Монголын цэргийн урлагийн тухайн үеийн хөгжил нь тактикийн өндөр түвшинд хүрч байсныг илэрхийлж буйн нэг илрэл юм. Үнэхээр тактикийн арга ажиллагааны мөн чанарыг монголчууд зөв ойлгож, энэ нь ялалт байгуулахад шаардлагатай нөхцөл, байдлыг өөрийн цэрэгт буй болгоход оршдог болохыг танин мэдсэн байжээ. Иймээс монгол цэргийн тактикийн ажиллагаа нь дайснаас давуутай чөлөөтэй, илүү боломжтой, илүү нөхцөлтэй, дайснаа аргагүй байдалд оруулсан байхад чиглэж байсан юм.

XX зууны үеийн Монголын цэргийн урлагийн онолын үндэс нь хуурай замын цэргийн байлдааны сонгодог тактик юм. Гэхдээ сонгодог тактикийн онол нь бүхэл зууны орон зайг эзлээгүй. Өөрөөр хэлбэл энэ зууны Монгол цэргийн урлагийн хөгжлийн асуудлыг тодорхой зааг ялгаатай судлах шаардлагатай юм. Энэхүү шаардлагад нийцэх судалгааны арга зүйн үндэслэлийг манай цэргийн түүхч эрдэмтэд “Монгол цэргийн түүхийн товчоо” номондоо боловсруулж, Монгол цэргийн шинэхэн түүхийг судлах үечлэлийг тогтоосон байна<sup>47</sup>.

**XX зууны хоёрдугаар хагасаас цэргийн тактикийн урлаг өвөрмөц онцлогтой хувьсан хөгжиж эхэлсэн байна.** Дэлхийн II дайнаас хойш 250 гаруй зэвсэгт мөргөлдөөн, орон нутгийн дайн явагдсан байна. Эдгээрээс нэлээд тоймтойг нь нэрлэвэл: Солонгосод (1950-1953 он), Вьетнамд (1945-1975 он), Ойрх Дорнодод (1967, 1973, 1982 онуудад), Фолклендын аралд (1982 он), Афганистанд (1979-1989 он, ), Персийн буланд (1991 он), Чеченид (1994-

<sup>43</sup> ВЭС.т.724;

<sup>44</sup> К.Клаузевиц. О войне. т.147;

<sup>45</sup> А.Жомини. А.Жомини. “Очерки военного искусства”. Москва. 1939. – ; т.3;

<sup>46</sup> Бжезинский.З. “Шатрын аварга хөлөг”. УБ. 2003. ШУА. -232х; т.20;

<sup>47</sup> Монгол цэргийн түүхийн товчоон. Тэргүүн дэвтэр. т.9;

1996 он, 1999- 2000 он), болсон дайн, зэвсэгт мөргөлдөөнийг нэрлэж болно. Эдгээр дайн, зэвсэгт мөргөлдөөн ямар нэг хэмжээгээр тактикийн урлагийн хөгжилд нөлөө үзүүлж ирсэн юм. Тактикийн урлагийн хөгжилд 1950-аад оноос 1980 –аад оны зэвсэгт тэмцлийн хэрэгслийн хөгжил нөлөө үзүүлсэн байдаг. Үүнийг дараах хүснэгтэд хураангуйлан үзүүлэв.

1.2 дугаар хүснэгт

Орон нутгийн дайн дахь зэвсэгт тэмцлийн хэрэгсэл,  
цэргийн тактикийн ажиллагааны хөгжил

| Зэвсэгт мөргөлдөөн, орон нутгийн дайн: | Онцлог шинж нь:                                                                                | Хэрэглэсэн шинэ зэвсэг нь:                                                                                       | Тактикийн ажиллагааны шинэ арга, хэлбэр нь:                                                                                                                                          |
|----------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Солонгос дахь дайн (1950-1953 он);     | Саяар тоологдох цэргийн хүчээр байр эзэлж тэмцлийг явуулсан;                                   | Тийрэлтэд онгоц, нисдэг тэрэг, ухралтгүй их буу, удирдлагат сум-онгоц, напалм, бактериологийн зэвсэг хэрэглэсэн; | Агаар, далайгаас десант буулгах, нисдэг тэргийг тагнуул явуулах, гал явуулахад чиглүүлэг өгөхөд болон дайсны ар талд десант буулгахад (дайсныг агаараар тойрон бүслэхэд) хэрэглэсэн; |
| Вьетнам дахь дайн (1964-1975 он);      | Байлдааны ажиллагаа голомтын шинжтэй явагдсан; Анги, салбарууд бие даасан ажиллагааг явуулсан; | Байлдааны нисдэг тэрэг, ТЭУП “ТОУ”, удирдлагат бөмбөг, сөнөөн-дайрөгч авиац, химийн зэвсэг хэрэглэсэн;           | Агаарын хөдөлгөөнт ажиллагааны тактик, Тактикийн “тойрог”, “хосолсон үсрэлт”, “шугаман”, “алх ба дөш” зэрэг ажиллагааг хэрэглэсэн;                                                   |
| Араб-Израилийн дайн (1973 он);         | Байрын ба маневрын ажиллагааг хослуулсан;                                                      | Зенитийн удирдлагат пуужин, Зенитийн пуужинг удирдах цогцолбор, ТЭУП-г олноор ашигласан;                         | Танк, танк эсэргүүцэх удирдлагат пуужингийн хоорондын онгоц, зенитийн удирдлагат пуужин хоорондын                                                                                    |

|                                                                                           |                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                           |
|-------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                           |                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                            | тэмцэл өрнөсөн;<br>Хориглолтод танк<br>эсэргүүцэх галын<br>уутыг байгуулсан;                                                                                                                                                                              |
| Афганистан дахь<br>дайн 1979-1989<br>он);<br>Персийн<br>булангийн дайн<br>(1990-1991 он). | Байлдааны<br>ажиллагааг голомтод<br>шинжтэй явуулсан;                                                              | Онгоц, нисдэг<br>тэрэгний байлдааны<br>удирдлага,<br>“фаланга”, “Штурм”<br>загварын ТЭУП,<br>РЭТ-ийн хэрэгсэл,<br>идэвхит МТС,<br>“Стингер” ЗЭПЦ,<br>огнемёт,<br>ЗБТС ПЗРК<br>«Стингер».<br>Огнеметы, ЗБТС,<br>БМП-2. Системы<br>ДММ ашигласан;            | Байнгын бус цэргийн<br>байгууллагатай<br>тэмцсэн; тагнуул-<br>цохилтын, туршуулын,<br>агаар-десантын<br>ажиллагааг явуулсан;<br>галын дайралт, отолтыг<br>ние их хийсэн; Тусгай<br>операцад оролцсон;<br>Минэ-ийн дайныг<br>явуулсан.                     |
|                                                                                           | Байлдааны<br>ажиллагааг: “газар-<br>агаарын шинж”-тэй,<br>операцын бүх гүнд<br>дайсныг хөнөөх<br>шинжтэй явуулсан; | “Джисак” загварын<br>ТУЦ, РЭТ-ийн<br>агаарын хэрэгсэл,<br>радиолокацын<br>альсын<br>илрүүлэлтийн<br>систем, “Пионер”<br>нисэгчгүй нисэх<br>аппарат (ННА),<br>тактикийн<br>нэгжүүдэд сансрын<br>тагнуул, холбоо,<br>чиглүүлгийн<br>хэрэгслийг<br>ашигласан; | РЭТ-ийн хэрэгслийг<br>авиацтай хослуулан үй<br>олноор хэрэглэсэн;<br>туршуул, агаарын<br>дайралт, тагнуул-<br>цохилтын ажиллагааг<br>ССО-ийн ажиллагаатай<br>хослуулсан; Дайсны<br>хориглолтын гүнд<br>идэвхтэй ажиллагааг<br>явуулагч фронтыг<br>нээсэн; |

*Тайлбар: ТЭУП (ПТУР) – танк эсэргүүцэх удирдлагат пуужин; РЭТ (РЭБ)-радио электрон тэмцэл; ЗЭПЦ (ПЗРК) – зенит эсэргүүцэгч пуужин цогцолбор; ЗБТС (РСЗО) – зенитийн бууны тийрэлтэд сум; ТУЦ (РУК) – тийрэлтэд удирдлагат цогцолбор; ННА (БПЛА); Системы ДММ (ССО);*

Дэлхийн II дайн дууссан цагаас хойш тавхан жил өнгөрсөн ч зэвсэгт тэмцлийн материаллаг бааз ихээхэн бэхжиж, шинэ зэвсэг цөөн бусаар зэвсэглэлд нэвтэрч, Солонгосын хойг дахь 1950 онд эхэлсэн дайнд тэдгээрээс нэлээдийг нь ашиглагдсан байна. Тухайлбал: залуур сум-онгоц; сэнст хөдөлгүүрт онгоцноос 2 дахин хурдтай тийрэлтэд хөдөлгүүрт онгоц; шатаах хэрэгсэл (напалм); ҮОХЗ-ийн зарим нэг төрөл (бактериологийн болон химийн зэвсэг). Цэргийн техникийн хөгжил нь байлдааныг явуулах тактик, аргад нөлөөлж, нисдэг тэргээр дайсныг агаараар тойрох тактик шинээр гарч ирсэн; “хонгил (туннельная оборона)-ын хориглолт”; далайн десант; тагнуул-хорлон сүйтгэх ажиллагаа урд өмнөхөөс улам их далайц, өргөн цар хүрээтэй явагдсан байна. Энэ нь зэвсэглэл, цэргийн техникийн хөгжил нь зэвсэгт тэмцлийг явуулах арга, хэлбэр, тактикт нөлөөлдөг зүй тогтлыг тодруулан харуулсан байна. Энэ зүй тогтлыг Вьетнамд явагдсан дайн улам тодорхой харуулсан байдаг. Энэ дайнд: зенитийн удирдлагат пуужин (ЗРК); онгоцны удирдлагат бөмбөг; “Шрайк” хэмээх авиацийн өөрийгөө залах пуужин; эзэлхүүнт үйлчилгээтэй тэсрэх галт хэрэгсэл; цаг уур болон геологийн дайны шинэ хэрэгслүүдийг шинээр ашигласан байна. Энэ нь байлдааны ажиллагааг илүү шийдэмгий, хурцадмал байдалд явуулахыг нөхцөлдүүлсэн байна. Вьетнамын дайнд олон зориулалт бүхий нисдэг тэргийг үй олноор хэрэглэсэн явдал нь цэргийн ажиллагаанд агаарын хөдөлгөөнт чанар хэмээх шинэ зарчмыг үүсгэж бий болгожээ. Дэлхийн цэргийн урлагт хуурай замын цэргийн байлдааны ажиллагааны нэг шинэ хэлбэр – агаарын операц (аэромобильные операции) үүсэн хөгжих үндэс болжээ. Энэ агаарын дивиз (аэромобильная дивизия) нь улмаар Америкийн армид шинэ бүтцийн нэгж - агаарын довтолгооны дивиз (воздушно-штурмовые дивизии) байгуулах үндэс болсон байна. Байлдааны талбарт байлдааны нисдэг тэргүүдийг өргөн хэрэглэсэн явдал нь хуурай замын цэргийг байлдааны талбар дээр нисдэг тэргэнээс дэмжих галын бэлтгэлийн шинэ аргыг нэвтрүүлэх эхлэлийг тавьсан байна. Вьетнамын дайн армийн авиацийн - нисдэг тэрэгний, хөнгөн онгоцны, нисэгчгүй нисэх аппаратын хөгжилд шинэ түлхэц өгсөн байна. Нисдэг тэрэгний зэвсэглэлд “агаар-агаар” ангиллын пуужин, танк эсэргүүцэх залуурт пуужин (ПТУРС) нэвтэрч, радио электрон тэмцэл (РЭТ)-ийн хэрэгсэл, цель заагч, тагнуулын хэрэгсэл улам боловсронгуй болж, нисдэг тэрэгний ашигтай даац, хамгаалалт нь дээшилж, “буудлаа-мартлаа” гэх байлдааны ажиллагааны зарчим, үзэл баримтлал хөгжих үндэс тавигдсан байна.

Ойрх дорнод дахь зэвсэгт мөргөлдөөн (1967, 1973, 1982 онуудын)-нд цөөн тооны бус шинэ зэвсэг, цэргийн техникийг туршсан байдаг. Боловсронгуй болгосон, илүү сайн зэвсэглэлээр иж бүрдэл хийсэн хэрэгсэлтэй танк, артиллери, авиац бүхий нийтийн хуурай замын армийг өргөн оролцуулсан байна. Эдгээр зэвсэгт мөргөлдөөнд авиацын удирдлагат пуужин (ЗУР, танк эсэргүүцэх залуурт пуужин (ПТУРС) -г өргөн хэрэглэсэн бөгөөд тэдгээрийн бүтэмж асар өндөр байсан учраас ялангуяа, 1973 оны зэвсэгт мөргөлдөөнийг “танкийн эсрэг ПТУРС-мйн дайн” гэж нэрлэх хэмжээнд хүрсэн байна.

Далаад онд явагдсан зэвсэгт мөргөлдөөнд хуяг нэвтлэгч сум, хуягийг сайжруулах өрсөлдөөний үр дүнг харуулж байсан юм. Үүнд танк эсэргүүцэх шинэ хэрэгсэл давамгайл байдлаа илүүтэй илэрхийлж байлаа. Тухайлбал, Араб-Израилийн 1967 оны дайнд танкийн хохирол 36 хувь байсан бол, 1973 оны дайнд 51 хувь, 1982 оны дайнд 80 хувь хүртэл өссөн баримт байдаг<sup>48</sup>.

Орон нутгийн өмнөх үеийн нэг дайнаас дараагийн дайнд шилжихэд шинэ төрлийн зэвсгийн системийг ашиглах нь улам бүр олширч ирсэн байдаг. Жишээ нь: Америкаас Солонгост явуулсан дайнд – 9; Вьетнамын дайнд - 25; Ойрх Дорнодын дайнд - 30; Персийн булангийн дайнд – 100 орчим шинэ зэвсэг, байлдааны техникийг америк хэрэглэж, чанарын хувьд эрс өөрчлөлт хийж, сайжруулсан байна<sup>49</sup>. Энэ шинэ зэвсэг, байлдааны техникт: “үл үзэгдэгч” онгоц; лазераар өөрөө чиглэл, залуурга авагч авиацын бөмбөг; радиолокац эсэргүүцэгч шинэ пуужин; тэсрэлт нь багтаамжит үйлчилгээтэй (вакуумное оружие) галт хэрэгсэл; далайн байршлаас хөөргөгч далавчит пуужин; тагнуул-цохилтын цогцолбор; радиоэлектрон тэмцэл (РЭТ)-ийн онгоц багтаж байлаа. Энэ үеэс сансрын хэрэгслийг байлдааны ажиллагааны талбарт ашиглаж, байлдаж буй цэрэг стратеги, операцын төдийгүй тактикийн үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг болж эхэлсэн байна. Энэ сансрын хэрэгсэл нь үндсэндээ Америкийн тагнуулын техник хэрэгсэл байлаа. Америк, зэвсэгт мөргөлдөөн, орон нутгийн дайны туршлага, сургамжаас нэн өндөр цэцтэй зэвсэг (НӨЦЗ)-ийг улам бүр хөгжүүлэхэд чухал ач холбогдол өгдөг болсон байна. Вьетнамын дайн түүний эхлэлийг тавьсан бөгөөд НӨЦЗ-ийг дараа дараагийн дайнд улам бүр их хэрэглэж ирсэн юм. Үүнийг дараах баримт нотлон харуулдаг. Тухайлбал: “Цөлийн шуурга” операц (1991 оны)-д удирдлагат бөмбөг нь бүх хэрэглэсэн авиацын бөмбөгийн 8 хувийг эзэлж байсан бол, долоон жилийн дараах Ирак дахь “Цөлийн үнэг” (1998 оны) операцад удирдлагат бөмбөгийн хэрэглээн нь 70 хувь хүртэл; Югослав дахь “Айлган сүрдүүлэх хүч” операцад америкийн НӨЦЗ-ийн хэрэгсэл 90 хувьд хүрсэн байна<sup>50</sup>. Ийнхүү хэт хөнөөл үзүүлэгч шинэ хэрэгслийг

<sup>48</sup> И.Н.Воробьев. Тактика – искусство боя. М., 2002. – 863с; - т.52;

<sup>49</sup> Чудо оружия.

<sup>50</sup> И.Н.Воробьев. Тактика – искусство боя. М., 2002. – 863с; - т.53;

зохион бүтээж хэрэглэхийн хамт зэвсэгт мөргөлдөөний явцад “сонгодог” төрөл, мэргэжэл (артиллери, танк, мотобуулагын цэрэг)-ийн цэргийн хэрэглээ, тэдний байлдааны ажиллагаа улам бүр боловсронгуйжиж иржээ. Тухайлбал, зэрэг (залп)-ийн галын тийрэлтэт сум (ЗГТС)-ны байлдааны бүтэмж нь буудлагын цэц нэмэгдсэн, байлдааны кассетад хэсгийг чиглүүлэх, хэрэглэх тоо нэмэгдсэн зэргээс хамаарч хоёр дахин өссөн байна. Авиаци болон ЗГТС-ыг газар орныг зайнаас минэжүүлэхэд ашигласнаар дайсанд үзүүлэх нөлөөллийн бүтэмжийг дээшлүүлсэн байна. Гол төмөрт артиллерийн буудлагын тусгал бүтэн хагас (1,5) дахин, харин бүлэг болон ганц целийг дарах түүний боломж нь хоёр дахин өсжээ. Үүний үрээр байлдааны ажиллагааны амжилтыг хангах зайлшгүй нөхцөл нь үргэлжилсэн галын байлдаан болжээ. Гэвч ойрын зайн байлдаан өөрийн ач холбогдлоо хараахан алдаагүй бөгөөд зөвхөн зэвсэгт мөргөлдөөнд илүүтэй хэрэглэгдэх болсон байна. Ийнхүү байлдааны ажиллагаанд НӨЦЗ-ийн гүйцэтгэх үүрэг өссөнөөр “алсын зайн” байлдаан хэмээн нэр томъёо хэрэглэгдэх болсон юм. Лазерын системт чиглүүлэг бүхий артиллерийн удирдлагат сум зохион бүтээж, хэрэглэсэн явдал нь танкийг хөдөлгөөнд нь, алс зайнаас анхны сумаар онож устгах боломжийг бүрдүүлжээ.

Афганистан дахь байлдааны ажиллагааны явцад Зөвлөлтийн цэрэг зарчмын хувьд “хэвийн бус” шинжтэй байлдаантай тулгарсан байдаг. Энэ нь дайсан болох байнгын бус зэвсэгт байгууллагатай, тэдний партизаны тактикийн ажиллагаатай тэмцэх, байлдааныг явуулахад суралцах явдал болж байлаа. Юуны өмнө, байлдааны хүнд техник уулархаг, цөлөрхөг, зам харгуй багатай, усгүй, тоосжилт ихтэй, ихээхэн халуун газар оронд голомтлог шинж чанартай байлдааны ажиллагааг явуулахад ашиггүй болохоо харуулсан байна. Тиймээс мотобуудлагын дивизийн зохион байгуулалтын бүтцийг өөрчлөх шаардлагатай болж байжээ. Мотобуудлагын дивизийг бүрэн бүтэц, бүрэлдэхүүнээр нь ашиглах явдал нэн ховор тохиолдож байсан бөгөөд танкийн хороог ч хаа сайгүй хэрэглэх боломж ч байхгүй байжээ.

“Байлдааны талбар өргөжсөн”, талуудын цэргийн байлдааны журам хоорондын завсар, зай ихэссэн нөхцөлд талууд аль алиныхаа жигүүрүүдээр цохилт хийх, дайсны ирэх зам харгуйг хаах, минэ-ийн саад тавих, нуралт үүсгэхийг эрмэлздэг байлаа.

Дайсны байнгын бус зэвсэгт байгууллагатай амжилттай тэмцэхийн тулд байлдааны хөнгөн техниктэй, чөлөөт отрядыг байгуулах шаардлагатай болсон бөгөөд түүний үндэсийг артиллери, танк, саперчдаар хүч нэмэгдүүлсэн, авиациар дэмжүүлсэн мотобуудлагын батальоноор бүрдүүлж байжээ. Туулахад хүндрэлтэй, уулархаг газар оронд газар, агаарын бүрэлдэхүүн бүхий тактикийн агаарын десантын үүрэг улам өндөр болж байжээ. Тэднийг гол төлөв, тэргүүний ангиудаас 15-50 км-ийн зайд чухал объект (гүүр, гарам, гарц, хот суурин, зам харгуйн уулзвар, зангилаа)-ыг эзлэн авах, тогтоон барих, үүрэгтэй буулгадаг байв.

Ингэснээр өөрийн цэргийн ажиллагааг хөнгөвчилж, дайсны отрядыг таслах, бүслэх, гүнээс резервээ татахыг нь хаан хорих бололцоогоор хангаж байжээ. Зөвхөн 1986 онд Афганистанд 12246 хүнтэй, 76 тактикийн агаарын десантыг, 1987 онд 8793 хүнтэй, 28 десант буулгаж байжээ. Армийн ерөнхий операцын районд ажиллагаа явуулах үед, уламжлалын дагуу давших, хориглох зурвасыг заалгүй, хариуцлагын бүсийг түүний оронд тогтоож өгдөг байлаа. Тухайлбал, 5 мбд-д 640 км үргэлжилсэн хариуцлагын бүсийг тогтоон өгч байсан бол, 108 мбд-д 420 км, 201 мбд-д 400 км хариуцлагын бүс зааж өгч байжээ. Хороодын хариуцлагын бүс 100-120 км байжээ. Харин батальонд 30-40 х 10-15 км харьцаатай хэсгийг заан өгч байв.

Цэргийн байлдааны ажиллагаа улам бүр өргөжих, нэн түвэгтэй нөхцөл үүсэх тохиолдолд удирдлага, радио холбоо, тагнуул болон хангалтын хэрэгслийг ашиглахаар урьдаас тооцоолоогүй байсан нь хүндрэл учруулж байсан бөгөөд үүнээс улбаалан байлдааны ажиллагааг зохион байгуулахад нэлээд онцлог байдал үүсэж байжээ. Жишээ нь дивизийн захирагч газар оронд явуулах туршуулыг нисдэг тэргээр хийхэд хүрч байв. Хариуцлагын бүсдээ цэргийн анги, байгууллага, отрядууд тагнуул – хайлтын ажиллагаа явуулах, дайсны бүлэглэлийн дайралтыг няцаах, тулгуур баазыг эзлэн авах, отолттой тэмцэх, онгоц буудал, замын сүлжээг хориглон хамгаалах, ачаа тээврийн цувааг дагалдах, таслан хаах, тогттон барих болон түүвэх ажиллагаа зэрэг “хэвийн бус” үүргийг биелүүлж байлаа. Тийм нөхцөлд анги, салбарууд байлдааны бие даасан байдлаа эрс дээшлүүлэх шаардлагатай тулгарч байлаа. Ар талын бүтэц, техникийн хангалтыг өөрчлөх, тэдгээрийг ар талын асуудлыг дангаар бие даан шийдвэрлэж чаддаг болгохоос гадна байлдааны үүрэг - дайсны дайралтыг няцаах, “өөрийгөө хамгаалах” чадвартай болгож өөрчлөх зайлшгүй хэрэгцээ үүссэн байна. Энэ хэрэгцээ, зорилтыг шийдвэрлэх үүднээс материал хэрэгсэл, ялангуяа галт хэрэгслийн тээвэрлэлтийг хангагч авто тээврийн техникийг хуягжуулах, бие бүрэлдэхүүнийг шинэ зэвсэглэлээр хангах болсон байна. Ийм хэрэгцээ, шаардлага ч дайсны хорлон сүйтгэгч бүлгийн дайралтад өртөмтгий, эмзэг инженер, хими, холбооны салбар зэрэг байлдааны хангалтын цэрэгт тавигдаж байлаа.

Афганистан дахь байлдаанд Зөвлөлтийн цэрэгт тохиолдож байсан хүндрэл, бэрхшээлт асуудал мөн Чечени дэх байлдааны ажиллагаанд (1994-1996 оны) тохиолдож байсан байдаг. Хэдийгээр Афганистаны сургамжийг тэнд байлдсан цэргийн командлал, захирагч дарга, цэрэг дайчид авч байсан ч ЗХ-ний хэмжээнд нэвтрүүлж чадаагүйн улмаас Чечений байлдааны ажиллагаанд өмнөх дутагдал, бэрхшээлтэй дахин тулгарч, тактикийн төдийгүй заримдаа стратеги, операцын түвшинд алдаа гаргаж байсан юм. Тухайлбал, Чечений хууль бус зэвсэгт бүлэглэл (ХБЗБ)-ийн байлдааны боломжийг дутуу үнэлсэн байдаг. Чечений ХБЗБ үнэн чанартаа байнгын армийн түвшинд сургагдсан, байлдах чадвар өндөр байсан юм.

Чечений цэргийн бүтэц нь: дайчилгааны боломж өндөртэй; удирдлагын нарийн тогтолцоотой; зэвсэглэсэн байгууллагууд байлдааны ажиллагааг бие даан явуулах чадвартайгаас гадна тэдгээрийн удирдлага төвлөрсөн, уялдаа холбоо, харилцан ажиллагаа нь өндөр; зэвсэглэсэн байгууллагууд цэргийн зохион байгуулалтын бүтэц (мото явган, уулын буудлагын, танкийн, артиллерийн, агаарын довтолгооноос хамгаалахын, тагнуулын болон ар талын г.м.)-д бүрэн шилжсэн байлаа. Түүнээс гадна, Чечений ХБЗБ-ийн байлдах чадвар нь орон нутгийн ард түмний гүн дэмжлэгт тулгуурласан, үндэстэн – ястны болон шашин шүтлэгийн гүн итгэл, үнэмшилд суурилсан учраас бат нягт, мятрашгүй дайчин чанараар илэрхийлэгдэж байлаа.

Чечений нэг дэх кампани амжилтгүй явагдсан гол шалтгаан нь: уг дайны бэлтгэлийг сайтар хангаагүй, яаран садран шийдвэр гаргаж, операцыг эхлүүлэх цаг хугацаа (12 дугаар сард)-г оновчтой сонгож чадаагүй; цэргийн ажиллагааны үед мэдээлэл-сэтгэл зүйн хангалтад ерөөс ач холбогдол өгөөгүй; хамтарсан операцад оролцогч холбооны янз бүрийн төрийн хүчний байгууллагууд (ХЗЦ, ЦАХ, ДХЯ, ХХА, ОБЯ, ХТБ, ТЗЦ)-ын харилцан ажиллагааг муу зохион байгуулсан; онцлог нөхцөлд байлдаан, байлдааны ажиллагаа явуулах бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг хангаагүй; Зэвсэгт мөргөлдөөний үед тохиолдох асуудлыг шийдвэрлэх бэлтгэл хангагдаагүй зэрэг байсан хэмээн үздэг.

Афганистанд болон Чечени дэх хоёр удаагийн кампанийг Зөвлөлтийн цэрэг амжилт муутай явуусан хэдий ч ихээхэн сургамж, туршлагыг олж, шинэ зэвсэг, байлдааны техникийг хэрэглэж, цэргийн операц, байлдаан явуулах хэлбэр, арга тактикийг эзэмшсэн байна.

Шинэлэг зүйл нь гэвэл: **нэгд**, партизаны ажиллагааны тактикийг ашиглаж буй байнгын бус цэргийн байгууллагатай тэмцэх, байлдаан явуулах үзэл баримтлалын цэгцтэй мэдлэгийн тогтолцоог бүрдүүлж чадсан; **хоёрт**, хүчний бусад байгуулага (ДХЯ, ХХА, ОБЯ, АБА)-ын бүлгүүдтэй хамтран тагнуул – хайгуулын, цохилт – дайралтын, түүвээн – таслан хаалтын ажиллагааг явуулж, тэмцлийн шинэ арга, хэлбэрийг эзэмшсэн; **гуравт**, зэвсэгт мөргөлдөөнд отряд-бүлгийн тактикийн ажиллагаа баталгаажиж, ерөнхий цэргийн нэгтгэл, ангиудын байлдааны журамд шинээр цөөнгүй бүрдэл хэсэг (элемент) үүсэн бий болсон; **дөрөвт**, голомтолсон шинж чанартай байлдаанд дайсныг хөнөөх галын системийг улам боловсронгуй болгосон; **тавд**, тогтоон барьж – тогтворжуулах ажиллагаа хэмээх хориглолт явуулах цоо шинэ арга үүсэж бий болсон; **зургаад**, ерөнхий цэргийн байлдааны зарчим шинэлэг байдлаар бодитой хөгжиж, операц, байлдаанд бэлтгэх, түүнийг явуулах, цэргийг удирдах, харилцан ажиллагаа, бүх талын хангалтыг зохион байгуулах талаарх захирагч, штабын ажлын агуулга, арга баяжсан байна.

Дотоод дахь зэвсэгт мөргөлдөөний байлдааны ажиллагааны практикаар, хамтарсан тусгай операц хэмээх операцын ажиллагааны шинэ хэлбэр боловсрогдсон байна. Хамтарсан



тусгай операц нь гол төлөв ХЗЦ-ийн командлал дор, хүчний янз бүрийн байгууллагуудын цэргийн бүлгүүдийн хамтын хүчээр явагдах зорилго, байр, цаг хугацаагаар уялдуулан зохицуулагдсан нэгдсэн удирдлага доорх операцын, дэглэмийн, улсын хил хаах цэргийн ажиллагаа юм.

Тэдгээр нь зэвсэгт мөргөлдөөнд нэлээд өргөн хэрэглэгдэж байсан хэдий ч, давшилт, хориглолтын хувьд “сонгодог” утгаар биш, хувьсан өөрчлөгдсөн хэлбэрээр явагдаж байлаа. Тухайлбал, хориглолтыг траншейны нягт байрлалыг бүрэлдүүлж, гүн цувраажсан зурвас байгуулах журмаар биш, харин хориглолтын зарим нэг тулгуурт байр, зангилгааг төхөөрөмжилж, гол чиглэлийг хаах зорилгоор эргэн тойрны галын системийн хөшиг, саадыг байгуулах замаар цэргийн ажиллагааны голомтын зарчмаар явуулж байлаа. Давших байлдааны агуулгын үндэс, мөн чанарыг онцгой хэлбэрээр явагдах цохилт-галын ажиллагаа бүрдүүлж байсан ба энэ тэмцэлд байрын хориглолтыг цөмлөх, цохилтын хүчтэй бүлэглэлийг бүрдүүлэх, өргөн фронтоор атаклах, хоёр дугаар цуврааг байлдаанд оруулан байлдааны хүчийг нэмэгдүүлэх г.м. байрын аргуудыг хэрэглэхгүй байна. Томоохон хууль бус зэвсэгт бүлэглэлийг устгах ажиллагааг галын алсын хөнөөл-ойрын бүс дэх галын цохилт-богино хэмжээний атак гэсэн бүдүүвч (схем)-ээр хэрэгжүүлж байлаа. Зарим тохиолдолд хууль бус зэвсэгт бүлэглэлийг мотобуудлага, танк, агаарын десантын салбарууд тэдэнтэй байлдаанд шууд орохгүйгээр алсын зайн галаар бут цохих болсон байна.

Голомтолсон тэмцэл явуулж буй нөхцөлд фронтын тогтвортой шугамгүй болж, байлдааны үүрэг биелүүлэх хүч хэрэгслийн хязгаарлагдмал байдал нь давшилт, хориглолтын байлдааны журамд ул мөрөө бодитой үлдээх болсон байна. Төв баазаасаа салангид, бие биенээсээ тусгаарлагдсан, алслагдсан чиглэлд байлдааны ажиллагаа явуулах мотобуудлага, танкийн болон агаар десантын салбарт тактикийн болон галын бие даасан байдлыг хангах шаардлагатай тулгарсан байна. Энэ байдал нь тактикийн нэгдсэн цоохор отряд, бүлгийг зориулалтынх нь дагуу тусгайлан байгуулахыг нөхцөлдүүлсэн байна. Тэдгээрийн үндсийг танк, артиллери, инженер, огнеметын салбараар хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын батальон бүрдүүлэх болжээ. Түүнээс гадна, зэвсэгт мөргөлдөөний үед, тактикийн нэгдсэн бүлэг, отрядын байлдааны журмын бүрдэл хэсэг (элемент)-т: цэргийн маневрын, цохилт-галын, сөнөөгч онгоцны, хорлон сүйтгэх бүлгийн эсрэг, нисдэг тэрэг-түүвээлтийн бүлэг, хуягт болон нисдэг тэргээр минэжүүлэх хөдөлгөөнт бүлэг шинээр орох болжээ.

Цэргийн маневрын бүлгийг: дайсны бүлэгтэй болон хөдөлгөөнт отрядтай тэмцэх, байлдааны явцад үүсэх гэнэтийн үүргийг биелүүлэх үед бие даасан байдлаа хангах үүднээс байгуулдаг болжээ. Тусгай үүрэг биелүүлэхийн тулд түүний бүтцэд: ДХЯ-ны харьяа дотоодын цэргийн анги, салбар, ДХЯ-ны ОМОН, СОБР бүлгийг оруулдаг болсон байна. Террористуудын эсрэг тэмцэх цэргийн операцын туршлагад үндэслэн маневрын цэргийн

бүлгийг байгуулдаг болсон байна. Өнөө үед мотобуудлагын хороо бүрийн гол бүтцийн нэгжид: гранатмет АГС-17 (Пламя), ТЭУП (ПТУР), огнеметын галаар дэмжүүлсэн мотобуудлагын шинэчлэгдсэн батальон багтах болжээ.

Цохилт-галын бүлгийг: гол төлөв, рейдын, тойрох, дайрах, саатуулах, зарим тохиолдолд суурин харуулах бүлэгтэй байгуулдаг болжээ. Түүний үндсийг: танкийн, мотобуудлагын, артиллерийн салбар бүрдүүлж, галын болон хуягтын цохилтыг хослуулан өгдөг болжээ.

Сөнөөгч онгоцны болон хорлон сүйтгэгчтэй тэмцэх отряд, бүлгийг: хүн амын суурьшлын бүсэд самнах, цэвэрлэх ажиллагаа, явуулах, дайсныг саатуулах, тогтоох, тусгай операц явуулах үед, ХБЗБ-ын террорист бүлэг болон хорлон сүйтгэх-тагнах байгуулагатай тэмцэх зорилгоор байгуулдаг болжээ.

Нисдэг тэрэг-түүвээлтийн бүлэг рейд (манлай) болон тойрох отрядын бүлэгт багтаж, авто тээврийн цуваанд байлдааны дагалт хийх, дайсны отолттой тэмцэх үүрэгтэй байдаг. Энэ бүлэг нь дайсны хорлон сүйтгэх-террорист бүлгийн ажиллагаа, дайралттай тэмцэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг болжээ.

Хуягласан бүлэг хүн амын суурьшлын бүсэд хөдөлгөнт саадын, тойрох отрядын, харуулдан хамгаалах заставын, авто тээврийн цуваа дагалдах отрядын, отолт, дайралтын отрядын бүтцэд багтаж, байлдаан үүрэг гүйцэтгэдэг байна.

Нисдэг тэргээр минэжүүлэх хөдөлгөөнт бүлэг гол төлөв, минэ-гэсэлгээний саадыг дайсны бүлэг ухрах, зугтах зам, зааг дээр шуурхай тавих, хаан саатуулах ажиллагааг явуулдаг байна.

Энэ бүхнээс харахад, ХХ зууны хоёр дугаар хагасад явагдсан орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөнд цэргийн урлагийн агуулга шинэчлэгдэж, цэргийн тактикийн урлаг ихээхэн хувьсан өөрчлөгдсөн байна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**  
**ЦЭРГИЙН ОПЕРАЦЫН УРЛАГ, ТАКТИКТ НӨЛӨӨЛЖ**  
**БУЙ ГАДААД, ДОТООДЫН ХҮЧИН ЗҮЙЛС,**

**§ 2.1. Операц, тактикийн урлагийн хөгжилд нөлөөлж буй гадаад хүчин зүйлс**

Цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийг гадаад ба дотоод хүчин зүйлс гэж хуваан үзэж болох юм. Гадаад хүчин зүйлсэд дэлхийн улс орнуудын цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжлөөс хамаарч улс орнуудын үндсэний цэргийн урлагийн хөгжилд түлхэц өгөх хүчин зүйлс багтах бөгөөд зэвсэглэл, цэргийн техникээс гадна стратеги, операц, тактикийн онол, практик, туршлага, сургамж, дам нөлөө үзүүлэгч даяршлын болон цэрэг-улс төр, цэрэг-стратегийн гэх мэт олон зүйлийг хамааруулан судлан шинжлэх боллоо.

Өнөө үед дэлхийн цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжилд нөлөө үзүүлж буй объектив, субъектив олон хүчин зүйлс байдаг. Цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжил нь улс төр, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан технологи, соёл иргэншил, хүний хөгжил зэрэг объектив болон субъектив нөхцөл, хүчин зүйлээс хамааралтай юм. Эдгээрийн дотроос юун түрүүнд: **нэгд**, гадаад цэрэг-улс төрийн болон цэрэг стратегийн байдал, нөхцөл, хурцадмал байдал, геоулс төрийн болон соёл иргэншил хоорондын зөрчил, нөлөө дам утгаараа; **хоёрт**, төр, нийгмийн байгууллын дэг журам, хууль эрх зүйт байдлын түвшин, зохион байгуулалт, улс төрийн бодлогын уламжлалт, залгамж чанар, тогтвортой, тууштай байдал; **гуравт**, улс орны хөгжил, үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин, эдийн засгийн чадавх, төсөв, санхүүгийн нөөц; **дөрөвт**, зэр зэвсэг, байлдааны техник, хэрэгслийн хөгжил, тоо, чанар; **тавд**, цэргийн урлаг буюу стратеги, операц, тактикийн онолын боловсруулалт, түүний бодит чанар; **зургаад**, цэргийн стратеги, операц, тактикийн шийдвэрийг гаргагч командлагч дарга, захирагч нарын оюуны чадавх, зохион байгуулах ур чадвар, хэрэгжүүлэх үйл ажиллагаа; **долоод**, байлдах арга ажиллагаанд суралцсан цэрэг дайчдын дадлага, ур чадвар, эр зориг, эрэмгий чанар; **наймд**, байлдааны ажиллагааны театр, байгаль, цаг уурын нөлөө, түүнийг эерэг ба сөрөг нөлөөлөлд байлдах чадвар; **есөд**, тухайн улсын шинжлэх ухаан, технологийн хөгжил, түүний түвшин; **аравд**, байлдаан явуулагч талуудын ар тал, хүнийн хөгжил, үзэл санаа, ухамсар, ард иргэдийн санаа сэтгэл, нийгмийн сэтгэл зүй г.м. олон хүчин зүйлс нөлөөлдөг байна.

Энд дурдсан асуудлыг бүгдийг энэхүү судалгааны ажлын тайланд тусгана гэвэл агуулга, багтаамж нь өргөжих тул түүнээс өнөө үед манайд чухалд тооцогдох зарим асуудлыг өнгөц дурдаад бусдыг нь сануулах төдийгөөр хязгаарлан судлан авч үзье.

Тухайлбал:

*Нэгд*, Цэргийн операц, тактикийн урлагт нөлөөлдөг гол нэг хүчин зүйлс нь зэвсгийн хөгжил хэмээн үзэх хандлага түгээмэл байдаг. Энэ нь улс гүрний эдийн засгийн чадавх, үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин, шинжлэх ухаан, техник, технологийн ололт, амжилтаас хамаардаг асуудал юм. Операц, тактикийн урлагийн хөгжил нь “цэргийн хэрэг дэх хувьсгал”-ын үр дагавар бөгөөд шинжлэх ухааны ололт, амжилтыг цэргийн хэргийн практикт нэвтрүүлж буйтай холбогдож байгаа юм.

*“Хувьсгал” нь хүний нийгмийн хөгжилд хамааралтай, төр, нийгмийн байгуулал, нийгмийн үзэгдэл, асуудалд эрс эргэлтийн чанартай өөрчлөлт гаргах, ямар нэгэн юмс үзэгдлийг үндсээр нь өөрчлөх үйл явцын нэр юм.* Дайн, зэвсэгт мөргөлдөөн бол нийгмийн онцгой үзэгдэл, түүний үйл явц, агуулгыг үндсээр нь хувьсгах, өөрчлөхийг дайны хувьсал гэж үздэг. Дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар, агуулга өөрөө өөрчлөгдөхгүй, түүнийг явуулж буй хүч, хэрэгслийн хувьслын нөлөө нь өөрчлөгддөг зүй тогтолтой. Тодруулж хэлбэл, дайн, зэвсэгт мөргөлдөөнийг явуулж буй цэргийн хэрэгт гарч буй хувьсгалын доор дайны хувьсал өөрчлөлт явагдана гэсэн үг юм.

*Цэргийн хэрэг дэх хувьсгал нь шинжлэх ухаан-техник, технологийн ололт, дэвшилийн нөлөө дор зэвсэгт тэмцлийн хэрэгсэлд гарсан чанарын үндсэн өөрчлөлтийн үр дагавар бөгөөд тэр нь зэвсэгт хүчний байгуулалт, сургалт, бэлтгэл, цэргийн байлдах урлаг, дайныг бүхэлд нь үндсээр нь өөрчилж буй үйл явцаар илэрхийлэгддэг.*

Цэргийн урлаг (операц, тактик)-ийн хувьсал, өөрчлөлтөд нөлөөлж ирсэн түүх асуудлыг, ОХУ-ын зарим судлаачдаас дэвшүүлсэн дайны хувьсал өөрчлөлтөд зэвсгийн хувьсгал хэрхэн нөлөөлсөн болохыг тайлбарласан үзэл бодлоос эш татан авч үзье<sup>51</sup>.

Хүн төрөлхтний түүхэн хөгжил дэх цэргийн хэрэг дэх (түүн дотор цэргийн урлаг ч багтана) *анхны хувьсгалыг*: дайтагч талууд чулуу, саваа модоор хүчирхийллийг явуулж ирсэн олон зуун жилийн тэмцлийн аргыг, тусгайлан бэлтгэсэн жад, илд бамбай, нум сум, тэрчлэн хуяг дуулга хэрэглэн явуулдаг болсонтой холбон авч үздэг. Манай гараг дээрх хүний нийгмийн соёл иргэншил оршин тогтносон анхан үеэс хүмүүс хүчирхийлэлт тэмцлийг явуулахдаа урт удаан хугацаанд чулуу, саваа мод гэх мэт хүйтэн зэвсэг хэрэглэн ойрын зайнд гардан байлдааны хэлбэрээр тэмцэж ирсэн түүхтэй. Энэхүү түүхэн хугацаанд хүн тэмцлийн хэрэгсэл болох зэвсэг (чулуу, саваа мод зэргээ)-ийг өөрчилж, илүү бөх бат материалаар илд, бамбай, нум, сумыг бүтээсэн нь зэвсэгт тэмцэл, дайны шинж чанарт эргэлтийн шинжтэй өөрчлөлтийг гаргажээ. Ойрын зайн гардан тулалдаан өөрчлөгдөж, арай хол зайнаас явагдах болж, чулуу, саваа модон зэвсэг нь илд, бамбай, нум сумаар солигджээ. Үнэхээр чулуу, саваа модтой, явган хүмүүсийн хооронд явагдах тэмцлээс, илд бамбай барьсан, нум сум агссан, агт морьд унасан хүмүүсийн хоорондын тэмцэл чанарын том ялгаатай байжээ.

<sup>51</sup> В.И.Слипченко. Войны шестого поколения. М. 2002;

ХII-ХIII зуунд зэвсэгт тэмцлийн хэрэгслийн хоёр дахь хувьсгалд анхдагч хувьсгалын үр дүн байр сууриа тавьж өгчээ.

*Цэргийн хэргийн хоёр дахь хувьсгал нь* зарим улсад дарь бүтээж, түүнийг винтов, гар буу, их буу зэрэг галт зэвсэг хэрэглэх болсоноор явагдаж эхэлсэн байна. Дайн, зэвсэгт тэмцэл явуулах арга тактик эрс өөрчлөгдөж, нум, сум, илд, бамбай хэрэглэсэн зэвсэгт тэмцэл винтов, гар буу, их буу хэрэглэсэн зэвсэг тэмцлээр солигджээ. Дайсныг арай алсын зайнаас винтов, гар буу, их буугаар устгах болж, арга тактик нь эрс өөрчлөгджээ. Зэвсэгт тэмцлийн хоёр дахь үеийн хувьсгалын үр дүн бараг өөрчлөгдөлгүй, 600 гаруй жил үргэлжилжээ.

*Цэргийн хэрэг дэх гурав дахь хувьсгал нь* техник, технологийн дэвшлийн үр дүнгээр бянтат зэвсгийг бүтээх үйлдвэрлэлийн технологийг нэвтрүүлж, бянтат зэвсгийг цэрэгт үй олноор хэрэглэх болсноор явагдаж эхэлсэн байна. Эдгээр зэвсэг нь целийг хөнөөхдөө цэцэн, алсын тусгалтай, олон дахин цэнэглэгддэг, төрөл бүрийн калибертай болсон нь зэвсэг тэмцэл явуулах арга, тактик их өөрчлөлтийг авч иржээ. Дайн, зэвсэгт тэмцэлд хэрэглэж буй үй олон бянтат зэвсэг нь түүнийг окопын байлдааны шинж чанартай болгон хувиргажээ.

100 гаруй жилийн өмнө *цэргийн хэрэг дэх ээлжит дөрөв дэх хувьсгал* хийгджээ. Энэ хувьсгал дайн, зэвсэгт тэмцэлд танк, нисэх онгоц, далайн хөлөг онгоц хэрэглэх болж, тэдгээрт суурилуулсан автомат зэвсэг хэрэглэсэнээр явагдаж эхэлжээ. Дөрөв дэх үеийн цэргийн хэрэг дэх хувьсгалаар маш олон тооны амьд хүч, зэвсэглэл, цэргийн техникийг ашиглах болсон нь зэвсэг тэмцлийг операцын төлөв шинжтэй болгожээ.

*Цэргийн хэрэг дэх ээлжит тав дахь хувьсгалыг* 1945 онд гарсан гэж үздэг. Энэ нь зэвсэглэлд цөмийн зэвсгийг зохион бүтээсэнтэй холбоотой юм. Түүнийг дагаад алсын зайн бөмбөгдөгч, пуужин зохион бүтээгдэж цөмийн дайн явагдах нөхцөлийг бүрдүүлжээ. Пуужинт-цөмийн дайн явагдах эхлэл тавигдсан нь цэргийн урлагт мөн хувьсгалын шинж чанартай өөрчлөлтийг оруулсан байна. Эдүгээ арваад улс гүрэн цөмийн зэвсгийг эзэмшиж, дайн, байлдааны ажиллагаа явуулах стратеги, тактикийг болжээ. Гэсэн хэдий ч Японы Хиросимо, Нагаск хотод АНУ цөмийн бөмбөг хэрэглэсэнээс хойш түүнийг дайн, байлдаанд ашигласангүй. Хэрэв цөмийн зэвсгийг дайнд ашиглана гэвэл хүн төрөлхтнийг хөнөөн устгах хэмжээний пуужинт-цөмийн зэвсгийн нөөцийг хуримтлуулсан байна. Цөмийн зэвсэгтэй дайтагч талууд дайснаа анхны цөмийн цохилтоор эсэргүүцэн тэмцэх чадваргүй болгохын тулд нөөц зэвсгийнхээ ихэнхийг ашиглах нь ойлгомжтой. Энэ нь сүйрэлд хүргэнэ. Өнөөдөр цөмийн зэвсгийг дайн, байлдааны ажиллагаанд хэрэглэх хэрэгсэл болгохоос илүүтэй том дайн, зэвсэг мөргөлдөөнийг тогтоон барих хэрэгсэл, өөрийгөө хамгаалах, халдлагад үл өртөх баталгаат хэрэгсэл болгох нь түгээмэл шинжтэй болжээ.

XX зууны сүүлчийн арван жилээс хойш *цэргийн хэрэг дэх зургаа дахь хувьсгал* эхэлсэн гэж үзэх болжээ. Энэ хувьсгал нь нэн өндөр цэцтэй зэвсэг гарсантай холбоотой бөгөөд

түүнийг дагаад зургаа дахь үеийн цоо шинэ, алсын зайн дайн, зэвсэгт мөргөлдөөн явагдах болсон байна.

Харин өнөөдрийн байдлаар *цэргийн хэрэг дэх долоо дахь хувьсгалын* эхлэл тавигдаж байна гэж үзэх үндэслэл бий болжээ. Энэ нь зэвсэгт тэмцлийн хэрэгслийн хөнөөлийн нөлөө механик болон энергийн үйлчлэлд үндэслэж байсныг өөрчилж, цэвэр энергийн үйлчлэлд шилжүүлэх болж буйтай холбоотой хэмээн судлаач бид үзэж байна. Энэ тухай энэхүү судалгааны ажлын I ба IV дүгээр бүлэгт арай дэлгэрүүлэн авч үзнэ.

Дээрх зүй тогтлоос харахад, цэргийн операц, тактикийн урлагт нөлөөлдөг гол нэг хүчин зүйл нь зэвсгийн хөгжил хэмээн үзэх хандлага давамгайлж байсан цаг үе өнгөрөх хандлагатай болоод байна. Цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжилд дайн, зэвсэгт мөргөлдөөн өөрөө нөлөөлдөг болжээ. Энэ тухай зарим судлаач бүтээл туурвилдаа бичсэн байдаг<sup>52</sup>. Түүнийг арга зүйн удирдамж болгон авч үзье. Цэргийн урлагийн хөгжлийн чиг хандлагад орчин үеийн дайны хувьсал, өөрчлөлттэй холбоотой хэд хэдэн гадаад хүчин зүйлсийн нөлөө байна.

*Нэгдүгээрт*, дайн, зэвсэгт мөргөлдөөн үүсэн гарах магадлал, түүний арга, хэлбэрийн өөрчлөлт, тухайн улсын онцлог зэрэгтэй холбоотойгоор дайн, зэвсэгт мөргөлдөөнд хандах төрийн бодлого, үйл ажиллагаа нь тэдгээрийн цэргийн урлагийн хөгжил, хувьсалд нөлөөлж байна. Тухайлбал, үүнд цэргийн хэрэгт хувьсгалын шинж чанартай өөрчлөлт явагдаж, бүх нийтийн цөмийн дайны аюул занал багасан алслагдаж байгаа нь нөлөөлж байна. Жишээ нь: Монголын цэргийн урлаг коммунизмын дараах улс орнуудын цэргийн урлагийн нэгэн адил, ЗХУ-ын (хуучин нэрээр) цэргийн урлагийн онол, практикийг удирдамж болгож, түүний агуулгад өөрийн армийн онцлогийг харгалзан тодотгол, тодруулгыг нэмэхийн зэрэгцээ цэргийн хамтын ажиллагааг урьтал болгосон цэргийг урлаг (операц, тактик)-т захирагдаж байлаа. Тийм ч учраас өмнөх нийгмийн үед, ердийн болон цөмийн зэвсгийн аль алиныг ашигласан зэвсэгт тэмцэл явуулах цэргийн урлаг (операц, тактик)-ийг хөгжүүлэхийг эрхэмлэж байлаа. Тэгвэл, өнөө үед манай төр засгийн төрийн батлан хамгаалах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль дахь “өөрийгөө хамгаалах” байр суурьт захирагдаж буйгаас үндэсний цэргийн урлагийн онол, практик энэ чиглэлд илүүтэй хандах боллоо.

Өөрөөр хэлбэл, манай үндэсний цэргийн урлаг өмнөх нийгмийн адил цөмийн зэвсэг хэрэглэсэн зэвсэгт тэмцэл явуулахад бэлтгэх бус, харин тийм дайн, байлдааны үед өөрийгөө хамгаалах, дөрөв дэх үеийн зэвсэгт тэмцлийн хэрэгсэлтэй<sup>53</sup> улс орны хувьд ийм зэвсэгт тэмцлийн стратеги, операц, тактикт илүүтэй анхаарч, өөрийгөө хориглон хамгаалахад чиглэх

<sup>52</sup> Ш.Паламдорж. Дайны хувьсал өөрчлөлт, цэргийн урлагийн хандлага. УБ., 2011 он;

<sup>53</sup> В.И.Слипченко. Войны шестого поколения. М. 2002; Ш.Паламдорж нар. Нэн өндөр цэцтэй зэвсэг, түүнээс хамгаалах. УБ., 2007 он. – 192 х;

боллоо. Түүний хамт шинэ хэлбэр, төрлөөр явагдах зэвсэгт тэмцлийн шинэ эрин эхэлж байгааг ухаарч, зургаа дахь үеийн зэвсэглэлтэй улс орны тоо өсөн нэмэгдэж, түүнийг орчин үеийн дайн, байлдааны ажиллагаанд хэрэглэх нь түгээмэл хандлагатай болж байгаад үнэлэлт, дүгнэлт хийж, зургаа дахь, дөрөв дэх үеийн зэвсэглэлтэй улсуудын цэргийн тактикийн ажиллагаа нь хэлбэрээ өөрчлөн хувьсгаж байгааг ч мэдэрч өөрийн цэргийн урлагийг энэ чиглэлд хөгжүүлэх хэрэгцээг бий болгож байна.

Дээр дурдсан дэлхийн улс орнуудад дайн, зэвсэгт мөргөлдөөн үүсэн гарах магадлал, түүний арга, хэлбэрийн өөрчлөлт нь зэвсэгт тэмцлийн хэрэгслийн хөгжил, хандлага, цэргийн урлаг (операц, тактик)-ийн хувьсал, өөрчлөлтөд нөлөөлж байна. Үүний хамт орчин үеийн цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжилд гарч буй стратегийн зорилт, операцын урлаг, тактикийн арга ажиллагааны онол, практикийн хувьсал, өөрчлөлт, чиг хандлагыг бас дээрхийг харгалзан үзэх, өөрийн цэргийн зэвсэгт тэмцэл явуулах чадавхыг дээшлүүлэх арга замыг сонгон тогтоох үндэслэлд анхаарыг шаардаж байна.

**Хоёрдугаарт,** дайны хэлбэр, түүнийг явуулах арга өөрчлөгдсөнөөс цэргийн урлагийн агуулгад хувьсгалын шинж чанартай өөрчлөлт бас орж эхэллээ. Үүний нэг нотолгоо бол “хүйтэн дайн”, түүнийг явуулсан стратеги, операц, тактикийн ажиллагаа юм. Дайны онол дахь түүний мөн чанар энэ тохиолдолд өөрчлөгдөөгүй, харин түүнийг явуулах хэлбэр, стратеги, операц, тактикийн арга, хэрэгсэл өөрчлөгдлөө. Энэхүү дайныг зэвсэгт хүчин, цэргийн хүчээр явуулаагүй, байлдааны ажиллагааны уламжлалт театрт явуулаагүй, нийгмийн доторх хүмүүсийн ухамсар, сэтгэл зүй гэсэн онцлог “театр”-т мэдээлэл, сэтгэл зүйн хэрэгслээр явууллаа. Энэхүү дайны улс төрийн зорилго нь дайсны цэргийг бут цохиход бус, газар нутгийг эзлэн авахад ч бус, гагцхүү дайны төгсгөл, үр дүнг эсрэг талыг удирдах, залах эрх мэдлийг гартаа авахад оршиж байлаа. Өөрөөр хэлбэл дайны ялалтын агуулга, үр дүнд өөрчлөлт орлоо. Ялалт байгуулж, дайн өдөөгчдийг олон улсын цэргийн шүүхээр шийтгэх, дайны төлбөрийг буруутан (ялагдагч тал)-аас гаргуулах нь ялалтын эцсийн үр дүнгийн нэг үзэгдэл биш боллоо. Дайны дараах дэлхий дахины сценар (зохиомжит), төлөв байдлыг болон “дайтагч” тухайн улс орныг удирдах эрх дархыг олж авах, ингэснээрээ дайны улс төрийн жинхэнэ зорилгыг биелүүлэх үндсийг бүрдүүлэх санаачилгыг гартаа авахад ялалтын агуулга, үр дүн орших боллоо.

Өнөө үед ямар ч улс мэдээлэл-сэтгэл зүйн дайнаас цэрэг-техникийн хэрэгслээр сэргийлэх, хамгаалах, тэр тусмаа тэмцэл явуулах боломжоор хязгаарлагдмал болоод байна. Иймээс аюулгүй байдлыг хангахад цэргийн хүч хэрэгсэл, операц, тактикийн арга стратегиас гадна олон улсын хууль, эрх зүй, улс төр, эдийн засаг, оюун санаа, мэдээллийн г.м. өргөн хүрээнд ажил, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх хэрэгтэй боллоо. Мэдээлэл-сэтгэл зүйн дайнд, дээр дурдсан хүрээнд сөрөг арга хэмжээг бололцоот бүх хэлбэр, аргуудыг

оновчтой хослуулан ашиглаж явуулснаар сөрөн зогсож чадна. “Хүйтэн дайн”-д ялагдсан учир шалтгаанд хийсэн шинжилгээ дүгнэлтээс үзэхэд, өмнөх нийгмийн байгууллын үед цэргийн урлагийн онол, практикийн судалгааг явцуу хүрээнд явуулж байсантай холбоотой болох нь тодорхой байна. Тэгэхээр дайны хувьсал өөрчлөлт, хэлбэр, агуулга нь цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжлийн хандлагыг өөрчилж, тодотгож, цоо шинэ чиглэлд хөгжүүлэхийг нөхцөлдүүлэх болжээ.

*Гуравдугаарт*, дайныг өөрөөр ойлгох шаардлага хэрэгцээ зүй ёсоор тавигдаж байна. Дайн дан ганц зэвсэгт тэмцлээр явагдахаа больж, дайны байдалтай цаг, тайван цагийн зааг ялгаа арилж, тайван цагт зэвсэгт бус тэмцлийн хэрэгслээр дайн явагддаг болж байна. Үүнийг зөв танин мэдсэнээр өнөө үеийн “дайн”-ыг ойлгоно. Өнөө үеийн “дайн”-ыг танин мэдэх нь танин мэдэхүй талаасаа цэргийн шинжлэх ухаанд хамааралтай юм. Цэргийн шинжлэх ухаанд системийн шинжилгээний аргазүй үгүйлэгдэж, цэргийн урлаг (операц, тактик)-ийн асуудлыг явцуу утгаар зөвхөн цэрэг, зэвсэг хэрэглэх хувилбараар судалж иржээ. Ерөөс цэргийн шинжлэх ухааныг зөвхөн зэвсэгт тэмцэл явуулах, түүнд бэлтгэх агуулгаар ойлгож, хөгжүүлж ирсэн онол, практик нь алдаатай болохыг бид одоо ухаарч шинжлэх шаардлага үүсч байна. Эндээс цэргийн шинжлэх ухаан дахь дайны тухай ерөнхий онолыг тогтолцоот чанараар нь, ялалт байгуулах цэрэг, зэвсгийг анхдагч болгохоос гадна, дайн, зэвсэгт мөргөлдөөнийг явуулдаг болж буй шинэ арга стратеги, операц, тактиктэй нь хамтаар судлах системийн шинжлэх ухаан болгон өргөжүүлэх учиртай нь ойлгомжтой байна. Цэргийн шинжлэх ухаан аюулгүй байдлыг хангах судлалтай нягт холбогдож байна. Энэ байдлыг бататгах үүднээс цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжил, түүний хандлагад нөлөөлөгч гадаад хүчин зүйлсийг багтаан шинжлэх аргад шилжих шаардлага бий болсон байна. Энэ нь цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжил, түүний хандлагад нөлөөлөх болно.

*Дөрөвдүгээрт*, тайван цагт дайн явагдаж буйн тод илрэлийн нэг бол мэдээллийн дайн болоод байна. Үүний талаар тусгайлсан судалгаа, шинжилгээний ажил явуулах хэрэгцээ, шаардлага бий болжээ. “Хүйтэн дайн”-ыг дайн биш хэмээн үздэг хуучирсан сэтгэлгээ манай цэргийн зүтгэлтнүүдийн сэтгэл, оюун ухаанд байдаг. Тэгвэл мэргэдийн үгээр, “Шилдгийн шилдэг жанжин дайсны цэргийг тулалдаангүйгээр буулгаж авдаг. Иймээс дайны урлагийн дээд нь дайсны дайн явуулах төлөвлөгөөг таслан зогсоох” гэсэн байна<sup>54</sup>. Клаузевиц “дайн бол өөр хэрэгслээр явуулж буй улс төрийн бодлогын үргэлжлэл”, “улс төрийн бодлогын мөн чанар нь эрх мэдлийн төлөөх тэмцэл” гэжээ<sup>55</sup>. Эндээс аливаа дайны мөн чанар нь улс төрийн бодлоготой холбоотой байх бөгөөд “дайсан улсыг өөрийн эрх мэдэлд оруулах”, “ялалтын дараа эрх дураараа дайсан улсаа залах”-д оршиж байна. Улс төрийн бодлогыг дагах,

<sup>54</sup> Сун цзы. Дайтах урлаг. т.14;

<sup>55</sup> Клаузевиц.О войне. т.55;



эсэргүүцэх аль аль нь сэтгэл зүйтэй холбоотой. Мэдээлэл, сэтгэл зүйн дайны мөн чанар нь мөн л “ердийн дайн”-ы нэг адил боловч “дайсан улсын санал, санаачилга, чиглэл, зөвлөмжийг хүлээн зөвшөөрөх”, “түүний зохицуулах бодлого, стратегийн төлөвлөгөөг аялдан дагах” болгож нийгмийн болон хувь хүмүүсийн сэтгэл зүйг өөрчлөхөд оршдог байна.

Эндээс “хүйтэн дайн”-ыг дайн биш хэмээн үздэг сэтгэлгээ, үзэл бодлыг өөрчлөх үндэслэл гарч ирдэг. “Хүйтэн дайн”-ы эхний шат нь “үзэл суртлын дайн”-аар эхэлж, “мэдээлэл, сэтгэхүйн дайн”-д шилжин өнөөг хүртэл үргэлжилж, улам олон янз, түвшинд хүрээд байна. Мэдээлэл, сэтгэл зүйн дайныг уламжлалт мэдээллийн хэрэгслээр явуулдаг байснаа өөрчилж зөвхөн сэтгэхүй, ухамсар, оюун санаанд үйлчилдэг шинэ төхөөрөмж хэрэгслийг ашигладаг болж байна. Бид үүнийг тайлбарласан “Мэдээллийн дайн, түүнээс хамгаалах”<sup>56</sup> (2003 он) гэсэн нэгэн сэдэвт шинжилгээ, судалгааны бүтээлээ олон нийтэд өргөн барьсан юм. Мэдээлэл, сэтгэл зүйн дайн гэх мэт зэвсэгт бус түрэмгийлэлтэй тэмцэхэд дан ганц цэргийнхний хүч хэрэгсэл хангалтгүй, нийгмийн бусад хүрээний бодлого, үйл ажиллагаа, хүч хэрэгсэл зайлшгүй оролцох учир төр, засгийн дээд удирдлагын асуудал гэсэн байр сууринаас хандах үндэслэл байхгүй болжээ. Үүнээс улбаалан, *нэгд*, улс орны аюулгүй байдлыг хангах нь монголын ард түмний нийтлэг үүрэг мөн боловч, төрийн гол үүрэг; *хоёрт*, зэвсэгт хүчнийг ашиглах эрх мэдэл зөвхөн парламентад байна. Тиймээс өнөө үед үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс парламентийн гишүүд, төр, засгийн удирдлагад ажиллаж буй улс төрийн албан тушаалтан бүгд дайн, зэвсэгт мөргөлдөөний мөн чанар, тийм операц, тактикийн ажиллагааг судалж мэдсэн, хамгаалалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэх мэдлэг, чадвар суусан байх шаардлагатай тулгарч байна.

Мэдээлэл, сэтгэл зүйн дайн гэх мэт зэвсэгт бус түрэмгийлэл, аюулаас хамгаалах, аюулгүй байдлыг хангах асуудалд цэргийнхэн тэргүүлэх үүрэг хүлээх нь тодорхой. Өнөө үед дагаж мөрдөж буй хуулийн хүрээнд бол *нэгд*, Зэвсэгт хүчин нь “... улс орныг цэргийн хүчээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллагуудын тогтолцоо мөн”; *хоёрт*, тайван цагт “эх орноо гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах бэлтгэлийг хангах” үүрэг хүлээсэн байгууллага. Энэ үүднээс асуудалд хандахдаа судлаачид бид “аюултай байж болзошгүй юм бүхэн аюул учруулна” гэсэн Мурфигийн хуулийг даган мөрдөж, “мэдээллийн түрэмгийллээс” хамгаалах стратеги, операц, тактикийг боловсруулах үүргийг мэргэжлийн хүмүүсийн хувьд хүлээнэ. Цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжилд мэдээллийн дайны үеийн урлаг (стратегийн, операц, тактик) гэсэн шинэ хандлага бий болж байна.

*Тавдугаарт*, дэлхий дахинаа хөгжлийн болон баян, ядуугийн зааг ялгаа эрс өсөж, хүчтний өмнө хүчгүй нь буруутан болох явдал түгээмэл болж, үүнийг зарим судлаач “дэлхийн удирдагчид улам илүү хөнөөлт зэвсэг олж авах санаархлаа амьдралд хэрэгжүүлж,

<sup>56</sup> Ш.Паламдорж. Мэдээллийн дайн, түүнээс хамгаалах нь. УБ., 2003 он;

үүнтэй хамт хэт колончлолын шинэ хэлбэрийг тулган хүлээлгэх, аргагүй болгох зорилготой, түүний эсрэг чиглэсэн батлан хамгаалах холбоотнууд гарч ирэхэд түлхэц өглөө. Харин илэрхийгээр эсэргүүцэн зогсож чадахгүй хэсэг нь газар сайгүй гардаг үзэгдэл болж буй партизаны дайн, ганцаарчилсан террорист ажиллагаа зэргийг хэрэглэх болов. Энэ бүхэн хүн төрөлхтөн өөрийгөө устгахад хүргэж байна”<sup>57</sup> гэж үзэж байна. Терроризмын дайн шинэ супертерроризмын дайны хэлбэрт шилжих занал нүүрлэх боллоо. Ерөөс халуун дайны хэлбэрийг өөрчилж, шинэ маягийн партизаны дайн - “терроризм”-ын дайныг өрнүүлж байна. Энэ дайны хүч хэрэгсэл, стратеги, операц, тактик өвөрмөц онцлогтой байна.

Дайныг гол төлөв цэргийн хүчээр явуулдаг байсан бол “терроризм”-ын дайнд хэт даврагсад, салан тусгаарлагчид, шашны тулгуур болон үндэсний дээрэнгүй үзэлтнүүд болох энгийн ард иргэд, зэвсэглэсэн “мэргэжлийн” бус хүчин явуулж байна. Уламжлалт дайнд дайсны цэрэг, зэвсэгт хүчинтэй байлддаг байсан бол “терроризм”-ын дайнд террористуудын байлдааны объект нь энгийн ард иргэд, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, иргэний байгууламж, үйлчилгээний объект, хэрэгсэл болж байна. “Терроризм”-ын дайн нь партизаны дайны стратеги, операц, тактикт өөрчлөлт оруулсан шинэ хэлбэр болж байна. Энэ нь улмаар устгах, хөнөөх ажиллагаанаас оюун санааны хорлон сүйтгэх үйлдэлд шилжих зүй тогтол болон хувирах хандлага ажиглагдаж байна. Ийм дайн өнөө үед нэлээд түгсэн шинжтэй явагдаж байгаа нь үндэсний цэргийн урлаг (операц, тактик)-ийг энэ чиглэлд хөгжүүлэхийг нөхцөлдүүлж байна. Ойрын ирээдүйд тохиолдож болзошгүй энэ мэт дайны ажиллагааны хувилбар, боломжууд үндэсний цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжилд нөлөөлөх болно.

Дэлхий дахинаа орчин үеийн халуун дайны шинж чанар, хэлбэр, агуулгын хувьсал, өөрчлөлт нь гадаад олон хүчин зүйлсийн нөлөөлөл дор явагдаж байна.

XIX, XX зуунд явагдсан үндсэн төрлийн дайны хэлбэр болох халуун дайн нь сонгодог утгаар явуулж буй зэвсэгт тэмцэл буюу дэлхийн I, II дайн, түүнээс хойш явагдсан бүс болон орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөнүүдийг хамааруулан ойлгох бөгөөд шинэ төрөл, загварын галт зэвсэг хэрэглэж, цус асгаруулан явагддагт энэхүү халуун дайны үндсэн шинж чанар агуулагддаг байна. Орон нутгийн дайнуудад зургаа дахь болон дөрөв дэх үеийн зэвсэглэл<sup>58</sup> хэрэглэж (тухайлбал, НАТО- Югаслав; АНУ- Ирак, Афганистан- АНУ-ын хооронд), эсвэл дөрөв дэх үеийн зэвсэглэл хэрэглэн (тухайлбал, Гүрж– Өмнөт- Осетийн дайн) явагдсан байна. XXI зуун гараад ч тийм дайн үргэлжилсээр байна.

<sup>57</sup> Ж.Капур. Бидний ирээдүй: хэрэглээндээ дарлагдах уу, хүмүүн байдлаа сахих уу. т.15;

<sup>58</sup> Слипченко В. И. Войны шестого поколения. М., 2000;

Халуун дайныг хязгаарлах, сэрэмжлэх, аюулгүй байдлыг хангах зорилго бүхий олон улсын байгууллага дэлхий болон тив, бүс нутгийн хэмжээнд олноороо байгуулагдсан хэдий ч дайн явагдсаар, түүнийг хэрэгжүүлэгч цэргийн операц улам бүр хувьсан өөрчлөгдсөөр байна.

Бүх нийтийн халуун дайн өрнөсөн тохиолдолд, хүн, түүний соёл, иргэншлийг сүйрлийн ирмэгт хүргэх аюултай хэрэгслийн нэг үй олноор устгах зэвсэг (цөм, хими, биологи), тэдгээрийн шинэ хэлбэр (нейтрон, бинар, токсин)-үүд, физикийн шинэ зарчимд үндэслэсэн болон шинэ төрлийн үй олноор хөнөөх хэрэгслийг зэвсэглэлд нэвтрүүлж, тэдгээрийг хэрэглэх болоод байна. Халуун дайны далд аюул урьд өмнө байгаагүйгээр ихсэж, түүнийг улс төрийн бодлогын үргэлжлэл болгохоос болгоомжлох байдал хэт их гүрнүүд болон хөгжил өндөртэй улс орнуудын төр, цэргийн бүлэглэлийн удирдлагад зонхилох байр суурь эзлэх боллоо. Тиймээс бүх нийтийн халуун дайныг явуулахад чиглэсэн цэргийн чадавх, урлаг цөөн тооны улсад байгаа, нөгөө талд нь нийтлэг байдлаар тийм дайн, байлдааны үед тэрхүү зэвсгийн хөнөөлөөс хамгаалах асуудалд голлон анхаарч, цэргийн операцийн урлаг, тактикийн онол аргагүйгээ хөгжүүлэх хандлага түгээмэл хэвээр байна.

Орчин үед цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжилд нөлөөлж болохуйц гадаад хүчин зүйлсэд хамгийн түрүүнд зэвсэглэл, цэргийн техникийн хөгжлийн эрс тэс ялгаа болж байна. Харин зургаа дахь үеийн зэвсгийг орон нутгийн дайнд өргөн хэрэглэж байгаагаас өнөө үеийн халуун дайны дэлхийн цэргийн операц, тактикийн урлагийн хөгжил эрс тэс ялгаатай агуулга бүхий гурван янзын хөгжлийн түвшин, чиглэлээр өрнөж байна хэмээн үзэж байна.

**Нэгд**, дайтагч талуудын аль алин нь нэн өндөр цэцтэй зэвсэг (НӨЦЗ), цэргийн хүчин болон зэвсгийг удирдах автомат систем, сансар, агаарын тагнуул, холбоо, радио электрон, мэдээллийн тэмцлийн хэрэгслүүдээр хангагдсан цэрэг, зэвсэглэлтэй нөхцөлд явагдах байлдааны ажиллагааны цэргийн урлагийн хөгжлийн түвшингээр илэрхийлэгдэх үндсэн чиглэл болоод байгаа юм. Энэ түвшний цэргийн операцын урлаг, тактикийн онол, агуулга урьд өмнөх үеийн урлагийн агуулгаас нэлээд өөрчлөгдөх боллоо. Үүнд:

- Зах нийлж нүүр тулсан, хоёр хос хүчин (симметр)-үүдийн хооронд явагдах дайн багасаж, харин дайны ажиллагаа алсаас (бесконтактный) явагдаж, дайсны хүч хэрэгслийн бүлэглэлийн хаанаас, ямар цохилт ирэх нь тодорхойгүй шинж агуулах боллоо;

- Гүний цэргийн тагнуулын үүрэг өсөн нэмэгдэж, дайн, зэвсэгт тэмцлийн ажиллагааг эрс шийдэмгий явуулах боломжийг нэмэгдүүлэх шинжийг агуулж байна;

- НӨЦЗ-ийн операц, тактикийн зориулалттай гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж, ялалт, ялагдлыг шийдвэрлэхэд үндсэндээ түүнийг ашиглах нь түгээмэл байна;

- Цохилтыг гол төлөв эсрэг талынхаа оперативын чухал объектууд (цэрэг-улс төрийн удирдлагын байр, үйлдвэрлэл, эдийн засгийн бааз, төвүүд, суурь бүтцийн оперативын ач холбогдол бүхий зангилаанууд) дээр өгч, ялалт байгуулах урьдач нөхцөлийг хангаж байна;

- Эсрэг тал нь дайсныхаа алсын зориулалттай пуужин, авиац, НӨЦЗ-ийн цохилтын эсрэг хийх тэмцлийн бэлтгэлийг эртнээс хангаж, дайн эхэлмэгц түүнийг хэрэгжүүлэх болсон явдал юм.

**Хоёрт**, дайтагч талын нэг нь нэн өндөр цэцтэй зэвсэг (НӨЦЗ), цэргийн хүчин болон зэвсгийг удирдах автомат систем, сансар, агаарын тагнуул, холбоо, радио электрон, мэдээллийн тэмцлийн хэрэгслүүдээр хангагдсан, нөгөө тал нь IY дэх үеийн зэвсэг, байлдааны хэрэгсэлтэй байгаа тохиолдолд явагдах байлдааны ажиллагааны цэргийн урлагийн хөгжлийн түвшингийн нэг чиглэл юм. Энэ түвшний цэргийн операцын урлаг, тактикийн онол, агуулга нь Персийн булан, Югослав, Ирак, Сири дэх байлдааны ажиллагааны агуулгаар тодорхойлогдож байна. Үүнд:

- Дайны эхэн үед алсын цохилтоор эхлэн явагдах зэвсэгт тэмцэл нь IY дэх үеийн зэвсэглэл бүхий улсын үндсэн объектууд, цэргийн хүчний үндсэн бүлэглэлийн байлдах чадварыг сулруулах, YI дахь үеийн зэвсэглэлтэй довтлогч тал нь улс төрийн зорилгоо биелүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх шинжийг агуулна. Энэ дайны сонгодог жишээ бол АНУ- Иракийн хооронд явагдсан дайн, түрэмгийлэл юм;

- Дайны эцсийн шийдвэрлэх үүргийг хуурай замын цэрэг, агаарын цэргийн харилцан ажиллагаатайгаар гүйцэтгэх бөгөөд гагцхүү байлдааны ажиллагааны эрчим нэлээд суларсан шинж чанартай байна. Энэ нь IY дэх үеийн зэвсэглэлтэй улсын удирдлага, хүч хэрэгсэл нэлээд сарнисантай холбоотой байна;

- Зэвсэглэлийн хөгжлийн энэхүү эрс ялгаатай дайн, зэвсэгт тэмцлийн ажиллагаа нь төгсгөлдөө жижиг бүлгийн болон партизаны фронт, ар талын зааггүй дайн, зэвсэгт тэмцлийн шинжийг агуулж байна;

- Дээрх шинж байдлаас шалтгаалан дараагийн дайн сунжирсан дайн, зэвсэгт тэмцэл болон хувирах шинж чанартай. 2001, 2003 онд явагдсан Афганистан дахь болон Ирак дахь дайны улс төрийн эцсийн зорилго бүрэн хэрэгжиж чадахгүй өнөөг хүртэл үргэлжилсээр байна;

- Дээрх дайн, зэвсэгт тэмцэлд татагдан орох улс орны тоо өсөн нэмэгдэх шинжийг агуулж, цэргийн удирдлагад операц төдийгүй тактикийн түвшинд ч хамтарсан командлал байгуулагдах нь түгээмэл болох шинжтэй байна.

**Гуравт**, дайтагч талуудын аль алин нь зөвхөн IY үеийн зэвсэг, байлдааны техник хэрэгсэлтэй буюу XX зууны уламжлалт, нийтлэг цэргийн урлагийн түвшинд үндэслэсэн чиглэл юм. Энэ түвшний цэргийн операцын урлаг, тактикийн онол, аргагүй нь өнгөрсөн

зуунд явагдсан АНУ- Вьетнам; ЗХУ- Афганистан; Чечень дахь байлдааны ажиллагааны агуулгаар тодорхойлогдож байна.

Үүнд:

- Дайн, зэвсэгт тэмцэл нь орон нутгийн шинжтэй, эрчим багатай, эхлэхдээ нэлээд эрс шийдэмгий явагдах шинж чанартай болсон;

- Ийм дайн, зэвсэгт тэмцлийн ажиллагаа нь их гүрнүүдийн оролцоо, хяналтад орж удаан үргэлжлэхгүй шинжтэй;

- Нэлээд тохиолдолд дайн, зэвсэгт тэмцэлд шинэ нэр төрлийн зэвсэглэл, байлдааны техникийг өргөн хэмжээгээр биш ч гэсэн ашиглах хандлагатай байна.

Дээр дурдсан түвшин, чиглэлүүдийн хоёр дахь чиглэл болон уламжлалт гурав дахь чиглэлээр манай цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжилдөө өөрийгөө батлан хамгаалах төрийн цэргийн бодлогоо үндэсийг гол баримжаагаа болгож байна. Иймээс манай цэргийн эрдэмтэн, мэргэжилтнүүд ОХУ-ын зэвсэгт хүчний Афганистан, Чечень дахь, АНУ болон НАТО-гийн цэргийн Персийн булан (1991 он), Югослав (1999 он), АНУ-ын Афганистан (2001 он), Ирак (2001 он, 2003 он) дахь, Гүрж-Осетийн байлдааны ажиллагаа болон орон нутгийн зэвсэгт мөргөлдөөний туршлагыг анхааралтай судлан шинжилж байна. Энэ нь дээр дурдсан нэг дэх түвшин, чиглэлийг анхаарлын гадна орхино гэсэн санаа огтхон биш юм. Бид зургаа дахь үеийн зэвсэг, байлдааны техник хэрэгсэл бүхий улс орны цэрэгтэй хамтран дайн, байлдааны ажиллагаанд оролцож болзошгүйг үгүйсгэх аргагүй юм. Гэхдээ энэхүү дайн, байлдааны ажиллагааны магадлал манай улсын хувьд өндөр биш байна.

Бас дан ганц дөрөв дэх үеийн зэвсэглэл, байлдааны техник, хэрэгсэл ашиглан явуулсан Гүрж-Осетийн таван өдрийн байлдаан болон Оросоос Сирид явуулсан агаарын операцын туршлага, сургамжийг ч судалж байна.

Дээр дурдсан цэргийн урлагийн хөгжлийн түвшинд явагдсан дайн, байлдааны ажиллагаанд хэд хэдэн нийтлэг онцлог хадгалагдаж байна. Энэ нь дайны ажиллагаа жижгэрч, жижиг бүлгээр байлддаг болсон явдал. Мөн дайн байлдааны ажиллагаа гол төлөв хүч тэнцвэргүй байдалд явагддаг болсон явдал юм.

Цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжилд цэргийн зэвсэглэл, байлдааны техник хэрэгслээс гадна дам болон шууд нөлөөлж буй гадаад хүчин зүйлсэд:

- Дэлхий дахины нийгмийн байгуулалын хувьсал өөрчлөлт. Үүнд: социалист системийн задрал; янз бүрийн “цэцэг”-ийн нэртэй өнгөт хувьсгалууд; нийгмийн доторх ардчилал, хүний эрх, эрх чөлөөний төлөөх тэмцлийн үр дагавар; нэг туйлт ертөнцийг байгуулахын төлөө, өөрт “таалагдахгүй” буй улсын дотоод хэрэгт хүний эрхийг хамгаалах, ардчиллыг тогтоох, нэг удирдагчийн дарангуйлалт засаглалыг өөрчлөх нэр доорх халдлага, түрэмгийлэлдийн үр дагавар зэргийг дурдаж болох;

- Дэлхийн геополитикийн хувьсал, өөрчлөлт. Үүнд: нэг улс эсвэл нэг хэсэг улс орны улс төрийн бодлогын давамгайлал; дэлхийн болон бүс нутаг дахь зах зээлийн эдийн засгийн болон мэдээллийн ноёрхол; дэлхийн геополитик дахь цэрэг-стратегийн ашиг сонирхол; дэлхийн тэргүүлэх болон бүс нутгийн улс, гүрнүүдийн цэрэг-техник-технологийн байдал;
- Иргэншил хоорондын зөрчил. Үүнд: барууны крестын болон исламын шашин хоорондын зөрчил; барууны болон кунзын үзэл браимтлал хоорондын зөрчил; Өрнө ба дорнын иргэншлийн зөрчил.
- Мэдээллийн төлөөх даяаршсан тэмцэл. Үүнд “мэдээлэлд хэн ноёрхлоо тогтоож чадна тэр дэлхийг ноёрхох болно” гэсэн үзэл баримтлал даяаршиж, түүнийг эзэмших, ашиглах, түгээхийн төлөө улс үндэстэн бүхэн гол зорилт, үндсэн үйл ажиллагаагаа явуулж байна. АНУ-аас БНХАУ-ын Хуавэй компаны эсрэг явуулж буй бодлого нь эдийн засгийн дайнд шилжих хүртэл өргөжиж байгаас харж болно.
- дэлхийн тэргүүлэх болон тив, бүс нутгийн гүрнүүдийн цэрэг- зэвсэглэл, техникийн шинэчлэл, технилогийн хувьсгал. Энэ нь операцын урлаг, тактикийн хөгжилд хувьсгалын шинж чанартай шууд нөлөөллийг үзүүлж байна. Энэ тухай өмнө дурдсан болно.
- НҮБ болон Олон улсын бусад байгууллагууд дэлхий дахинд үүсээд байгаа олон улсын аюулгүй байдлыг сахиулах асуудлуудыг зохицуулах үүрэг хариуцлага.

Дээр дурдсан хүчин зүйлсийн агуулгыг товч дурдаад эдгээр нь цэргийн урлаг (оператив, тактик)-ийн урлагт хэрхэн дам болон шууд нөлөөлж буй асуудлыг авч үзье.

**Нэгд**, дэлхий ертөнц дэх хүн төрөлхтний нийгмийн байгуулалтын хоёр туйлт тогтолцоо арилж, нэг болон олон туйлт тогтолцооны төлөөх өрсөлдөөн тэмцэлдээн идэвхжиж, дэлхийн бүс нутгуудад зэвсэгт мөргөлдөөн, орон нутгийн дайн олширч эхэлсэн нь зэвсэгт тэмцлийг явуулах арга, хэлбэр, стратеги, операц, тактикт их өөрчлөлтийг оруулж байна. Дэлхийг хамарсан нийтийн том дайны аюул занал буурч байгаа ч, олон улсын хэмжээнд харилцан итгэлцэл бэхжих, улс төрийн сөргөлдөөнт байдал арилах, хамтран ажиллах, харилцан туслалцах хамтын аюулгүй байдлаа хамгаалах урьдчилсан нөхцөл бүрдэж чадаагүй байгаа нь гол нөлөө үзүүлж байна.

Гэсэн хэдий ч дэлхийн нийтлэг эрх ашгийн төлөө хамтрагч, холбоотон болж хувьсан өөрчлөгдөж нэгэн зорилго, үйл хэрэгт нэгдэн нийлж харилцан туслах, хамтран хамгаалах бодлого, үйл ажиллагаа бий болж байгаа нь монголын цэргийн урлагийн онолын агуулгад өөрчлөлт оруулахад нөлөөлж, шинэ бодлого, арга тактикийг эрэлхийлэхийг шаардах боллоо. Монголын Зэвсэгт хүчний төлөөлөл НҮБ болон бусад олон улсын энхийг сахиулах, дэмжих ажиллагаанд оролцож, дэлхийн халуун цэгүүдэд үүргээ амжилттай биелүүлж, тайван цагт

гүйцэтгэх үүрэгтээ удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын механизмд суралцаж, практик дадлагаа дээшлүүлж байна.

*Хоёрт*, дэлхийн тэргүүлэх улс орнуудын улс төрийн бодлогын нөлөө, хандлага нь цэргийн урлаг судлалд нөлөө үзүүлэгч субъектив нэг хүчин зүйл болж байна. Дэлхийн бодлого тодорхойлогч нөлөө үзүүлэгч гүрэн, бүлэглэлийн болон хөрш зэргэлдээх улсуудын төрийн бодлого, тэдний практик ажиллагаа нь манай улсын цэргийн батлан хамгаалах бодлогыг тодорхойлоход болон түүний агуулгад нөлөө үзүүлэх нэг хүчин зүйл болж байна. Дэлхийн болон бүс нутгийн нөлөө бүхий АНУ-ын хүч түрсэн цэрэг-улс төрийн бодлого, түүнийг сөрсөн ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх гэсэн улс төрийн бодлого зэргийн нөлөө доор тэдгээр улсууд батлан хамгаалах бодлого, цэргийн номлолдоо өөрчлөлт оруулж байгаа нь харилцан итгэлцэлийг бэхжүүлэх, хамтран батлан хамгаалах бодлого, үндэсний цэргийн урлагийн онолыг боловсруулахад харгалзан үзэх нэг үндэслэл болж байна. АНУ, БНХАУ-ын хооронд эдийн засгийн дайн дэгдээд байгаа нь дайныг өөр хэрэгслээр үргэлжлүүлж байгаагийн нэг илрэл бөгөөд улс төрийн бодлоготой нь холбоотой бодитой асуудал юм. Цэргийн судлаач бидний ойлголтоор ийм байдал хадгалагдах аваас энэ нь гибрид дайн “холимог дайн”-д шилжих нь тодорхой болно. Үүнийг өөрийн цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжилд харгалзахгүй байхын аргагүй байна. Дэлхийн эдийн засаг интегралчилал, даяаршилд орж, улс үндэстэн дамнасан олон улсын корпорациуд олширч, эд баялаг цөөнх улс, үндэстэнд төвлөрч, ядуу улс, үндэстэн олширч байна. Тэр хэмжээгээр ард түмэн төдийгүй, улс орнуудад ч давхараажилт үүсэх үйл явц идэвхтэй явагдаж, түүнийг цэргийн операц, тактикийн онол, аргазүйд харгалзан үзэх зайлшгүй шаардлага, хэрэгцээ бий болжээ. Манай орны эдийн засгийн чадавх хязгаарлагдмал тул хоёр их хөрштэйгээ хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж байгаа ч, АНУ-ын “мянганы хөгжлийн сан”-гаас дэмжлэг авч, дэлхий дахинаа шийдвэрлэх нөлөө үзүүлж “хэт их гүрэн” хэмээн нэрлүүлээд байгаа бодлогоороо, ганцаар ноёрхох, Азид нөлөөгөө хадгалах оролдлогыг хэсэгт хугацаанд хадгалахад нь манайх дэмжээд байгаа мэт сэтгэгдлийг хөрш гүрнүүддээ өгч байна. Энэ нь үндэсний цэргийн урлаг (операц, тактик) хөгжүүлэхэд дам нөлөө үзүүлж байна. Үүнийг цаашид харгалзаж, засаж залруулах асуудал яах аргагүй мөн гэж судлаач бид үзэж байна. Манай улсын газар зүйн байршил дэлхийн геополитик, цэрэг стратегийн ашиг сонирхлын гадна оршихгүй нь мэдээ юм. Дэлхийн, бүс нутгийн хоёр их гүрний хүрээлэлд манай улс оршдог, газар зүйн байршилтай. Геополитикийн ашиг сонирхол зөвхөн Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээгээр хязгаарлагдахаа больж, шинэ эрин зууны цаг үед дэлхийн аль ч тив, бүс нутгийн улс төр, цэрэг- батлан хамгаалах, нийгэм, соёл, эдийн засаг, мэдээллийн олон хүчин зүйлсийн нөлөө, тусгал дор геополитикийн ашиг сонирхол үйлчлэх болоод байна.

**Гуравт,** иргэншил хоорондын зөрчил, үндэстний асуудлыг дайн, байлдааны эх сурвалж болох талаас нь өнөө үед харгалзан үзэхээс өөр аргагүй байдалд хүрчээ. Түүхэн байдал, орчин цагийн бодит үйл явдлаас харахад дайн, зэвсэгт мөргөлдөөнүүд соёл иргэншлүүдийн зааг, хязгаар, тэдгээрийн хилийн шугамаар болж, аль эрт үүссэн барууны ба исламын соёл иргэншлийн заагаар өнөөдөр ч цэргийн сөргөлдөөн, мөргөлдөөн үүссээр, тэр байтугай исламын шашны (гол төлөв) үзэлт террорист алан хядагчид барууныхны эсрэг аллага, халдлага хийж, барууныхан ч терроризмын эсрэг дайнаа үргэлжлүүлсээр байна.

“Хүйтэн” дайны үргэлжлэл болсон орчин үеийн терроризмын дайн үүсэх, гарах боломж нээлттэй болж, түгээмэл шинжийг агуулах боллоо. Тиймээс Ази, Номхон далайн бүс нутгийн, тэр тусмаа Евразийн геополитикаар хязгаарлалтгүй, дэлхийн геополитикийн далайц хэмжээг харгалзсан цэргийн батлан хамгаалах бодлого, түүнд зохицсон цэрэг-улс төрийн үйл ажиллагааг явуулж байх нь чухал болохыг харуулж байна. Ийм учраас олон улсын цэрэг-улс төрийн дээрх нөхцөл байдлыг харгалзсан үндэсний цэргийн урлаг (операц, тактик)- ийг боловсруулахгүй, хэрэгжүүлэхгүй байх үндэс үгүй юм.

**Дөрөвт,** Мэдээллийн дайн, тэмцэл нь улс гүрнүүдийн улс төрийн бодлогын үргэлжлэл, түүнийг өөр хэрэгслээр явуулж буй хэрэг, мэдээлэлд ноёрхлоо тогтоохын төлөөх тэмцэл болж байна. Мэдээллийн дайн нь мэдээллийг тэмцлийн нэг төрөл хэлбэр, хэрэгсэл болгож байна. Энэ л учраас мэдээллийг цэргийн урлаг, түүний операц, тактикийн онол арга зүйтэй холбон авч үзэж, энэхүү дайн, зэвсэгт тэмцэлд ялалт байгуулах урлагийг судлан хөгжүүлэх шаардлага үүсч байна<sup>59</sup>. Өнөө үеийн дайн “сүлжээ төвт дайн” болж байгааг цэргийн мэргэжилтнүүд тайлбарлаж байна. Энэ дайны стратеги, операц, тактикийн хөгжил өнөө үед эрч хүчээ авч байна.

**Тавд,** дэлхийн тэргүүлэх болон тив, бүс нутгийн гүрнүүдийн цэрэг- зэвсэглэл, техник нь шинэ технилогоор тогтмол шинэчлэгдэн сайжруулагдаж байна. ОХУ-ын зэвсэгт хүчин шинэчлэгдэж, сансарын хамгаалалтын орчин үеийн хэрэгслэлд тулгуурласан “үл баригдах” шинэ пуужинтэй болж, ай, төрлийн цэргийнхээ нэгдэл, нэгтгэлийг шинэ загварын зэвсэглэл, байлдааны техникээр хангах ажлыг эрчимжүүлж, ердийн зэвсэглэлийн талаарх мэдээллийг хаалттай болгосон нь бүс нутгаар хязгаарлахгүй дэлхий дахины цэрэг-зэвсэглэл, техникийн байдалд нөлөө үзүүлж байна. АНУ болон НАТО-гийн улсууд Агаарын цэргийнхээ хүч, хэрэгслийнхээ үндсэн бүрэлдэхүүнийг эх газрын гүн тийш байршуулж, нэн өндөр цэцтэй

---

<sup>59</sup> Паламдорж.Ш “Мэдээллийн дайн, түүнээс хамгаалах”. УБ., 2003 он. х-162;



зэвсэг (НӨЦЗ) болон шинжлэх ухаан технологийн дэвшил, физикийн шинэ зарчимд үндэслэсэн зэвсгийг зохион бүтээх, турших, зэвсэглэлдээ нэвтрүүлэхийг чухалчилж байна. БНХАУ-ын ХАЧА-ын зэвсэгт хүчинд оперативын шуурхай хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, сансар дахь объектыг нэн өндөр цэцтэй пуужингаар сөнөөх чадвартай болгох, батлан хамгаалах зардал, чадавх нь жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа зэрэг олон хүчин зүйлийг хэлж болохоор байна.

*Зургаад*, НҮБ болон Олон улсын бусад байгууллагууд дэлхий дахинд үүсээд байгаа олон улсын аюулгүй байдлыг сахиулах асуудлуудыг зохицуулах үүрэг хариуцлага нэмэгдэж зөвхөн цөмийн дайнаар хязгаарлахгүй, хүн төрөлхтөнд аюул, занал учруулж байгаа байгаль, нийгмийн олон хүчин зүйлс нь зарим улс орны ард түмний ирээдүйдээ итгэх санаа сэтгэлийг зовоож, амьдралын орчин, нөхцөл боломжоо өөрчлөхийг шаардаж байна. Тийм ч учраас НҮБ болон Олон улсын бусад байгууллагуудын нийтлэг эрх ашгийг хамгаалсан бодлого, үйл ажиллагаанд нийцсэн үндэсний цэргийн урлаг (операц, тактик)-ийн онолыг боловсруулах нь зайлшгүй асуудал юм.

Монголын Улсын цэргийн урлаг, түүний дотор операц, тактикийн урлагт нөлөөлж буй гадаад объектив болон субъектив хүчин зүйлсийг товч агуулгаар дүгнээд үзэхэд монголын үндэсний цэргийн урлаг (операц, тактик)-т нөлөөлж буй гадаад хүчин зүйлс нь даяаржсан (глобал) шинжтэй, цаг хугацаа, орон зайн алс ирээдүйтэй холбогдсон, улс орны хөгжил, батлан хамгаалах бодлоготой нягт уялдаатай хэмээн үзэж болохоор байна.

## **§ 2.2. Операц, тактикийн урлагт нөлөөлж буй дотоод хүчин зүйлс**

Монгол Улсын Зэвсэгт хүчний үндсэн чиг үүргээ биелүүлэх чадавх нь болзошгүй дайсны авиац, нэн өндөр цэцтэй зэвсэг (НӨЦЗ)-ийн анхны бөөгнөрүүлсэн цохилтод байлдах чадавхаа хадгалан үлдэх замаар хариу ажиллагаа явуулах боломжийг тайван цагт бүрдүүлсэн түвшингээс ихээхэн хамаарах боллоо. Ямар ч тохиолдолд манай зэвсэгт хүчин болон түүний нэгтгэл, анги, салбарууд зайлшгүй тохиолдол тулгарч, эх орноо гадны халдлага, түрэмгийллээс хамгаалахад хүрвэл хүч, зэвсэглэлээр давамгайл “дайсан”-тай байлдааны ажиллагаа явуулах болно гэсэн номлолд тулгуурлан өөрийн цэргийн урлаг (операц, тактик)-ийн онол, практикийг түүнд зохицуулан хөгжүүлэх шаардлагатай болно гэж цэргийн урлаг судлаач бид үзэж байна.

Энэ үүднээс цэргийн урлаг (операц, тактик)-ийн онол, аргазүй, практикт нөлөөлж болохуйц дотоод хүчин зүйлст төр, нийгмийн байгууллын дэг журам, хууль эрх зүйт байдлын түвшин, зохион байгуулалт, улс төрийн бодлогын уламжлалт, залгамж чанар,

тогтвортой, тууштай байдал гэх мэт олон асуудлыг үндэсний цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжлийн нөлөөлөлд багтаан авч үзэхээр байна. Монгол Улсын Их Хурлаас “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг 2010 онд батлан гаргасан бөгөөд түүний агуулга дотор цэргийн аюулгүй байдлын асуудал тусгагдсан байх учиртай. Төр, засгийн болон цэргийн командлалын бодлого, үйл ажиллагаа төдийгүй, нийгмийн анхаарлын төвд цэргийн аюулгүй байдлын асуудал байнга оршиж байдаг.

“Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл мөн<sup>60</sup>” гэж уг үзэл баримтлалд заасан нь цэргийн арга, хэрэгслээр аюулгүй байдлыг хангах асуудлууд болох үндэсний язгуур ашиг сонирхол дахь монголын ард түмний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалахын эрэмбэ, зиндааг тогтоон өгсөн явдал юм. Үүнд цэргийн арга, хэрэгсэл зохих байр суурь эзэлж, нэлээд тохиолдолд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Цэргийн аюулаас ангид оршдог улс орон гэж бараг үгүй. Тиймээс үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгийг: хувь хүний, нийгмийн, оюун санааны, мэдээллийн, эдийн засгийн, экологийн, гадаад, дотоод, цэргийн гэж ангилах нь<sup>61</sup> түгээмэл байдаг.

Харин манай улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд, оршин тогтнохуйн аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, хүний аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал<sup>62</sup> гэж хуваан үзсэн байдаг. Хэдийгээр үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт “цэргийн аюулгүй байдал” гэсэн үг, үгүүлбэр байхгүй ч түүний агуулга нь оршин тогтнохуйн аюулгүй байдал, дотоод (нийгмийн Ш.П) аюулгүй байдал, хүний аюулгүй байдал зэрэг болон бусад бүрэлдэхүүн хэсгийн агуулгад багтаж байгаа гэж үзэж байна. Тиймээс энэхүү үзэл баримтлалын агуулгад шууд биш ч гэсэн шууд бусаар цэргийн аюулгүй байдлыг тусгасан байна гэж үзэж болох ч нийгэмд Монгол Улс “цэргийн аюул байхгүй цорын ганц улс” гэсэн “мессеж”-ийг түгээж байгаа мэт сэтгэгдлийг төрүүлж байна. Энэ “мессеж”, “сүүдэр” байгаа нь төр, засгийн удирдах албан тушаалд ажиллаж буй хүмүүс цэрэг, дайны болон аюулгүй байдлын асуудалд анхаарахгүй байх, тэр нь Зэвсэгт хүчний байгуулалт, цэргийн урлаг (операц, тактик)-ийн хөгжилд дам нөлөөлж байна. Үүнийг нотлон харуулах нэг жишээ бол Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийн талаар төрөөс баримтлах бодлого, стратегиз тодорхойлохгүй байгаа явдал юм. Зэвсэгт хүчин ямар зэвсэглэл, цэргийн техниктэй байна,

<sup>60</sup> Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.3. заалт;

<sup>61</sup> Гордиенко.Д.В, Баскаков.В.В. Основы экономической безопасности государства.т.10;

<sup>62</sup> Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;

түүндээ нийцсэн цэргийн урлаг (операц, тактик)-ийг хөгжүүлнэ гэдэг нь энэ дэд бүлгийн эхэнд дурдсан “цэргийн хэрэг дэх хувьсгал”- аас ойлгомжтой, тодорхой байна.

Орчин үед манай улсын цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсэг болох операц, тактикийн урлагт нөлөө үзүүлж буй асуудлууд нь улс орны маань хөгжлийн өнөөгийн бодит нөхцөл байдлаас болж нөлөөлөл үзүүлэх зарчмын хэд хэдэн онцлогтой байна гэж үзэж байна. Дараах нөхцөл, хүчин зүйлсийг манай цэргийн урлаг (операц, тактик)-т нөлөөлж байна хэмээн үзэж болохоор байна. Үүнд:

**Нэгдүгээрт**, улс орны улс төр, нийгэм, эдийн засаг өнөөгийн (манай төрийн байгууламжийн системийн өөрчлөлт бүрэн утгаараа төгөлдөржөөгүй, төр, засгийн газар, институтууд бүрэн төлөвшөөгүй, бодлого, үйл ажиллагаа нь тогтворжоогүй, нийгэм, эдийн засгийн хөгжил тэнцвэржээгүй, жигдрээгүй, савалгаа, давалгаа ихтэй) байдал үндэсний цэргийн байгуулалт, урлагт нөлөөлж байна;

**Хоёрдугаарт**, төрийн бодлого (Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал<sup>63</sup>, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал<sup>64</sup>, Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс<sup>65</sup>, Орон нутгийн хамгаалалтын талаар төрөөс баримтлах бодлого<sup>66</sup>, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал<sup>67</sup> зэрэг) нь улс орноо батлан хамгаалах бодлогыг тодорхойлж улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах талаарх хууль, эрх зүйн тогтолцоог - Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Аюулгүй байдлыг хангах тухай хууль, Батлан хамгаалах асуудлаарх багц хуулийг бүрдүүлээд байгаа нь үндэсний цэргийн байгуулалт, урлагийн хөгжилд эерэг нөлөө үзүүлж байна;

**Гуравдугаарт**, хөрш болон хамтран ажиллагч улс гүрэнтэй найрсаг харилцаа тогтоогоод байгаа нь үндэсний цэргийн байгуулалт, урлаг (стратег, оператив, тактик)-ийн хөгжилд ач холбогдлоо үзүүлж байна. Энэ нь цэргийн стратеги, операц, тактикийн хөгжил төдийгүй, улс төр, дипломатын аргаар батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд таатай боломжийг олгож байна. Харин хойд, урд хөршүүдтэйгээ цэрэг, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх гэрээ, хэлэлцээрийг байгуулж, итгэлцлийг бататгах ажил, арга хэмжээг хэрэгжүүлбэл улам ч эерэг нөлөө үзүүлэх болно;

**Дөрөвдүгээрт**, улс орны үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин, эдийн засгийн чадавх дээшлэх (улс орны эдийн засаг, төсөв сайжирч, эдийн засгийн үндсэн салбаруудын хөгжлийн

<sup>63</sup> Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;

<sup>64</sup> Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал;

<sup>65</sup> Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс;

<sup>66</sup> Монгол Улсын Их Хурлын 2007 оны 98 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого. Төрийн мэдээлэл сэтгүүл. 2007 он;

<sup>67</sup> Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралт. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

харьцаа олон улсын дундаж түвшинд нийцэхийн хэрээр батлан хамгаалах зориулалттай бүтээгдэхүүн, хэрэгслийн нийлүүлэлт дээшилж, батлан хамгаалах чадавх, цэргийн хэргийн хөгжил) нь эерэг нөлөө үзүүлнэ;

**Тавдугаарт**, цэргийн болон зэвсэгт хүчний байгуулалтаас цэргийн урлагийн хөгжил хамаарч байна. Ялангуяа зохион байгуулалтын бүтэц, зэвсэглэл, цэргийн техник, табель хэрэгслээс болон зэр зэвсэг, байлдааны техник, хэрэгслийн тоо, чанараас ихээхэн хамаарч байна (нэгтгэл, ангиудын орон тоо, зэвсэг, цэргийн техник, табель хэрэгслийн тоо, чанар өнөө үеийн Зэвсэгт хүчний үндсэн болон тайван цагт хүлээж буй чиг үүргийг биелүүлэх шаардлагад тэр бүр нийцэж, таарч тохирохгүй байна);

**Зургаадугаарт**, цэргийн урлаг (стратег, операц, тактик)-ийн онолын боловсруулалт, түүнийг цэргийн сургалт, практик ажиллагаанд нэвтрүүлж буй бодит байдал цэргийн урлагийн хөгжилд нөлөө үзүүлж байна. Монголын цэргийн урлагийг үндэсний шинжтэй, өвөрмөц стратеги, операцын урлаг, тактиктэй байхад онолын үндэслэл, гаргалгаа, тайлбар нэн чухал үүрэг гүйцэтгэнэ;

**Долоодугаарт**, цэргийн стратеги, операц, тактикийн шийдвэр гаргагч командлагч, захирагч нарын оюуны чадавх, зохион байгуулах ур чадвар, хэрэгжүүлэх үйл ажиллагаа (Зэвсэгт хүчний ай, төрлийн болон тусгай мэргэжлийн цэргийн командлал, даргалах бүрэлдэхүүний мэдлэг, чадвар, дадлага, тэднийг бэлтгэх, давтан бэлтгэх ажиллагааны цар хүрээ, төр, засгийн дээд албан тушаалтнууд, улс төрчдийн цэрэг стратегийн бэлтгэл, нийт эрчүүдийн цэргийн хэргийн бэлтгэлжилт)-аас цэргийн урлагийн хөгжил хамаарч байна;

**Наймдугаарт**, байлдах арга ажиллагаанд суралцсан цэрэг дайчдын дадлага, ур чадвар, эр зориг, эрэмгий чанар (Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын байлдааны бэлтгэл сургалт, ялангуяа жигдрэлтийн сургалтууд батлан хамгаалах төсвийн хүрэлцээгүй байдал, зэвсэг хүчний байгуулалтад гарсан алдаанаас болж шаардлагын түвшинд хүрэх хэмжээнд явагдахгүй байгаа) зэрэг нэлээд асуудал нөлөөлж байна.

Түүнчлэн орчин үед операц, тактикийн урлагт нөлөө үзүүлж буй обьектив, субъектив олон асуудлууд байна. Тухайлбал, **нэгдүгээрт**, улс орны хөгжил, үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин, эдийн засгийн чадавх, төсөв, санхүүгийн нөөц; **хоёрдугаарт**, зэр зэвсэг, байлдааны техник, хэрэгслийн хөгжил, тоо, чанар; **гуравдугаарт**, цэргийн урлаг буюу операц, тактикийн онолын боловсруулалт, түүний бодит чанар; **дөрөвдүгээрт**, цэргийн операц, тактикийн шийдвэрийг гаргагч захирагч, дарга нарын оюуны чадавх, зохион байгуулах ур чадвар, хэрэгжүүлэх үйл ажиллагаа; **тавдугаарт**, байлдах арга ажиллагаанд суралцсан цэрэг дайчдын дадлага, ур чадвар, эр зориг, эрэмгий чанар; **зургаадугаарт**, байлдааны ажиллагааны театр, байгаль, цаг уурын нөлөө, түүнийг эерэг ба сөрөг нөлөөлөлд байлдах чадвар; **долоодугаарт**, тухайн улсын шинжлэх ухаан, технологийн хөгжил, түүний

түвшин; *наймдугаарт*, байлдаан явуулагч талуудын ар тал, ард иргэдийн санаа сэтгэл, нийгмийн сэтгэл зүй г.м. олон хүчин зүйлс нөлөөлдөг болохыг орхигдуулж болохгүй.

Аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөн, байлдааны ажиллагаа нь өмнөө тавьсан улс төрийн болон цэргийн стратеги, операц, тактикийн зорилготой байдаг.

Зэвсэгт хүчин мэргэжлийн чиг баримжаатай хөгжиж эхэлсэн дотоод хүчин зүйлээс гадна орчин үеийн зэвсэгт тэмцлийн хэрэгслийн хувьсал, өөрчлөлт, шинэ зэвсгийн хөнөөлийн шинж чанар зэрэг нь үндэсний цэргийн урлагийг хөгжүүлэх үндэслэлийг нөхцөлдүүлж ирсэн юм. Шилжилт, шинэчлэлтийн гэж нэрлээд байгаа 1990-ээд оноос хойших он жилүүдэд олон улс, бүс нутагт явагдсан орон нутгийн дайн, байлдаан, зэвсэгт мөргөлдөөны ажиллагааг цэргийн шинжлэх ухаанд тулгуурлан операцын урлаг, тактикийн онол аргазүйд нийцүүлэн нөлөөлөх хүчин зүйлсийг авч үзвэл:

*Нэгдүгээрт*, Олон тооны ерөнхий зориулалтын томоохон бүлэглэл орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөнүүдийн туршлага, дэлхийн II дайны үеэс баримталж ирсэн операц, тактикийн урлагийн түвшингийн онол, аргазүйн зарчим, заавруудын сонгодог тактикийн ажиллагааны үндэслэлүүд нь орчин үеийн шинэ технологит суурилсан олон загварын зэвсэглэл, сүлжээт мэдээлэл, иргэншил хоорондын дайны нөхцөлд хэрэглэхэд олон байдлаар таарч тохирохгүй болох нь мэдрэгдэж эхэлсэн.

Түүний нэг тод илрэл нь Зөвлөлтийн Зэвсэгт хүчин, АНУ, НАТО-гийн цэргийн бүлэглэлээс Афганистаны партизануудтай, Чечень дахь террористуудтай явуулсан байлдааны ажиллагаануудын бодит үр дүнг харуулж байна. Партизанууд болон террористууд цөөн бүлгээрээ, нэгдмэл удирдлага зохион байгуулалтгүй, хэтийн зорилго, чиглэл, хандлагаа нэгтгэж, хүч тэнцвэргүй зэвсэгт тэмцлийг явуулж тодорхой зорилтуудаа биелүүлсэн явдал<sup>68</sup>;

*Хоёрдугаарт*, Зөвлөлтийн болон Оросын операцын явуулах хэмжээний цэргийн бүлэглэлээс явуулсан байлдааны ажиллагаанууд нь бодит байдал дээр янз бүрийн бүтэц, зохион байгуулалттай болон зохион байгуулалтгүй, хагас партизаны байгууллагуудтай байлдаж, үнэн чанартаа тактикийн хэмжээний байлдаан болж, үр дүнд хүрдэггүй байлаа. Ийм байлдааны “дайсны” тактик нь аравт, тавт, гуравт тэр ч байтугай хоёрт гэсэн бүтэцтэй, гавшгай ажиллагаатай, танктай ч, нисдэг тэрэгтэй ч, сонгодог бүтэц, зохион байгуулалттай цэрэгтэй ч байлдах чадвартай жижиг бүлэг, отрядууд байсан юм. Сонгодог тактикаар байлдаж сурсан тэдэнд хүч тэнцвэргүй бүлэг, бага бүтэцтэй жижиг бүлэгүүд санаанд оромгүй байдлаар ялалтад хүрч байсан явдал нь том сургамжид хүргэж байсан юм. Эндээс харахад, орчин үеийн дайн, байлдаанд сонгодог оператив, тактикаар, тэр тусмаа сонгодог бүтэц зохион байгуулалт, төлөвлөлтийг дээд штабаас хийж, оператив, тактикийн нэгжүүдээр

<sup>68</sup> Гареев.М.А “Афганская страда” М. 2002 г. -59 стр;

байлдах боломжгүй болсоны илрэл. Ер нь Афганистан, Чеченид явагдсан олон жилийн байлдааны ажиллагааг судалж үзэхэд, удирдлагын нэгжүүд бэлтгэлийн түвшингээр заавал эрэмбэ дээгүүр байх, захирах-захирагдах, удирдах-удирдуулах зарчим цэргийн анги, байгууллагад үнэн хэрэгтээ алдагдсан гэж үзэж болохоор байсан.

**Гуравдугаарт,** зэвсэгт хүчний ай төрөл, тусгай мэргэжлийн цэргийн сонгодог зохион байгуулалтын бүтэц (хороо, бригад, батальон)-аар Афганистаны партизануудтай, Чечень дахь террористуудтай идэвхтэй тэмцэл явуулахад, таарч тохирохгүй байдал тэдгээрийн байлдааны туршлага, сургамжаас илт харагдаж байснаас гадна хот доторх, уулан дахь гэх мэт байгалийн бартаат орчин, онцгой нөхцөлд дайн, байлдааны ажиллагааг эсрэг буюу санаачилагчаас гаргаж аль болох өөрт зохистой, дайсандаа халтай газар орон, байрлал эзэлж, цаг, улирал, хугацааны хувьд гэнэдүүлэлт үзүүлэх нөхцөлийг сонгон байлддаг болсон;

**Дөрөвдүгээрт,** аливаа дайн, байлдааны ажиллагаанд оюун ухаан, сэтгэл зүйн болон мэдээллийн тэмцлийн хэрэгслийн нөлөө ихсэж, ялангуяа хэвлэл, радио, телевиз, интернэт, цахим системээр үүсэж болзошгүй дайн, байлдааны ажиллагааны талбарт болж буй, болох гэж байгаа үйл явдлын талаар маш өргөн мэдээллийг олон нийтэд дайны талбарт байлдаж буй цэрэг дайчдын мэдэж буйгаас илүү өргөн мэдээллийг цаг алдалгүй хүргэж нөлөөллийн хүчин нэмэгдэж байна. Энэхүү өргөн мэдээллийг хүлээн авсан олон нийт дайны зорилго, учир шалтгаан, шалтаг, мөн чанарыг олон ургальч үзлийн байр сууринаас өөр өөрийнхөөрөө тайлбарлаж, ард түмний санаа сэтгэлийг нэгэн зорилго, үйлсэд чиглүүлэхэд бэрхшээлтэй болгосон;

**Тавдугаарт,** орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөн явагдаж буй улс, нутаг дэвсгэр, үндэстэн, түүний иргэншлийн төлөв байдал, ялангуяа шашин шүтлэг, зан заншил нь дайтагч талуудын цэргийн санаа сэтгэл, үйл ажиллагаанд хүчтэй нөлөө үзүүлж, үүсэл гарвал ойролцоо, хөрш зэргэлдээх улсад, зарим тохиолдолд улсынх нь бүрэлдэхүүнд багтаж буй ястан, үндэстний эсрэг зэвсэгт тэмцэл явуулах тохиолдолд зэвсэг барьсан цэргүүд байлдааныхаа үйл хэргийн төлөө тууштай байр, суурь эзэлж, байлдах боломжийг алдагдуулж байлаа.

Түүнчлэн дайн, байлдаанд ашиглаж буй зэвсэглэл, байлдааны техник, хэрэгслүүд улам боловсронгуй болж, цэргийн байлдах урлаг, арга, тактикийн ажиллагаа өөрчлөгдөхийн хэрээр цэргийн шинжлэх ухааны зарим нэршил, ойлголтын агуулга, ухагдахууныг зайлшгүй эргэн харж, судлан боловсруулалт хийх шаардлагатай болж, тулгамдаж буй асуудлууд олширсоор байна.

Орчин үеийн манай цэргийн урлаг нь ОХУ-ын цэргийн шинжлэх ухааны онол, аргагүйг ерөнхий чиг баримжаагаа болгон хөгжиж ирсэн. Энэ үүднээс цэргийн операц, тактикийн урлагт нөлөөлөх дотоод хүчин зүйлст:

1. Монгол Улсын Зэвсэгт хүчний төрөл, тусгай мэргэжлийн нэгдэл, нэгтгэл, ангийн байлдааны зэвсэглэл, техник үндсэндээ ЗХУ (хуучин нэрээр)-ын цэргийн аж үйлдвэрийн зэвсэглэл, техник, галт хэрэглэл, сэлбэг бүтээгдэхүүнээр хангагдсан бөгөөд цаашид шинэчлэх, орчин үеийн шинэ төрлийн байлдааны зориулалтын зэвсэглэл, техник хэрэгслээр хангах асуудал эхний ээлжинд ОХУ-д үйлдвэрлэгдсэн зэвсэглэл, техник, галт хэрэглэл, сэлбэг бүтээгдэхүүнээр хангах төлөвтэй байгаа;

2. Зэвсэгт хүчний ай, төрөл, тусгай, мэргэжлийн цэргийн нэгдэл, нэгтгэл, анги, байгууллага, цэргийг командлах, удирдах, даргалах бүрэлдэхүүний 90.0 гаруй хувь нь ЗХУ (хуучин нэрээр), одоогийн ОХУ-ын шат, шатны цэргийн их, дээд сургууль, академийг төгссөн, Зөвлөлтийн цэргийн шинжлэх ухааны онол, аргазүй, практикийг эзэмшсэн офицерууд Зэвсэгт хүчнийг үндсэндээ удирдаж байгаа бөгөөд энэхүү үйл явц уламжлагдан явагдах төлөвтэй;

3. Америк, европ маягийн цэргийн урлагийн онол, арга зүй сургаалтай, монголынхоо уламжлалт байлдах арга ухааныг ялангуяа операц, тактикийн түвшинд харьцуулан гүйцэд судалж, бие даасан онол, арга зүйг боловсруулж, ном бүтээл гаргаж чадаагүй байна;

4. Мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчний шинэ зориулалт, тайван цагт гүйцэтгэх үүргийн онцлогоос хамаарч, үндэсний уламжлалт тактикийн онол, аргазүйг өнөөгийн сонгодог тактик, орчин үеийн шинээр буй болж буй хүч тэнцвэргүй дайн, байлдааны тактикийн арга ажиллагаануудтай зохистой хэлбэрээр хослуулан ашиглах хэрэгцээг бусад улс орны цэргийн урлагийн ололт амжилтаас суралцах шаардлага байна;

5. Энхийг сахиулах, олон улсын террорист алан хядах бүлэглэлтэй тэмцэх, гадаадын улс оронд хүмүүнлэгийн тусламж, авран хамгаалах ажиллагаа явуулах зэрэг нь янз бүрийн улс орны цэрэгтэй хамтран ажиллах учир тэдний тактикийн онол, аргазүйгээс суралцан, хамтын ажиллагааг хөгжүүлэх хэрэгцээ нэлээд байна.

Энэ үүднээс цэргийн урлагийг хөгжүүлэх, даргалах бүрэлдэхүүний операц, тактикийн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх зорилгоор ОХУ, АНУ, БНХАУ, ХБНГУ, Япон, Турк, Солонгос зэрэг олон улсад цэргийн урлагийн онол, арга зүйгээс сургаж, бэлтгэж цэргийн хэргийн боловсролоо нэмэгдүүлж иржээ.

Ер нь аль ч улс орон бүрт цэргийн урлагийн судлагдахуунууд нэгдмэл, судалхуун адил төстэй байдаг учир тэдгээрийн аль алинаас суралцаж, онол, практикийг авах гээхийн ухаанаар ашиглаж, хэрэглэж, монгол цэргийн урлагийн онол, аргазүй, практикийг хөгжүүлэн дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Тэгэхдээ аль ч улс орны цэргийн их, дээд сургууль, академид очиж суралцсан гадаадынханыг сургаж бэлтгэх, заах, хэлэх асуудал нь тодорхой хэмжээнд, хязгаарлагдмал учраас цэргийн операцын урлаг, тактикийн онол нь улс орон бүрт үндэсний уламжлалт

хэлбэр, өнгө төрхтэй байдгаараа бусад шинжлэх ухаанаас ялгагдах тусгайлсан онцлогтой байдаг гэдгийг мартаж болохгүй юм. Учир нь дайснаа ялан дээлэхийн тулд байлдах зэвсэглэл, техник, операц, тактикийн арга ажиллагаагаа нууцалж, онол, аргазүйгээ хязгаарлагдмал хэмжээнд дэлгэж илэрхийлдэг нь зүй ёсны асуудал байна.

Иймээс шинээр төлөвшин буй монголын цэргийн урлагт нөлөөлөх гол хүчин зүйлсийн ойлголтын агуулгаас авахуулаад онол, арга зүйн тулгуур үндэс дээр шүүмжлэлтэй хандаж, операц, тактикийн урлагаа уламжлалд буй шилдэгтэй нь хослуулан хэрэглэх хэрэгцээ шаардлага байгаа нь дээрхээс тодорхой харагдаж байна.

Өөрийн улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжил, төрийн байгуулалтын шилжилтийн үеийн тулгамдаж буй зарим бэрхшээл, санхүү, эдийн засгийн чадавхаа харгалзан зэвсэгт хүчнийхээ байлдах чадвар, зэвсэглэл, байлдааны техник, хэрэгслийн хангамж, хэрэгсэлд үнэлэлт, дүгнэлтийг хийхэд улс орныхоо цэргийн аюулгүй байдлыг хангах хүрээнд болон тайван болон байлдааны цагт хүлээсэн үүргээ биелүүлэх хязгаарлагдмал боломжийг нэмэгдүүлэхэд үндэсний цэргийн урлаг, түүний дотор операц, тактикийн урлагт нөлөөлж буй хүчин зүйлсийг нь харгалзан зэвсэг, байлдааны техник, хэрэгслийн хангамж гэх мэтийн олон асуудлыг мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин болох өнөө үеийн шаардлагад нийцүүлэн шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага бий болжээ.

Үүний тулд эхний ээлжинд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх: *нэгд*, Хуурай замын болон Агаарын цэргийн байлдааны салбарын тоог нэмэгдүүлж, гэрээт цэргээр бүрдүүлэх, хяналтын нэгдсэн тогтолцоог хангах зэвсэг, техникийн хангамжийг сайжруулах; *хоёрт*, цэргийн удирдлагын холбоо, мэдээллийн аюулгүй байдлын техник, хэрэгслийг шинэчлэх; *гуравт*, НҮБ-ын энхийг сахиулахын анги гэхээсээ илүүтэй олон талт тусгай үүрэг гүйцэтгэх болон олон улсын террорист халдлага, үйлдлийн эсрэг зэвсэгт тэмцлийг явуулахад оролцох цэргийн анги, салбарыг байгуулж, бие бүрэлдэхүүнийг үүрэг, зориулалтын дагуу зэвсэглэл, техник, хэрэгслээр хангах гэх мэт асуудлуудыг авч үзэх нь чухал байна.

Монголын цэргийн операц, тактикийн урлагийн уламжлагдан ирсэн арга ажиллагааг учирч болзошгүй цэргийн түрэмгийлэлийн онцлог байдалтай харьцуулан судалж, үзвэл:

*Нэгд*, “Монгол Улсад учирч болзошгүй цэргийн түрэмгийлэл нь орон нутгийн шинж чанартай хязгаарлагдмал орон зайд, явцуу зорилготой байх магадлал өндөртэй юм. Энэ нөхцөлд зэвсэгт тэмцэл явуулах арга хэлбэр нь хүйтэн дайны үед Европын байлдааны ажиллагааны театрт төсөөлөгдөж байсан сонгомол операц, байлдаанаас өөр байх”<sup>69</sup> болж байна. Өөр байх магадлал ихсэж байгаа болохоор сонгодог тактикийн ажиллагаанаас гадна

<sup>69</sup> Шагдар.Б “Гадны цэргийн түрэмгийллийг няцаахад зэвсэгт хүчнийг ашиглах нь” (Цэргийн ухааны докторын зэрэг горилсон ажил). УБ., 1999 он. х-124., т-83-84;



зэвсэгт тэмцлийг явуулах шинэ арга тактикийн онол, аргазүй, практикийг боловсруулах хэрэгцээ шаардлага зайлшгүй байна;

**Хоёрт,** Орчин үеийн зэвсэгт тэмцэл гол төлөв партизаны ажиллагааны тактикийг хэрэглэсэн, байнгын бус, хууль бус зэвсэглэсэн байгууллагууд, тэдний төлөөлөл болох жижиг бүлгүүдтэй явагдах шинж төлөвийн хандлагыг агуулж байна. Ямар дайсан байна түүнд таарч тохирсон хүч хэрэгсэл, арга тактикаар байлдахаас өөр аргагүй байдаг. Орчин үеийн зэвсэгт тэмцэл нь хүч тэнцвэртэй бус хүчнүүдийн хооронд явагдах нь олонтоо тохиолдож буй бөгөөд өөрийн гэсэн онцлог операц, тактикийн онол аргазүйтэй болж байна;

**Гуравт,** Афганистан, Чеченьд явагдсан дайн, байлдааны туршлага, сургамжаас харахад, фронт тодорхойгүй, байлдааны өвөр эгнээ, ар талын зааг ялгагдахгүй, уул, тал, говь хосолсон газар орон дээр замгүй, тоос ихээр босдог, усны олдоц, нөөц хязгаарлагдмал нөхцөлд байлдааны ажиллагаа голомтолсон байдлаар явагдах үед байлдааны хүнд техник, хэрэгслийг ашиглах, бүх төрлийн хангалт хүргэх боломж тун хязгаарлагдмал байсан. Түүнчлэн мотобуудлагын хороо, дивиз мэт томоохон нэгтгэл, ангийг бүрэн бүрэлдэхүүнээр нь байлдаанд ашиглах, үүрэг гүйцэтгүүлэх тохиолдол тун ховор байжээ.

Энэ байдал нь мотобуудлагын хороо, дивизийн бүтэц, зохион байгуулалтыг юуны өмнө өөрчлөх, операц, тактикийн ажиллагаандаа зохицуулалт хийж, зэвсэгт тэмцлийн хэрэгслийг түүнд бас зохицуулах шаардлагыг буй болгожээ. Нэгэнт байлдааны ажиллагаа голомтолсон байдлаар өргөн дэлгэр нутаг дэвсгэрт “өргөтгөсөн талбарт” явагдаж, голомт хоорондын зай завсар, байлдааны журам хоорондын зайг ихэсгэж, нэгтгэл, ангиудад давших, хориглох зурвас заалгүй, гол төлөв хариуцлагын өргөн уудам бүс зааж байсан нь цэргийн урлагт ихээхэн нөлөөлөл үзүүлсэн байна;

**Дөрөвт,** манай орны газар зүйн нөхцөлтэй адил уул, тал, говь хосолсон газар орон дээр байлдааны ажиллагаа ороосон, тойрсон, отолт хийсэн, гэнэдүүлсэн, газар орны шинж чанарыг үр дүнтэй ашигласан байдлаар явагдсан байна. Энэхүү нөхцөл нь цэргийг байнгын удирдлагаар хангах ажиллагааг хүндрүүлээд зогсохгүй, байлдаан (радио холбоо, тагнуул )-ы болон бүх төрлийн хангалтыг “стандартын бус үүрэг” биелүүлэх ажиллагаанд шилжүүлэх, хүч хэрэгслийг нэмэх, ашиглалтыг өөрчлөх, зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудлыг дахин харахад хүргэж байжээ. Жишээлбэл, хариуцлагын бүс дэх цэргийн ажиллагаа нь тагнуул-хайгуулын, тагнуул-цохилтын аргаар явагдах, тулгуур бааз, сууринг эзлэх, нисэх буудал, төмөр болон авто замуудыг хориглон хамгаалалтад авах, цэргийн болон бусад цуваануудыг дагалдан хамгаалах ба хүч илүүтэй дайсантай отолтоор байлдах, түйвээх байлдаан хийхээс гадна байлдааны болон ар талын хангалтын анги, салбар, нэгжүүд ч өөрийгөө хамгаалах байлдааны ажиллагаа явуулах давхар чадавхтай байх, байлдааны

нэгжүүд ч хангалтаа бие даан явуулахад хүрч байсан зэргийг судлан харьцуулан авч үзэх нь зүйтэй юм.

Тиймээс дээрх байлдааны ажиллагааны дүр төрөхийг операц, тактикийн аргазүйн өнөө үетэй харгалзан үзэхээс аргагүй байна. Монгол Улсын Зэвсэгт хүчний явуулж болзошгүй зэвсэгт тэмцлийн зорилго нь болзошгүй түрэмгийллийн анхны цохилтыг тогтоон барих, дайсанд үлэмж хохирол учруулан туйлдуулах, цаг хугацаа хожих, хүчээ гамнах замаар цаашид тэмцлээ үргэлжлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх гэсэн урьдынхаас зарчмын өөр агуулгатай болж байгаагаараа онцлогтой болохыг тодорхойлсон<sup>70</sup>.

Манай цэргийн урлагийн байлдах тактикийн арга нь “өндөр эрчимтэй байлдаан, тулалдаанаас аль болох зайлсхийх”<sup>71</sup> явдал хэмээн тодорхойлж байлдааны ажиллагааны эрчмийн хэмжээг (Б.Шагдарын гаргасан итгэлцүүрийн хэмжээс) гурав ангилан үнэлгээ, дүгнэлт гаргасан нь дээр дурдсан Афганистан дахь байлдааны сургамжаас харахад ч тийм хэлбэрээр байлдааны ажиллагаа өрнөх төлөв байдал зонхилохыг үгүйсгэхгүй байна.

Иймээс манай зэвсэгт хүчний хуурай замын цэргийн явуулж болзошгүй байлдааны практик ажиллагаа нь монгол цэргийн урлагийн онол, аргазүйтэй нягт холбоотой байх учиртай болно.

Монгол Улс өөрийгөө хамгаалах зорилгоо цэргийн арга хэрэгслээр хэрэгжүүлэх үед явуулж болох зэвсэгт тэмцлийн хувилбарыг хэд хэдэн удаагийн КШХС-ийн туршилт, эрдэм шинжилгээний хурлаар цэргийн эрдэмтэн, судлаачдын дэвшүүлэн тавьсан дүгнэлтэд тулгуурлан тогтоосныг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ зэвсэгт тэмцлийг явуулах “сонгодог” аргаас буюу дан ганц операц, тактикийн онол, аргазүйд суурилснаас өөр арга, тактикийн ажиллагаагаар байлдааныг явуулах нөхцөл бүрдэхийг бас үгүйсгэх боломжгүй байна.

Монгол Улсын батлан хамгаалах бодлогоор “...Монгол Улс мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг зэвсэгт хүчнийг бүрдүүлж бэхжүүлнэ...”<sup>72</sup>, “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа болно”<sup>73</sup> хэмээн тодорхойлсон нь аливаа зэвсэгт тэмцлийг партизаны дайны арга хэлбэрээр явуулахад хүргэх болно. Ер нь орон нутгийн хамгаалалтын цэрэг, сайн дурын зэвсэглэсэн бүлэг байлдааны ажиллагааг явуулахдаа “нэг бодлого төлөвлөгөө”<sup>74</sup> удирдлагад захируулах бус бие даасан байдлаар явуулах нь олон

<sup>70</sup> Шагдар.Б “Гадны цэргийн түрэмгийллийг няцаахад зэвсэгт хүчнийг ашиглах нь” (Цэргийн ухааны докторын зэрэг горилсон ажил). УБ., 1999 он. х-124., т-84;

<sup>71</sup> Мөн тэнд, т-85;

<sup>72</sup> УИХ-ын 85 дугаар тогтоол. “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”. 2015 он., 2.4.1 дэх заалтаас;

<sup>73</sup> УИХ-ын 85 дугаар тогтоол. “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”. 2015 он., 2.4.2 дэх заалтаас;

<sup>74</sup> Шагдар.Б “Гадны цэргийн түрэмгийллийг няцаахад зэвсэгт хүчнийг ашиглах нь” (Цэргийн ухааны докторын зэрэг горилсон ажил). УБ., 1999 он. х-124., т-87;

улсын партизаны дайны ажиллагааны сүүлийн үеийн туршлагаар нотлогдоод байгаа тактикийн арга, хэлбэр юм.

Өнөө үед партизанууд томоохон бүтцийн нэгжээр, зэвсэгт хүчинтэй хамтран нэгдсэн бодлого, төлөвлөгөөний дагуу байлдааны ажиллагаа явуулж байсан дэлхийн II дайны туршлагаас татгалзаж, жижиг бүлгүүдээр, харилцан хамааралгүй, бие даасан байдлаар зэвсэг тэмцлийг явуулдаг болжээ. Тухайлбал, партизаны нэг бүлэг олзлогдох, ялагдал хүлээхэд бага хохирол амсдаг; партизаны бусад бүлгүүддээ хохирол үзүүлэх боломжийг хаадаг; дайснаа цөхрөлд оруулах, түүнд аюултай байдлыг тасралтгүй үзүүлэх боломжийг олгодог зэрэг хэд хэдэн давуу байдлыг бий болгож байна.

Манай улсын хувьд чадварлаг жижиг бүлгээр байлдааныг төлөвлөн явуулах боломжтой байна. Учир нь жижиг бүлгүүд хаана байрлаж юу төлөвлөж байгаа нь тодорхойгүй, гаднаас нь харж мэдэх боломжгүй, тагнуулчид олж илрүүлэхэд хүндрэлтэй байдаг учраас орчин үеийн нэн цэцтэй зэвсгийн хөнөөлд өртөхгүй байх боломжийг бүрдүүлж, ингэснээрээ байлдах чадвараа хадгалах нөхцөлийг бүрдүүлнэ.

Нөгөө талаар нэг байрлалд уддаггүй, үргэлжийн хөдөлгөөнд, маневрлаг боломжийг бүрдүүлж, дайсныхаа хүнд зэвсгийн хөнөөлд өртөхгүй байх бололцоотой байж, эсрэг талаа идэвхгүй, отолтын байдалд оруулж, гэнэдүүлэх, урьдчилан таамаглах боломж олголгүй, шөнийн цагт ч, цаг агаарын ямар ч нөхцөлд дайсандаа цохилт өгдөг онцлогтой болно.

Жижиг бүлгүүд тус тусдаа өөр өөрсдийн тавигдсан үүрэг, даалгаврыг биелүүлэх зорилгоор голомтолсон жижиг байлдааныг явуулж, дайсныг цэргийн томоохон нэгдэл, нэгтгэлээр байлдах боломжгүй болгож, галын бэлтгэл явуулах, зохион байгуулалттайгаар давших, сөрөг цохилт хийх, хүнд зэвсэг хэрэглэх нөхцөлгүй болгож, улмаар байлдааны ажиллагааны санаачилгыг жижиг бүлгүүд гартаа төвлөрүүлж, хадгалах давуу талыг бүрдүүлэх нь олонтоо байна.

Эндээс харахад, Монгол Улс нь өөрөө цөөн хүн амтай, томоохон газар нутагтай учраас Зэвсэгт хүчнээ нөхөн хангах хязгаарлагдмал нөөцтэй хэдий ч мэргэжлийн чадварлаг цэргийн хүчээр эх орон, хүний амийг хамгаалах асуудал гарцаагүй үндэсний монгол цэргийн урлагийн мөн чанарт хадгалагдах учиртай болох нь улсын маань түүхийн сурвалж дахь баримт, мэдээлэл үргэлж сануулдаг гэдгийг ойлгох ёстой байна.

Цэргийн судлаачид бидний төсөөллөөр зэвсэгт хүчний үндсэн нэгж (тасаг, салаа, рот, батальон, бригад)-ийн тогтолцоо хэвээр хадгалагдаж, харин жижиг бүлгүүдэд тавигдах байлдааны үүргээс хамаарч түр зохион байгуулалтын бүтцэд оруулах замаар асуудлыг шийднэ хэмээн үзэж байна. Энэхүү жижиг бүлгийг бүрдүүлэх, зэвсэглэх, бэлтгэх, сургах ажиллагааг тайван цагт хийж, байлдааны ажиллагаа явуулах операц, тактикийн онол, аргагүйг эзэмшүүлэх нь манай цэргийн урлагийн эрхэмлэх зорилтын нэг болж байна.

Дээрх зорилтыг хангаснаар:

- зэвсэг, байлдааны техник, хэрэгслээ чадамгай эзэмшиж, дайсанд үр нөлөөтэй цохилт хийх чадвартай болно;

- жижиг бүлэг хоорондын харилцан ажиллагааг төлөвшүүлж, харилцан уялдаа холбоо бүхий оператив, тактикийн зорилтыг хэрэгжүүлэх үндсийг бүрдүүлнэ;

- жижиг бүлгүүд дайсанд гэнэтийн цохилт өгч, байгаль, орон нутгийнхаа хамгаалах, халхлах онцлогийг ашиглан далдлагдах, хариу цохилтоос зайлсхийх арга ухааныг эзэмшинэ;

- эсрэг талынхаа ихээхэн хүч, бүлэглэлтэй зууралдсан байлдаан явуулахгүй, харин гэнэтийн дайралт, цохилт, ухралтыг байнгын хийх замаар сунжирсан байлдааныг явуулах чадварыг эзэмшинэ;

- жижиг бүлгийн гишүүд санаачилгатай, идэвхтэй, эрчимтэй ажиллах бололцоогоор хангагдана;

- жижиг бүлгийн гишүүд сэтгэл зүй, бие бялдрын өндөр бэлтгэлтэй болно;

- өөрийн ажиллагааг өнгөлөн далдлах, нууцлалтыг хатуу чанд сахих, холбоо, дохио дамжуулах арга ухааныг эзэмшинэ;

- орон нутгийн цэрэг, ард иргэд, зэвсэглэсэн бүлгээс дэмжлэг авч, нутгийн иргэдийн дотор “уусах” замаар нуугдаж, мэдээллээр хангагдаж, дараа дараагийнхаа ажиллагааны чиглэл, аргыг тогтоох чадвартай болно гэх мэт нөлөөллийг авч үзэх нь чухал байна.

Эндээс үүдээд Монголын төр, нийгмийн байгуулалт өөрчлөгдөж, улсын эдийн засгийн хэлбэршилд чанарын хувьсал явагдаж, монголын ард түмэн, үндэстний язгуур эрх ашиг шинээр илэрхийлэгдэх болж, манай зэвсэгт хүчний зориулалт, гүйцэтгэх үүрэг шинээр тодорхойлогдсон юм. Дээрх хүчин зүйлсийн нөлөө дор монголын цэргийн урлаг, түүний бүрэлдэхүүн хэсэг болох операцын урлаг, тактикийн онол, аргазүй шинэ агуулга, хэлбэрээр хөгжих үндэс бүрдсэн байна.

Өнөөгийн манай улс орны үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин, эдийн засгийн чадавх, цэргийн зэр зэвсэг, байлдааны техник, хэрэгслийн тоо, чанар, цэргийн урлагийн онолын боловсруулалт, түүний бодит чанар, шийдвэр гаргагчдын оюуны чадавх, зохион байгуулах ур чадвар, хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон эх орноо хамгаалах арга ажиллагаанд суралцсан цэрэг дайчдын дадлага, ур чадвар, эр зориг, эрэмгий чанар зэрэг нь юун түрүүнд цэргийн операц, тактикийн урлагт нөлөөлөх гол хүчин зүйлс болж байна.

Түүнчлэн манай зэвсэгт хүчин өөрийн цэргийн хүч хэрэгслээр бие дааж операцын үүрэг гүйцэтгэж болзошгүй тохиолдолд операцын урлаг нь цэргийн стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэж, тактикийн үүрэг, зорилго, хөгжлийн чиглэлийг тодорхойлох болно. Зөвлөлтийн цэргийн урлагийн үүднээс бус өөрийгөө хамгаалах зэвсэгт

хүчнийхээ хэмжээ, хүч бололцоо, нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан асуудалд хандах аваас операц, тактикийн урлагийг шинжлэн судлах нь чухал юм.

Туршлага, сургамж дээр тулгуурлан холбоотны цэрэгтэй хамтран сонгодог арга, тактикаар операц явуулах тохиолдолд энэхүү операцын урлагийн онол, практик хэрэгжих үндэстэй байна. Иймээс операцын урлагт нөлөөлж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлсийг судлах нь зүйн хэрэг юм.

Өнгөрсөн зууны сүүлч, шинэ мянганы эхэн үеэс цөмийн дайны аюул заналхийлэл багассан ч их гүрнүүдийн хүчний тэнцвэр хэвээр хадгалагдан үлдэж, тав, зургаа дахь үеийн зэвсэглэлээр явуулах хүч тэнцвэргүй шинэ дайны үндэс суурь тавигдаж эхэлсэн байна. Энэ нь цөмийн зэвсгийн эзэлж байсан байр суурийг цэрэг-техникийн хөгжлийн өндөр түвшин, цэрэг-эдийн засгийн чадавхад үндэслэсэн шинэ төрлийн хөнөөлийн ердийн зэвсэг болон байлдааны хэрэгсэл тухайлбал, нэн өндөр цэцтэй зэвсэг (НӨЦЗ), цэргийг болон зэвсгийг удирдах автомат систем, сансрын тагнуул, холбоо, радио электрон, мэдээллийн тэмцлийн хэрэгсэл өөрчилж, цэргийн операцын урлаг, тактикийн онол, аргазүйд нөлөөлсөн байна.

Иймээс өндөр хөгжилтэй, цэрэг-эдийн засгийн чадавх бүхий улс, гүрнүүдэд дэлхийн аль ч өнцөг булангаас хуурай газар, далай, тэнгис, агаарын орон зайд байрлуулсан НӨЦЗ-ийг алсын зайнаас хэрэглэн эсрэг талынхаа цэрэг-эдийн засгийн чадавхыг тодорхойлогч чухал объектуудад цохилт өгөх чадвар нэгэнт бий болжээ. Орчин үеийн дайн, байлдаан дахь цэргийн урлагийн хөгжлийн өнөөгийн ийм ерөнхий дүр төрх дэлхийн олон улс орны цэргийн урлагийг өөр өөрсдийн өнгө аястай хөгжихийг шаардаж байна.

Өөрийн улс орныхоо нийгэм, төрийн байгууллын шилжилтийн зарим бэрхшээл, эдийн засгийн хөгжил, санхүүгийн чадавхаа харгалзан зэвсэгт хүчнийхээ зэвсэг, байлдааны техник, хэрэгслийн хангамж, хамгаалах хүч хэрэгслийн асуудал нь цэргийн урлаг судлалд нөлөөлөх байдлаас үнэлэлт, дүгнэлтийг хийж, улс орныхоо цэргийн аюулгүй байдлыг хангах хүрээнд болон тайван цагт хүлээсэн үүргээ биелүүлэх боломж нь хязгаарлагдмал байна. Цаашид цэргийн урлагийн хөгжилтэй уялдуулан цэргийн зэвсэг, байлдааны техник, хэрэгслийн хангамжийн олон асуудлыг өнөө үеийн шаардлагад нийцүүлэн шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага бий болжээ.

## ГУРАВДУГААРБҮЛЭГ

### ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЦЭРГИЙН ОПЕРАЦЫН УРЛАГ, ТАКТИКИЙН ТУРШЛАГА, СУРГАМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

#### § 3.1. Дэлхийн зарим улс орнууд дахь “цэргийн операцын урлаг” хэмээх нэр томъёоны ойлголт, тодорхойлолтын талаарх харьцуулсан шинжилгээ:

“Цэргийн операцын урлаг” гэсэн нэр томъёоны ойлголт, тодорхойлолт нь стратеги, тактикаасаа илүүтэй нэлээд тохиолдолд төөрөгдлийг төрүүлсээр ирсэн байдаг. Өнгөрсөн түүхэн хөгжлийн явцад цэргийн операцын урлагийн талаар шууд ба шууд бус олон ойлголт, нэр томъёог ашигласаар ирсэн байна. Энэ нь цэргийн операцын урлаг, түүний зорилго, үүргийн талаар нэгдсэн ойлголтод хүрэхээргүй, олон маргаантай асуудал оршсоор ирсэнтэй холбон үздэг. Баримт дурдахад, зарим улс оронд их тактик (*grand tactic*) гэсэн нэр томъёог өнөөгийн цэргийн операцын урлагтай дүйцүүлэн үзэж, судалсаар ирсэн байдаг. Жишээ нь Францын генерал, цэргийн онолч Гибер, Жак Антуан Ипполит (1743-1790) анх удаа “их тактик” гэсэн нэр томъёог ашигласан байдаг. Харин генерал Антуан Генрих Жоминигийн (1779-1869) хувьд дайны урлагийг их ба бага гэсэн хэсэгт хуваан авч үзсэн байдаг. Түүний үзэж байснаар их тактикийг - “байлдаанд бэлтгэх болон явцыг хослуулах урлаг” гэж тодорхойлсон байдаг. Энэ хослуулах тактикийг мөрдөх зарчим, стратеги нь сөргөлдөгч хүчний эсрэг их хэмжээний хүчийг гэнэт ашигласны үндсэн дээр чухал үр дүнд хүрэх явдал гэж үзсэн байна. Түүний авч үзэж буй “бага тактик” нь өнөөгийн “тактик” гэсэн ойлголттой ижил байдаг. Английн генерал Ж.Ф.Ц Фүлер (1878-1966) операцын онолын талаар нэлээд бүтээл бичсэн байдаг бөгөөд Гибер, Жомини нарын адил “их тактик” гэсэн нэр томъёог ашиглаж, түүнийгээ стратеги, тактик хоёрын дундах ухагдахуун гэж үзсэн байдаг. Тэрээр “их стратеги нь улс төрийн зорилготой шүтэлцээтэй байх бөгөөд операцаар бүтцээ бий болгож, бага тактикаар хэрэгжүүлдэг” гэсэн байна.

1866 оны үед Прүссийн цэргийн их жанжин, фельдмаршал Хельмүт фон Молк Елдер операц гэсэн нэр томъёог анх хэрэглэхдээ стратеги, тактикийн дундах түвшин гэж авч үзсэн бөгөөд операцыг үндсэн байлдаанд орохын өмнөх цэргийн хүчний хөдөлгөөн гэж, харин стратегийг үндсэн байлдаан гэж үзжээ<sup>75</sup>. Мөн тэрээр Германы цэргийн онолд оператив гэсэн нэр томъёог гаргаж энэ нь дайн, байлдааны ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд чиглэж байсан бөгөөд XIX зуунаас Германы цэргийн онол, практикт хэрэгжүүлж ирсэн байна. Өнөөдөр Германы цэргийн урлагт операцын удирдлага, хяналт гэсэн нэр томъёо өргөн хэрэглэгдэж байна.

<sup>75</sup> Besterhorn, J. (1999) ‘Freie Operationen’-zur Bedeutung eines neuen Begriffes im Rahmen der operativen Schulung des Heeres. Hamburg, Führungsakademie der Bundeswehr;

XX зууны эхээр ОХУ-ын цэргийн онолчид мөн их тактикийг стратеги, тактикийн дундах түвшин гэж үзсэн бөгөөд үүнд Молк Елдериин онолыг орчуулагчдын нөлөө ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. 1904-1905 онд Орос-Японы хооронд явагдсан дайны туршлагад үндэслэн “оператик” буюу операц гэсэн нэр томъёог гарган тайлбарлаж ирсэн бөгөөд стратегийн хувьд дайнд оролцох, операцын хувьд армийн түвшинд байлдааны ажиллагааг явуулах, тактикийн хувьд армийн корпус, түүнээс бага нэгжээр байлдааны ажиллагаанд оролцох явдал гэж үзсэн байна.

Үүнээс хойш ЗХУ болон социалист системийн бусад улс оронд операцын урлаг (Хятадад кампанийн шинжлэх ухаан) гэсэн нэр томъёог өргөн ашиглаж ирсэн байна. ЗХУ-ын цэргийн онолч Александр А.Свечин өөрийн “Стратеги” номондоо тактикийн ажиллагаа нь операцын урлагт захирагдан, байлдааны ажиллагаа нь дангаараа тогтнохгүй, операцын нэг хэсэг мөн, гэхдээ ховорхон тохиолдолд нэг тулаанаас эцсийн үр дүнд хүрэх тохиолдол байж болох талтай гэж дурджээ<sup>76</sup>. Түүний үзсэнээр операцын урлаг нь операцын онол, практикийг судлахад чиглэгдэх ёстой гээд “Операц нь дайны тодорхой театрт зарим зорилгыг саадгүйгээр хангахад оршино” гэж тодорхойлжээ.

Свечины операцын урлагийн ойлголтыг ЗХУ 1920-1991 оны хооронд бараг тэр чигээр нь хадгалж ойлгож ирсэн байна. Түүнээс хойш ОХУ-ын цэргийн эрдэмтэд үндэсний түвшний цэргийн бодлого, номлолоос байлдааны тактикийн ажиллагаа хүртэлх шат дараалсан цогц загварыг боловсруулан гаргасан байна.

Эдгээрээс операцын урлаг судлалд дараах асуудлыг хамруулж иржээ. Үүнд:

- Орчин үеийн операцын шинж чанар, хэлбэр, зүй тогтлын судалгааны асуудал;
- Байлдааны ажиллагааг явуулах, бэлтгэх арга хэрэгслүүд;
- Зэвсэгт хүчний нэгдэл, нэгтгэл зэрэг томоохон анги, салбарын үүргийг тодорхойлох;
- Байлдааны ажиллагааны үед удирдлага, харилцан ажиллагаа, аюулгүй байдал зэрэг бүх талын арга хэмжээ;
- Зэвсэгт хүчний нэгдэл, нэгтгэлийн бүтэц, зэвсэглэл, техникийн хэмжээг тодорхойлох;
- Удирдлага болон офицерын бие бүрэлдэхүүнд операцын сургалт, түүний мөн чанарыг ойлгуулах;
- Театрын байлдааны ажиллагааны үед операцад бэлтгэх зөвлөмжийг боловсруулах;
- Дайсан байлдааны ажиллагааны үед операц хэрхэн явуулах гэж байгаа талаар судлах зэрэг байна.

---

<sup>76</sup> Свечин. А.А . Стратегия. Военный Вестник. Москва. 1927. -200 стр;

Герман, Орос улсад операцын урлаг судлалыг системтэйгээр судлан авч үзэж байсан бол АНУ тухайн үед том хэмжээний нэгдэл, нэгтгэл болон флотын байлдааны ажиллагаанд оролцох төлөвлөлтийн дадлага, сургуульд анхаарлаа төвлөрүүлж иржээ. Үүний үр дүнд дэлхийн II дайны хэд хэдэн театрт төлөвлөлт, байлдааны ажиллагааг явуулахад ихээхэн бэлтгэл сайтай байсан байна. Гэсэн хэдий ч дайны дараах жилүүдэд бүх туршлага, сургамжаа мартсан байсан бөгөөд 1950 он гэхэд операцын урлагийг үл ойшоох хандлагатай болсон байна. Солонгосын дайны үед цөмийн зэвсэгт, 1960-аад онд зэвсэгт босогчтой тэмцэхэд илүү анхаарлаа хандуулж ай, төрлийн цэргийн хамтарсан сургалт, дадлагаас илүүтэйгээр хуурай замын цэрэгт тактикийн сургалт, дадлагад, тэнгисийн цэрэгт флотын сургууль, дадлагад, нисэх хүчинд стратегийн сургууль зэрэгт анхаарлаа хандуулж иржээ<sup>77</sup>.

Вьетнамын дайны дараагаар өндөр эрчимт дайнд бэлтгэхийн чухлыг ойлгож, үүнд операцын урлаг, түүнийг судлахад анхаарлаа хандуулж иржээ. АНУ-ын Хуурай замын цэрэгт голлох үүрэг ногдож байсан бөгөөд 1986 онд Канзасийн Форт Ливинвордод хуучин ЗХУ-г голлон судлах албыг байгуулж, 1991 онд энэхүү алба нь нэрээ өөрчилж гадаадын цэргийн судалгааны алба болсон байна. Энэхүү судалгааны алба нь ЗХУ-ын операцын урлагийг судлахад чиглэж байсан бөгөөд 1982 онд операцын урлагийн талаар номлолдоо анх тусгаж өгчээ. Жишээ нь 1986 онд операцын урлагийг АНУ-ын хуурай замын цэрэг нь “Стратегийн зорилгод хүрэхийн тулд цэргийн хүч, хэрэгслийг операц, байлдааны ажиллагааны театр дахь бүтэц, зохион байгуулалттай кампанит ажиллагаа” гэж тодорхойлжээ<sup>78</sup>. Энэхүү тодорхойлолт нь 2001 онд өөрчлөгдсөн бөгөөд операцын урлагийг “Цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төлөвлөлт, харилцан ажиллагаа болон тактикийн нэгжийн үр дүнтэй шүтэлцээ, уялдаа холбоотой кампанит ажиллагаагаар театрын стратегийн зорилгыг хангах явдал юм” гэж томъёолжээ<sup>79</sup>. Үүнээс хойш операцын урлагийн тухай тодорхойлолт хэд хэдэн удаа өөрчлөгдсөн бөгөөд 2010 онд “Операцын урлаг - захирагч, штабын мэдлэг, ур чадвар, туршлагаар цэргийн хүчийг стратеги, кампани болон операцыг зохион байгуулах бүтээлч санаачилга юм” гэжээ. 2017 оны FM 3-0 Operations болон (JP) 3-0 Joint Operations-д “Операцын урлаг нь - стратеги, кампани болон операцыг зохион байгуулахад цэргийн хүчийг ашиглах захирагч, штабын мэдлэг, ур чадвар, туршлага, бүтээлч байдал, хяналт, шинжилгээгээр хэрэгжих хамтарсан арга хэмжээний нэгдэл” гэжээ.

Операцын урлагийн ерөнхий тодорхойлолтыг авч үзвэл “Операцын урлаг нь цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд байлдааны ажиллагааны театр дахь стратегийн зорилтыг биелүүлэхэд чиглэсэн кампани, операцын төлөвлөлт, бэлтгэл, үйл ажиллагааны онол,

<sup>77</sup> Holder, L.D. (1990) Educating and Training for Theater Warfare. *MilitaryReview*. 9 (1990);

<sup>78</sup> US DoA HQ. (1986) Field Manual 100-5, Operations. Washington, D.C.,;

<sup>79</sup> US DoA HQ. (2001) Field Manual 3-0, Operations. Washington, D.C.,;



практикийн нэгдэл” гэж хэлж болохоор байна. Иймээс операцын урлаг нь стратеги болон тактикийн нэг адил, урлаг төдийгүй тодорхой шинжлэх ухаан юм. Цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд операцын урлаг өөрийн гэсэн судлагдахуун, судлахуунтай, практик хэрэглээтэй, бодит зүй тогтлоор явагддаг нийгмийн онцгой үзэгдэл юм. Хэдийгээр практик хэрэглээ онолоосоо давамгайл шинжийг агуулдаг боловч онол нь ай, төрөл болон нэгдсэн ажиллагааны номлол боловсруулах үндэс суурь нь болж өгдөг.

Гэхдээ операцын урлагийн агуулга ай, төрлийн цэрэгт тодорхой ялгаатай байдаг бөгөөд энэ нь операц явуулах орчин, нөхцөл (газар, ус, агаар зэрэг), зэвсэг, байлдааны техникийн эрс ялгаа, операц, байлдааны явуулах стратеги, операц, тактикийн онцлогоос шалтгаалдаг. Хуурай замын цэрэг нь агаарын цэрэгтэй хамтран хэд зуу дахин олон бие бүрэлдэхүүн, зэвсэг, байлдааны техник хэрэгслийг ашиглан, газар орон, агаар, сансрын орчин дахь хүнд цагийн байдлын нөхцөлд байлдааны ажиллагаа явуулдаг учраас операцын урлагийн онол, практик түүнд илүү түгээмэл холбогдож, хөгжиж ирсэн байна.

Агаарын цэргийн цагийн байдлаас шалтгаалж хуурай замын цэргийн операц, байлдааны ажиллагаа нь хоёр орон зайн нөхцөлд, харин тэнгисийн цэргийн операц, байлдааны ажиллагаа агаар, усны гадарга дээр болон усан доор гэсэн гурван орон зайд явагддаг тулзэвсэг, байлдааны техникүүд нь өөр, операцын урлаг, байлдааны ажиллагаа нь өөр байх нь тодорхой юм.

Иймд операцын урлагийг практикт чадварлаг нэвтрүүлснээр чадамж, сургалт, дадлага болон цэргийн хүчийг удирдах арга барил дээшлэхээс гадна уялдаа, холбоо бүхий стратегитай байснаар хүчирхэг дайсныг ялах боломжийг нэмэгдүүлж өгдөг байна.

Дэлхийн зарим улс орнуудын “цэргийн операцын урлаг” хэмээх нэр томъёоны ойлголт, тодорхойлолт, агуулга, мөн чанарын харьцуулалтаас харахад, өнөө үед “операцын урлаг” хэмээх нэр томъёоны ойлголт, тодорхойлолт, агуулга нь нэгдмэл байдалд хүрч байгаа нь ойлгогдож байна.

### **§ 3.2. Дэлхийн зарим улс орнууд дахь цэргийн операцын урлагийн туршлага, сургамжийн шинжилгээ:**

Операцын үед удирдагч нь өөрөө операцын төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ удирдан хэрэгжүүлдэг хатуу журам дэлхийн улс орнуудын цэргийн операцын ажиллагааны үед тогтсон байна.

Цэргийн операцын ажиллагаа бие биенээсээ алслагдсан хэд хэдэн газар оронд нэг бодлого, нэгдмэл төлөвлөгөөний дагуу явуулах тохиолдол цөөнгүй гардаг. Ийм операцыг явуулахад нэгэн зэрэг хэд хэдэн районы цэргийн цагийн байдлыг тасралтгүй мэдэрч, операцад оролцож байгаа хүч хэрэгслийн харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах, аль ч

районд байлдаж байгаа цэргийн хүчийг ямар ч нөхцөлд хүч хэрэгслээр дэмжихэд бэлэн байх шаардлага цэргийн удирдлага, штабт тавигдах болсон нь хүндрэлтэй асуудлын нэг байсаар иржээ.

АНУ-ын тэргүүлсэн олон үндэстний цэргийн хүчний Иракт явуулсан цэргийн ажиллагаа нь ерөнхий зорилгын хүрээн дэх тодорхой зорилтуудыг шат дараалан шийдвэрлэх цэргийн ажиллагааны нэгдэл байсан байна. Энэхүү цэргийн ажиллагааг олон улсын цэргийн хүчний нэгдсэн операц гэж авч үзэх бөгөөд операцын зорилго, ашигласан хүч хэрэгсэл, гүйцэтгэсэн үүрэг зэрэг нь цэргийн сонгодог операцаас ихээхэн онцлог, ялгаатай байв. Тухайлбал:

- Операц нь давшилтын ба хориглолтын уламжлалт зорилгыг шийдвэрлэхээсээ илүүтэй ажиллагааны явцад дэвшигдсэн байлдааны ба тусгай үүргийг цаг тухайд нь шийдвэрлэснээрээ болон гүйцэтгэснээрээ;
- Операцыг явуулахдаа давамгайлал олж авах, сонгосон цохилт хийх, чиглэсэн хангалт зохион байгуулахад анхаарч байснаараа;
- Операцын урьтал болгож мэдээллийн операцыг өргөнөөр явуулсанаараа;
- Орчин үеийн шинжлэх ухаан, технологийн амжилтад тулгуурлан бүтээсэн зарим шинэ зэвсэглэл, техникээ туршсанаараа;
- Операцыг тусгайлан бэлтгэсэн, зориулалтат хүчээр явуулсанаараа;
- Цэргийн нэгтгэл, ангиуд гол төлөв чухал байрлал, зангилааг эзэлж, нөлөөлөл, хяналтын хүрээгээ тэлэхэд чиглүүлэн цэргийн хүч хэрэгслийн байгууламжийг сонгосоноороо зэрэг хэд хэдэн зүйлээр ялгарч байв.

XX зууны сүүлч, XXI зууны эхэн үеийн орон нутгийн дайн, байлдааны ажиллагааны туршлага, сургамжаас “Зэвсэгт хүчний ангиудаас болон төрийн цэргийн бусад байгууллагаас татан авч нэгтгэн цэргийн түр бүлэглэл байгуулж, нэг бодлого, нэгдсэн төлөвлөгөө, нэгдмэл удирдлагаар явуулах байлдааны ажиллагаа нь цэргийн операцын нэг төрөл мөн болно” гэсэн дүгнэлтэд хүрээд байна.

Энэ нь фронтын операц, армийн операц гэсэн сонгодог операцаас гадна Зэвсэгт хүчний ай, төрлийн цэргийн болон төрийн цэргийн бусад байгууллагуудын нэгтгэл, ангиудаас бүрдүүлсэн цэргийн түр бүлэглэлээр нэг бодлого, нэгдсэн төлөвлөгөө, нэгдмэл удирдлагаар явуулах байлдааны ажиллагааг “цэргийн операц” гэж авч үзэх, түүнийг төлөвлөх, бэлтгэх, удирдан явуулахдаа цэргийн операцын урлагийн онол, практикийг хэрэглэх нь монголын үндэсний цэргийн урлагийн хөгжлийн нэг хандлага болохыг харуулж байна.

Иймээс сүүлийн үед явагдсан гадаадын зарим улс орны цэргийн операцын туршлага, сургамжийг судлан өөрийн үндэсний цэргийн операцын урлагийг хөгжүүлэхэд дөхөм болно гэж үзэж дараах харьцуулсан судалгааг хийлээ.

Операцийн туршлага, сургамжийн шинжилгээнд АНУ, ОХУ, НАТО зэрэг улс, холбоотны зэвсэгт босогчид, террорист бүлэглэлийн эсрэг хийсэн цэргийн операцийн ажиллагааг авч үзэх нь дэлхийн цэргийн операцийн урлагийн өнөөгийн өнгө төрхийг илэрхийлнэ гэж үзэж байна.

### **§ 3.2.1. АНУ-ын цэргийн хүчний явуулсан “Анаконда” операц**

Энэхүү цэргийн операц нь Афганистан улс дахь Аль Кайда болон Талибан зэрэг террорист бүлэглэлийг устгахаар АНУ болон Холбоотны хүчний “Тогтвортой эрх чөлөө” ажиллагааны эхэнд буюу 2002 оны 3 дугаар сард явуулсан цэргийн операц байсан байна. Цэргийн операцийн төлөвлөлтөд эхний ээлжинд Афганистаны Зүүн муж дахь Хост- Гардез-д байгаа Аль Кайда, Талибаны бүлэглэлийг устгах явдал байсан бөгөөд уг цэргийн операцад хошууч генерал Франклин Л. Хагенбэкээр удирдуулсан АНУ-ын 10 дугаар уулын дивиз оролцсон байна. Уг операц “алх, дөш” шиг сонгомол утгаар явагдахаар төлөвлөсөн байна. Уг дивизийн зарим нэгж, элементүүд 101 дүгээр агаар-десантын дивизтэй хамтран “дөш” мэт хаалт тавих, Афганы хүчин АНУ-ын тусгай хүчний дэмжлэгтэйгээр Ремингтон хөндий дэх тосгон дахь дайсныг “алх” мэт даран цэвэрлэх явдал байсан байна. Хэдийгээр “Шахикот” хөндийн 2500 метрийн өндөр уулархаг, байгалийн агуй, хязгаарлагдмал орц, гарцтай байсан явдал нь эсрэг талд эерэгээр нөлөөлж байсан байна. Энэ газар 1980 онд хуучин ЗХУ хоёр ч удаа ихээхэн хохирол амсч ялагдаж байсан сургамж өмнө нь байсан байна.

“Анаконда” цэргийн операцийн төлөвлөлтийн ажиллагаа нь хоёр шалтгааны улмаас агаарын дайралтыг багасгах шийдвэр гаргасан байдаг. Энэ нь *нэгдүгээрт*, тус суурин газар дээд тал нь 200 хүрэхгүй дайтагч байгаа гэж үзсэн, *хоёрдугаарт*, өмнөх “Тора Бора” операцийн үед агаарын дайралт нь газрын буюу хуурай замын цэргийн ажиллагаанд муугаар нөлөөлсөн гэж үзсэнд байна. Операцыг явуулахад дайснаас хүн хүчний хувьд харьцангуй илүүдээ итгэж, ойрын дэмжлэг үзүүлэх зориулалттай цөөн тооны “Apache” нисдэг тэрэг болон хөнгөн, дунд миномёт, ганц хүнд миномёттой байжээ.

Операцыг театрын удирдагч буюу Холимог хүчний агаарын хэсгийн захирагч, дэслэгч генерал Т.Михайл Мосли 2 дугаар сарын 25 хүртэл “Анаконда” операцийн талаар ямар ч ойлголтгүй байжээ. Үүний улмаас агаарын хэсгийн тухайн цагийн байдалд хариу арга хэмжээг авах боломж думтаг байснаас хуурай замын цэргийн ажиллагаанд хүндрэл учирсан байна.

Энэ бүгдээс “Анаконда” цэргийн операцийн ажиллагаанд агаар-газрын харилцан ажиллагаа хүндрэлтэй байсан бөгөөд дараах асуудлуудтай тулгарч байжээ. Үүнд:

1. Буруу ташаа тагнуулын мэдээ нь дайсны аюулыг дутмаг үнэлснээс гадна Афганы хүчний бодит байдлыг илрүүлж чадахгүйд;
2. Нэгдсэн болон холимог хүчний штабт хангалттай хүний нөөц байгаагүйд;

3. Удирдлага, хяналтын харилцан ажиллагаа дутмаг байснаас тухайн газар орон дахь төрөл, мэргэжлийн цэргүүдийн үүрэг тодорхойгүй байсанд;
4. Холимог хүчний болон агаарын хүчний операцын төвөөс агаарын дайралтыг хоцроож төлөвлөсөнд;
5. Дээд штабаас Афганистанд дэлгэсэн цэргийн хүчний төрөл, тоог харьцангуй цөөн илгээсэнд;
6. Афганы цохилтын хүч “Алх” хүч нь тулааны эхний өдөр ухарч, дан ганц хаалт хүч “Дөш”-ийг үлдээсэнд;
7. Төлөвлөгдсөн агаарын дайралт өөрийн цэрэгт хэт ойртсон тул цуцалсанд;
8. Агаарын бүрэлдэхүүний төлөвлөлт хуурай замын төлөвлөлттэй нийцээгүйд;
9. Цаг агаарын нөхцөл байдал хөдөлгөөнийг удаашруулж, агаарын дэмжлэгт нөлөөлсөнд;
10. “Шахикот” хөндийд явуулсан агаарын дайралт нь төлөвлөгөөгүй явагдсанд;
11. Дайсны галын довтолгоон, цаг агаарын нөхцөл байдлаас болж тулааны эхний өдөр 5-7 ширхэг “Apache” нисдэг тэрэг ажиллагаагүй болсонд;
12. Холимог хүчин болон тусгай хүчний хоорондын харилцаа муугаас агаарын дэмжлэг дутмаг байсанд;
13. Агаар-десантын удирдлага, хяналтын системн дутмаг байдлаас “Алх” төлөвлөгөөний гүйцэтгэлд саад учирсанд;
14. Газар болон агаарын хооронд холбооны бэрхшээл тулгарсанд;
15. Агаарын дайралт хийж буй онгоцууд зөвхөн нэг газар төвлөрсөнд;
16. “Шахикот” хөндийн газар зүйн байдал, дайсны тактикийн ажиллагаа, байршил нь тагнуулын мэдээ цуглуулах, бүтэмжтэй галын цохилт хийхэд ихээхэн хүндрэл учруулсанд;
17. Артиллери, миномётын галын хүрэлцээгүй байдлаас агаарын дэмжлэг авах хангалттай тооцоо хийгээгүйд;
18. Хүч хэрэглэх дүрмийн дагуу явуулсан нь хязгаарлагдмал байсан төдийгүй, өөрчлөх шаардлага гарахад заавал төвийн командлалаас зөвшөөрөл авах шаардлага гарсанд;
19. Агаарын дэмжлэгийн онгоцонд шаардлагатай зэвсэглэлийг байрлуулаагүйд гэсэн сургамжийг үлдээжээ<sup>80</sup>.

“Анаконда” цэргийн ажиллагаа нь 3 дугаар сарын 18-нд дуусгавар болсон бөгөөд АНУ-ын талаас 8 цэрэг алагдаж, 80 гаруй хүн шархадсан, эсрэг талаас 200 гаруй цэрэг алагдсан байна. АНУ-ын тал төлөвлөлтөө буруу хийсний улмаас уг хөндийд газардсан явдал нь дайсны “Үхлийн бүс”-д шууд орсон гэж үзжээ.

Операцын дайралтыг муу төлөвлөсний улмаас уг хөндийгээс террористуудыг зайлуулж

---

<sup>80</sup> Operation Anaconda: Lessons Learned or lessons observed?. Fort Leavenworth, Kansas 2009. Pg 9;

чадсан хэдий ч гол толгойлогчид, түүн дотор Осам Бин Ладен зугтсан гэж үздэг учраас операцийн ажиллагаа амжилтгүй болсон гэж дүгнэжээ.


“Анаконда” ажиллагаанд АНУ болон Холбоотны хүчний 30.000 цэргийн алба хаагч, эсрэг талд Талибан, Аль Кайда бүлэглэлийн 1000 гаруй террористууд оролцсон байна.

### § 3.2.2. ОХУ-ын цэргийн хүчний операц

#### § 3.2.2.1. ОХУ-ын цэргийн хүчний Чеченьд явуулсан операц

Чеченьд ОХУ 2 удаа томоохон цэргийн операц явуулсан бөгөөд эхнийх нь 1994-1996 оны хооронд амжилт муутай явагдсан байдаг. Хоёр дахь удаагийн операц нь 1999 онд явагдсан байна. Энэхүү терроризмын эсрэг 2 дахь удаагийн операц 1999 оны 10 дугаар сард эхэлсэн бөгөөд Басаев, Хаттаба нараар толгойлуулсан террорист бүлэглэлийг устгах зорилготой байлаа. Үүний улмаас Чеченьд 10 дугаар сарын 6-ны 00 цагт Масхадоны ерөнхийлөгчийн зарлигаар дайны байдлыг зарласан байна. Чечений цэргийн анги, салбаруудад дайралт хийх, харин холбооны хүчин Ичкерийн бүх хил, хязгаарыг хяналтандаа байлгах явдал байв.

Холбооны хүчний операцийн ажиллагааны үр дүнд 12 дугаар сар гэхэд Чечений тал газрыг тэр чигтээ хяналтандаа авч чадсан бөгөөд уулархаг орчинд болон Грозный-д Чечений 3000 орчим террористууд төвлөрөөд байсан байна. Террористуудыг устгахын тулд тусгай бүлэглэлийг бий болгосон бөгөөд террористуудын 3 хориглолтын бүсийг сэтэлснээр 2000 оны 2 дугаар сар гэхэд хотыг бүрэн хяналтдаа авсан байна.



3.1 дүгээр зураг. Чечений Грозный хот дахь террористуудтай ОХУ-аас явуулсан операцийн ажиллагааны төлөвлөлт

Чечений уулархаг районд төвийн бүлэглэлийг байгуулснаар баруун болон дорнод бүлэглэлтэй хавсран террористуудыг 2 дугаар сарын 29 гэхэд бүрэн дарсан байна<sup>81</sup>.

Энэхүү операцад ОХУ-аас 3000 цэргийн алба хаагчийн амь үрэгдэж, 8800 хүн шархадсан байдаг бол Чечений террористуудаас нийтдээ 15000 дайтагч амь үрэгдсэн байна<sup>82</sup>.

Чеченьд явуулсан ОХУ-ын цэргийн операцыг гадаадын судлаачид дүгнэн үзэхдээ улс доторх террорист бүлэглэлтэй тэмцэх ажиллагаа нь зөвхөн цагдаа, дотоодын цэргийн үүрэг болохоос зэвсэгт хүчний үүрэг биш гэж онцолж, шүүмжилж байсан байна<sup>83</sup>.

Грозный дахь террористуудын ихэнх нь оргон зайлж чадсаны улмаас сунжирч партизаны дайны байдалтай болсноор эрчимжилт ихээхэн суларч эхэлсэн байна. Хэдийгээр терроризмын эсрэг тусгай ажиллагааг 4 дүгээр сарын 16-ны өдөр албан ёсоор дуусгавар боллоо гэж Чечений ерөнхийлөгч Рамзан Кадыров зарлаж, “дайн дууссан үндэсний баярын өдөр” гэсэн боловч Шатой болон Веденьски районд гал зогсоогүй байсан байна<sup>84</sup>.



3.2 дугшаар зураг. Операцаар эзэлж амжаагүй Чечений Шатой болон Веденьски районы байршил

Үүний улмаас Чечень дэх терроризмын эсрэг ажиллагаа нь 2009 он хүртэл үргэлжилсэн гэдэг ч үнэн чанартаа 15 жил үргэлжилсэн партизаны дайн явагдсан байдаг.


<sup>81</sup> Контртеррористическая операция в Чечне 1999-2009 гг. Справка.26 марта 2009;

<sup>82</sup> Мөн тэнд;

<sup>83</sup> Война в Чечне глазами американских военных экспертов. <https://www.svoboda.org/a/24203508.html>;

<sup>84</sup> Чечне после отмены режима КТО произошло боестолкновение. Кавказский узел (17.04.2009).

ОХУ-аас Чечен дэх террорист бүлэглэлтэй явуулсан байлдааны ажиллагааны онцлог нь цэргийн бүлэглэл (нэгтгэл, анги, салбар) тус бүрд хариуцлагын бүс тогтоон өгч цэргийн ажиллагаа явуулсанд оршдог.



3.3 дугаар зураг. Чечен дэх цэргийн бүлэглэл (нэгтгэл, анги, салбар)-ийн хариуцлагын бүсийг тогтоосон байдал

Чеченд явуулсан операцын үр дүнд гэмт хэрэг, террорист ажиллагаануудыг таслан зогсоож, хар тамхи, боолын наймааг устгаснаас гадна хамгийн чухал нь Кавказад дэлхийн исламын террористуудын төв байгуулах төлөвлөгөөг нурааж чадсанд оршиж байна<sup>85</sup>.

### § 3.2.2.2. ОХУ-ын Сирид явуулсан цэргийн операц

ОХУ-ын цэрэг Сири улсад Сирийн засгийн газрын хүсэлтээр, зөвхөн “Исламын улс” террорист бүлэглэлтэй, сирийн хуурай замын цэргийн ажиллагаанд зөвхөн агаараас дэмжлэг үзүүлэх операцыг явуулсан юм. Энэ операцийг 2015 оны 9 дүгээр сарын 30-нд Сири дахь “Исламын улс” террорист бүлэглэлийн эсрэг цэргийн сансрын хүч өөрийн онгоцоор авиацийн цохилт өгсөнөөр эхлүүлсэн байдаг.

Сири улсад явуулсан ОХУ-ын цэргийн операц нь олон улсын, бүс нутгийн болон орон нутгийн зэрэг хэд хэдэн стратегийн зорилгыг агуулж байсан байна. Ялангуяа Сири дэх өөрийн цэрэг, улс төрийн ашиг сонирхлоо хамгаалах; Ливи улстай адил тогтсон дэглэмийг нуран унагаахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах; ОХУ-ын исламын шашинтай бүсээс ирсэн иргэдийг нутаг буцаах зэрэг зорилготой байжээ. Операцын хувьд Москвагийн оролцоо, ашиг сонирхлыг тухайн бүс нутагт хадгалах явдал байв.

<sup>85</sup> Владимир Иванов, как это было?, Вторая Чеченская Война, 27 Июня 2018;

ОХУ-ын цэрэг-улс төрийн удирдагчид “Сирид цэргийн операц явуулах нь ихээхэн сорилттой тулгарч байсан бөгөөд зүгээр нэг хэсэг, бүлэгтэй бус өндөр зохион байгуулалттай, маш сайн сургагдсан, зэвсэг, техникийн хувьд хангалттай террорист армитай тулах болсон, энэ нь ОХУ-д шууд аюул учруулах хор уршигтай” гэж үзсэн байна<sup>86</sup>. Тиймээс эдгээр дайснаа “Террорист бүлэг биш, шинэ зохион байгуулалттай, өнөөгийн гибрид дайсан” гэж тодорхойлсон байна.

Цэргийн операцыг том хэмжээнд явуулах зорилго агуулаагүй бөгөөд стратегийн хандлагыг эсрэг маягаар харуулах гэсэн оролдлого байсан. Үүнд: Асадын цэргийн хүчний эсрэг ажиллагаанд саад хийх, дэглэмийг хүчжүүлэх, сэргээх; эсрэг хүчнийг тараан бутаргах, сааржагжуулах зэрэг байв.

Агаарын цохилтыг эсрэг талын удирдлага, хяналтын систем, материал хангалтын сүлжээ, эдийн засгийн төв цэгүүд рүү хийсэн байна. Хуурай замын цэрэг нь агаарын цохилтын харилцан ажиллагаатайгаар тээврийн гол зам, дэд бүтцүүдийг хяналтдаа авсны зэрэгцээ хот, суурин газруудыг бүслэх, тусгаарлаж байх явцдаа эсрэг талыг системтэйгээр устгаж байсан байна.

ОХУ Сири дэх цэргийн операцад байлдааны дадлага, туршлагатай захирагч, дарга нарыг их хэмжээгээр явуулсан бөгөөд 2017 оны эцсээр 3 ээлжээр нийт 48.000 ЦАХ оролцуулсан байна. Захирагч, удирдагчид операцын нэгдсэн ажиллагаа, ай төрлийн цэргүүдийн харилцан ажиллагаа, тагнуул, удирдлага, хяналт болон галын цохилт зэрэгт ихээхэн туршлага хуримтлуулжээ.

Үүнээс гадна ОХУ-ын БХЯ нь Сири улс руу инженер, техникийн эрдэмтэн, судлаачдыг явуулж газар орон дээр шинэ зэвсэг, техникийг бодитоор хэрэглэж ихээхэн туршлагыг хуримтлуулсан байна. Иймээс ч Сирийг ОХУ-ын туршилт, судалгаа, инновацын инкубатор болгон ашигласан байна. Мөн анх удаагаа цэргийн хэрэгт мэдээллийн технологийн хувьсгалыг ашиглажээ. Энэхүү ойлголтыг хуучин ЗХУ-ын үед буюу 1980 онд цэргийн онолчид бий болгосон бөгөөд барууныханд “Огарковын номлол” нэрээр танигдсан байдаг.

Тусгай операцын хүчний командлал, нисэгчгүй нисэх аппарат (ННА), флот болон сансрын навигацын системийг ашигласан нь үр дүнгээ өгчээ. ННА-ыг ашигласнаар ерөнхий зориулалтын цэргийн операц, тактикийн түвшний байлдааны бүтэмж ихээхэн нэмэгдсэн байна. Нийтдээ 60-70 төрлийн ННА-ыг тагнуул, цохилт, радио-электроны тэмцэл буюу саатуулгад ашиглажээ.

---

<sup>86</sup> Красная Звезда, 24 декабря 2017г. Андрей Гавриленко, Александр Тихонов, Роман Бирюлин, “Армия останется несокрушимой”, , <http://archive.redstar.ru>;



Цаашдаа ОХУ-ын дээд командлал ННА-ыг бүх төрлийн байлдааны ажиллагаанд өргөн ашиглахаар төлөвлөж байна.

Сансрын навигацын системийг ашигласнаар удирдлага, хяналт болон ННА-ын далай, тэнгис, агаар болон газрын целийг илрүүлэх, устгахад дэмжлэг үзүүлж байсан байна. Энэхүү операцад: 21-27 ширхэг хиймэл дагуулыг ашигласан хэдий ч навигацийг удирдлага, хяналтын шаардлагыг хангалттай хэмжээнд өгч чадаагүй байна. Гэхдээ агаарын хүчин, тэнгисийн авиац, алсын тусгалтай бөмбөгдөгч зэрэг навигацын станцтай хэрэгсэлд навигацын чиглэгийг хангалттай түвшинд өгчээ.

ОХУ-ын Сирид явуулсан цэргийн операцын үр дүнд шинэ зэвсэг, техник, технологийг туршиж, операцыг явуулах шинэ хувилбарыг боловсруулан өргөн ашигласнаар ихээхэн туршлага хуримтлуулж сөргөлдөгч талуудынхаа анхаарлыг ихээхэн татаж, цэргийн сүр хүчээ гайхуулсан явдал болсон гэж үзэж болох юм.

Операцын үр дүнд “Исламын улс” террорист бүлэглэл бут цохиулж, Египет, Хойд Африкийн орнууд руу дайжсан байна.

### ***§ 3.2.3.НАТО-гийн цэргийн хүчний Югославын эсрэг явуулсан операц***

Югославын Холбооны Улс (ЮХБНУ)-ын эсрэг НАТО-гийн цэргийн агаарын операц 1999 оны 3 дугаар сарын 24 –нөөс 6 дугаар сарын 10-ны хооронд “Холбоотоны хүч” гэсэн нэр хаяг доор явагдсан юм. Энэхүү операцыг НАТО-гийн зүгээс явуулах болсон гол шалтгаан нь Косово дахь албани, серб үндэстэн хоорондын гарвал үүслийн зөрчилдөөн, сербчүүдийн талаас албаничуудын эсрэг явуулсан үй олноор нь хоморголон устгах ажиллагаа болсон юм. НҮБ-ын зүгээс 1998 оны 9 дүгээр сарын 23-ны № 1199 дугаартай тогтоол гаргаж, дээрх үйл ажиллагаагаа нэн даруй зогсоох, гэрээ хэлцэл байгуулахыг ЮХБНУ-аас шаардсан хэдий ч Югославын ерөнхийлөгч Слободан Милошевич татгалзсан юм. НАТО-гийн операц эхлэхэд, түүний агаарын хүчин 227 нисэх техник, түүнээс 192 бөмбөгдөгч, 63 хангалт-дэмжлэгийн онгоц, 19 тагнуулын онгоц, 3 нисдэг тэрэгтэй байлаа. Энэ кампанийг Европын улсуудын холбооны дээд штаб ерөнхий удирдлагаар хангаж байсан бөгөөд түүнийг америкийн генерал Уэсли Кларк (Wesley Clark) командадсан байна.

Шведийн ерөнхий сайд Ханс Йоран Перссоны санаачилгаар байгуулсан олон улсын бие даасан комисс: “НАТО-гийн зүгээс Югославын эсрэг явуулсан цэргийн агаарын операцыг “НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн зөвшөөрлийг урьдчилан авах ёстой байсан” гэсэн үндэслэлийг гаргаж, олон улсын эрх зүйг зөрчсөн ажиллагаа” гэж дүгнэсэн байдаг.

Югославт явуулсан НАТО-ийн цэргийн операц нь агаарын кампанит ажиллагаа байсан бөгөөд Сербийн дэд бүтэц, Косово дахь Сербийн цэргийн хүчнийг устгах, Косовогоос Сербийн хүчнийг гаргах, энхийг сахиулагчдыг оруулах, дүрвэгсдийг нутаг буцаах зэрэг

зорилготой ажиллагаа байв. Агаарын бөмбөгдөлтийн ажиллагаа 3 сар гаруй үргэлжлүүлсэн бөгөөд Кумановогийн гэрээ, хэлэлцээр хийгдэж НАТО-ийн “KFOR” ажиллагаа эхэлснээр дуусгавар болсон байдаг.

НАТО-ийн агаарын бөмбөгдөлтийн операц 1999 оны 03 дугаар сарын 24-ны өдөр эхэлсэн бөгөөд 29-ны өдөр гэхэд Сербийн нийслэл Белград НАТО-ийн бөмбөгдөлтөд бүрэн автсан байна. Гол байнд нь эхний ээлжинд цэргийн удирдлагын байрууд, агаарын довтолгооноос хамгаалах объектууд, дараа нь газрын тос боловсруулах үйлдвэр, радио, холбоо, телевизийн мэдээ дамжуулах байгууламжууд болон үндэсний эрчим хүчний сүлжээнүүд байв. Үүний улмаас Сербийн эрчим хүчний 70 хувь, газрын тосны 80 хувийн чадавхыг алдагдуулсан байна. Ингэснээр Милошевичийн эрх мэдэл буурч, ард иргэд нь ёс суртахууны доройтолд орсон байна. Дайныг эсэргүүцэгчдийн жагсаал газар авч “Үхсэн Косово бидэнд хэрэггүй” гэж орилцгоож байсан байна<sup>87</sup>. НАТО-ийн бөмбөгдөлтийн улмаас 500 гаруй энгийн ард иргэд, 1000 гаруй Сербийн ЦАХ үрэгдсэн байна.

НАТО-ийн агаарын операц 78 хоног үргэлжилсэн бөгөөд нийт 50.000 ЦАХ, 1259 онгоц, үүн дотроос АНУ-ын 983 онгоц оролцсон байна. Зэвсэглэлийн хувьд чөлөөт уналттай бөмбөг, төрөл бүрийн чиглүүлэгтэй удирдлагат пуужин, тэнгисийн далавчит пуужин “Томагавк” болон “CALCM” зэрэг байв. Энэхүү тактикийн аргыг НАТО өмнө нь 1991 онд Иракийн дайны үед ашигласан байдаг.

Олон улсын комисс НАТО кассетад бөмбөг хэрэглэснийг, НҮБ цацраг идэвхт хордуулалтыг бөмбөгдөлтөөр үүсгэсэн болохыг буруушаасан байна. Агаарын операцад нийтдээ 35219 нислэг, өдөрт дээд тал нь 679 нислэг хийж, нийтдээ 23.000 гаруй бөмбөг, пуужинг хаясан байна. Югославийн 995 объект сүйтгэгдэж, 22.000 тонн үхлийн металл хаягдсан байна<sup>88</sup>.

---

<sup>87</sup> Chuka Euka, “Extra-Territorial Consequences of NATO’s War on Serbia”, 2018;

<sup>88</sup> Операция НАТО «союзная сила» против союзной республики Югославии, <http://www.eurasian-defence.ru/?q=node/30100>;



3.4 дүгээр зураг. НАТО-ийн Сербийг бөмбөгдсөн байдал.

Дээрх зургаас харахад дан ганц Серби улс руу бус Черногор руу бөмбөгдсөн байна.

НАТО-ийн операцыг НАТО өөрсдөө хууль ёсны, зайлшгүй хийгдэх ёстой, өөрсдийн зорилгодоо хүрсэн ажиллагаа болсон гэж дүгнэсэн байна. Харин ОХУ энэхүү НАТО-ийн агаарын операцыг олон улсын хууль, эрх зүйн хоёр үндсэн зарчмыг зөрчсөн эмгэнэлтэй сонгодог жишээ болсон гэж үздэг. Үүнд, *нэгдүгээрт*, үндэстний тусгаар тогтнох эрхийг хязгаарласан, *хоёрдугаарт*, улсын хилийн халдашгүй дархан байдлыг зөрчсөн гэж үзсэн байна.

Энэхүү агаарын операц нь: НҮБ-ын Аюулгүй зөвлөлийн шийдвэргүй, хүний эрхийг хамгаалах нэрийн доор ямар ч улсын дотоод хэрэгт эрээ цээргүйгээр оролцож, цэргийн ажиллагаа явуулж, нэгд, олон улсын эрх зүйг зөрчиж болохыг дэлхий нийтэд харууллаа. Хоёрт, агаарын цэргийн хүчин өнөө үеийн зэвсэгт тэмцэлд голлох үүрэгтэй болохыг цэргийн хэрэг, байлдааны ажиллагаа талаас нь харууллаа. Гуравт, НАТО-д америкийн оролцоо ямар хор уршиг дагуулж болохыг харууллаа. Дөрөвт, тусгаар тогтносон улсын дотоод хэрэгт оролцож, төр засгийн удирдлагыг нь өөрчилж, тэргүүнийг нь шийтгэж болохыг харуулсан бөгөөд үүнийгээ Ирак, Ливи, Египет зэрэг улсад хэрэгжүүлсэн нь бусад улс оронд сургамж өгсөн хэрэг боллоо.


**§ 3.3. Дэлхийн улс орнуудын операцын урлагт гарч буй хувьсал, өөрчлөлтийн харьцуулалт**

**ОХУ:** XX зууны төгсгөл, XXI зууны эхээр болж буй зэвсэгт тэмцэл, тэдгээрийн хэрэгслийн хөгжлөөс шалтгаалж операц болон тактикийн урлагт тодорхой өөрчлөлтүүд гарсаар байна. Үүний улмаас дайныг явуулах арга, хэрэгсэлд урьд өмнө байгаагүйгээр ихээхэн өөрчлөлтийг бий болгоод байна.

Үүний нэг тод жишээ бол ОХУ-ын зэвсэглэл, техник орчин үеийн түвшинд 6 жилийн өмнөх байдлаар 20-30 хувьтай байсан бол бусад хөгжингүй улс орнууд 70 хувиас дээш үзүүлэлттэй байжээ. Зэвсэглэл, техникийн хөгжил нь байлдаан явуулах арга, техникт ихээхэн өөрчлөлт оруулж байгаа бөгөөд дайсныг устгахад баллистик пуужин, өндөр цэцтэй зэвсгийн систем, цогцолборууд нь ихээхэн нөлөө үзүүлж байна. Алсын тусгал мөн нэмэгдсэн бөгөөд эдгээрийн улмаас операц урлаг, тактикийн түвшинд нөлөө үзүүлсээр байна. Үүнээс гадна орчин үеийн геополитикийн нөхцөл байдал нь дайн, байлдааныг цэргийн хэрэгслээр явуулах нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

Орчин үеийн дайн нь цэргийн бус аргаар буюу “5 дахь цувраа” –аар явагдаж байгаа бөгөөд үүнд мэдээллийн, эдийн засгийн, тагнуулын болон сөрөг тагнуул зэрэг арга, хэрэгслүүдээр явагдах болоод байна.

ОХУ-ын дайн, байлдааныг явуулсан түүхэн үе шатыг зэвсэгт тэмцлийн шинж чанартай холбон авч үзвэл 3.1 дүгээр зурагт харуулснаар явагдаад байна.



3.5 дугаар зураг. ОХУ-ын дайн байлдааныг явуулсан үе шат, зэвсэгт тэмцлийн шинж чанар

Энэхүү зургаас зэвсэгт тэмцлийн шинж чанарын өөрчлөлт нь байлдааны ажиллагааны далайцын тэлэлт, орон зайнаас ихээхэн хамаарч агаар-сансар, мэдээллийн хүрээний масштаб дээр явагдах болоод байна.

Ирээдүйд операцын түвшний байлдааны ажиллагааны шинж чанар дараах хандлагатай явагдах төлөвтэй гэж үзэж байна. Үүнд: *нэгдүгээрт*, дайсныг дарах үндсэн үүрэг нь галын болон радио электроны хэрэгслийг ашиглах бөгөөд үүнд алсын зайн галын хөнөөл нэмэгдэнэ; *хоёрдугаарт*, айлдааны ажиллагаанд авиац, өндөр цэцтэй зэвсэг, агаарын

довтолгооноос найдвартай хамгаалагдсан байдал нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ; *гуравдугаарт*, операцын байгууламж (байлдааны журам)-ыг журам мэт тагнуул, мэдээллийн бодит үр дүнд тулгуурлан цэргийг бүлэглэхэд оршиж байна. Иймээс орчин үеийн дайн, зэвсэгт тэмцэл нь цэц өндөртэй, хэт эрчимтэй, хорлон сүйтгэх шинжтэй бүх төрлийн технологийн дэмжлэгтэйгээр явагдах болоод байна<sup>89</sup>.

Стратегийн давших операцын гол бүрэлдэхүүн хэсэг нь стратегийн цохилт бөгөөд операцын зорилго болон хүч, хэрэгслээс шалтгаалж нэг буюу хэд хэдэн цохилтыг төлөвлөж болно. Цохилт нь дайсны цэргийн бүлэглэл, эдийн засгийн чадавхыг устгах зорилгыг агуулах бөгөөд гол төлөв стратегийн агаар-сансрын операцаар явуулдаг болно. Иймд иймэрхүү дайн, байлдаан нь маш хурдан хугацаанд болж өнгөрөх магадлал өндөр юм. Иймэрхүү дайн, байлдаан нь хүчирхэг улс орнуудын хооронд, хэн сайн бэлтгэл хангасан нь тухайн үед, гэнэтийн ажиллагаагаар эхлэх нь тодорхой гэж үзэцгээж байна.

Операцын байлдааны ажиллагааны зорилго нь дайсны тактикийн нэгжийг устгах бус операц, стратегийн гүнд явагдах болно гэж үзэж байна. Бүх операц нь радио электроны ажиллагаагаар эхэлж дайснаас өрсөж байлдааны орон зайд мэдээллээр ноёрхох, дайсныг сохлоход чиглэгдэх болоод байна<sup>90</sup>.

XIX-XX зуунд явагдсан дайн, байлдаантай адил хориглох байлдаан нь давших байлдааны эсрэг эрчимтэй арга хэмжээг авч цаашид давшилтад шилжих нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна. Газар, агаар, сансрын байлдааны ажиллагааны үед операцын түвшний хориглолтыг зохион байгуулахад арми, корпус нь бие даан өөрийн хүч, хэрэгслийг чухал газар оронд операцын тусгай чиглэлд хөдөлгөөнт байдлыг халхалсан, галын халхлалт болон галын уутыг завсар, үзүүрүүдэд найдвартай байдлаар хангах байдлаар хийх нь чухал гэж үзэж байна.


ОХУ-ын агаар, сансрын хамгаалалтын стратеги, операц болон тактикийн түвшинд ямар нэгжүүдийг хамааруулж байсан ойлголтыг дараах диаграмм 3.2 дугаар зургаар харууллаа<sup>91</sup>.

---

<sup>89</sup> <http://csef.ru/ru/oborona-i-bezopasnost/348/perspektivy-razvitiya-taktiki-i-operativnogo-iskusstva-form-i-sposobov-vooruzhennoj-borby-po-opytu-minuvshih-vojn-7222>;


<sup>90</sup> “Оперативное искусство сухопутных войск” учебник, Общейвойсковая академия ВС РФ, издание академия, Москва. 2017 г, стр 32;

<sup>91</sup> <http://bvra.ru>. Журнал "Воздушно-космический рубеж" ВКР 1-2017 22 of Август, 2017;



3.6 дугаар зураг. Өсөлтийн үеийн довтолгооны үеийн бууралтын үеийн гтгэл, анги салбаруудыг зохион байгуулалтын түвшинд хамааруулсан байдал.

Энэхүү диаграммаас операцын түвшний нэгжид арми, тойргийг, тактикийн түвшний нэгжид дивиз, бригадыг хамруулан ойлгож байна. Цаашид газар, тэнгис, агаар болон сансрын орон зайд дайн, байлдааны ажиллагааг явуулахад 3.3 дугаар зурагт харуулснаар нэгдсэн харилцан ажиллагаатайгаар явагдах болоод байна.



3.7 дугаар зураг. Гурван орон зай дахь операцын ажиллагаа

ОХУ-ын цэргийн шинжээчид орчин үеийн дайн, байлдааны ажиллагааны шинж төлөв нь дараах байдалтай явагдах магадлал өндөр гэж үзэж байна. Үүнд: *нэгдүгээрт*, зэвсэгт тэмцэл дэх гол өөрчлөлт нь тэдгээрийн дотоод агуулгад явагдах бөгөөд энэ нь дан ганц зэвсэгт хүчний ай, төрөл, мэргэжлийн цэрэг биш улсын батлан хамгаалах байгуулалтыг бүрдүүлж бэхжүүлэх зэрэг стратеги, операц, тактикийн үүргийг гүйцэтгэх бүх нэгжид хамааралтай болоод байна. Үүнээс гадна орчин үеийн операц нь газар, агаарын хориглон – давших байлдааныг илүү давамгайлан явуулснаар дайсны цохилтыг няцааж, таслан зогсоох зорилгыг агуулах; *хоёрдугаарт*, алсын тусгалтай өндөр цэцтэй зэвсгийн нөлөө дайны зорилгыг улс төр, стратегийн түвшинд тодорхойлох болоод байна. *Гуравдугаарт*, зэвсэгт тэмцлийн орон зайн далайц улам нэмэгдэж байна. Үүний улмаас дайсны бүх газар оронд хүчтэй цохилтыг өгөх, цэргийн объектод дараалан хуралдуулсан галаас гадна нэгэн зэрэг явуулах гал илүү явагдах болоод байна.

**НАТО:** Сүүлийн жилүүдэд барууны судлаачид операцын урлаг, тактикийн судлалын талаар нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй байна. Энэ нь НАТО-ийн төвийн командлал дахь олон улсын нэгдсэн ажиллагаа нь зөвхөн тайван цагт НАТО-ийн энхийг дэмжих ажиллагааны стратегийн зорилгыг хангахад операцын урлагийн асуудал чиглэж байгаатай холбон үзэж байна<sup>92</sup>.


<sup>92</sup> Clayton R. Newell and Michael D. Krause. "On Operational Art" Washington, D.C. 1994. Pg 120;

НАТО болзошгүй тогтворгүй байдал, операцын урлагийн хөгжлийн хандлагад нөлөөлж болохыг дараах асуудлуудтай холбон авч үзэж байна. Үүнд: *Нэгд*, үй олноор хөнөөх зэвсгийн аюул бөгөөд үүнд аль нэг улс эсвэл улс биш тоглогч цацраг, хими, биологийн болон цөмийн зэвсгийг гартаа оруулснаар хэрэглэж болзошгүй бөгөөд цахилгаан соронзон, нано зэрэг орчин үеийн техник, технологийг ашиглах боломж бүрдсэн байдалтай; *хоёрт*, уламжлалт цэргийн операцад хоёр буюу түүнээс дээш улс орон оролцож, уламжлалт цэргийн хүчнийг ашиглахтай; *гуравт*, хурцадмал байдлыг үүсгэх, аюулгүй байдлын орчныг тогтворгүй болгох, энэ зорилгоор жагсаал, цуглаан зохион байгуулах, заналхийлсэн мэдээлэл цацах, зэвсэгт мөргөлдөөн үүсэх нөхцөлийг бүрдүүлэхтэй; *дөрөвт*, гибрид дайныг уламжлалт болон уламжлалт бус аргаар хослуулан явуулахтай; *тавд*, түр зуурын дайн (irregular war)-аар, улс болон улс биш тоглогчдын хоорондын мөргөлдөөнд гол төлөв мэдээллийн хэрэгслийг ашиглаж ард иргэдийг нөлөөндөө оруулах эрмэлзэлтэй; *зургаад*, терроризмоор, улс биш тоглогч, байгууллага нь өөрийн улс төр, шашны болон үзэл суртлын зорилгод хүрэхийн тулд хууль бус үйлдэл, хүчийг тодорхой хугацаа, хэмжээсээр явуулахтай, түүнээс гадна засгийн газар, нийгэм, ард иргэдэд хяналт тогтоохын тулд террорист (кибер) үйлдэлд хүрч байгаатай; терроризм, зохион байгуулалттай гэмт хэргийн харилцан хамааралтай байдал нь тогтворгүй байдлын шинэ төрлийг бий болгох магадлал өндөр байгаатай; *долоод*, дэлхий нийтийн эвдрэл (global common disruption) ба гэмт этгээд хүч хэрэглэснээр, олон улсын хууль, дүрэм, дэлхий нийтэд сорилт үүсгэх магадлалтай, энэ нь кибер орон зайг кинетик болон кинетик бус аргаар саатуулах, сарниулах, шууд халдлага болон кибер халдлагаар илэрч болохтой; *наймд*, онц чухал объект руу хийх халдлагаар, НАТО-ийн холбоотны эсрэг чөлөөт байдлыг алдагдуулахын тулд эрчим хүч, усан боомт, усан доорх кабель, интернетийн эх үүсвэр зэргийг тасалдуулсанаар тогтвортой байдлыг алдагдуулахтай; *есд*, мэдээллийн дайнаар, гэмт этгээдүүд мэдээллийг ард иргэд, шийдвэр гаргагч нарт хүргэснээр энэхүү мэдээллээр үйл ажиллагаагаа явуулах бөгөөд мэдээлэл нь үнэн, хагас үнэн, худал байх магадлалтай; *аравт*, кибер халдлага, кибер орон зайд хийсэн халдлагаар, холбоо, мэдээлэл болон бусад электрон төхөөрөмжийг эвдлэн сүйтгэхтэй; *арваннэгд*, Засгийн газрын өөрчлөлт, үндсэн үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсноор, улс орны гадаад, дотоод аюулгүй байдалд аюул учрахтай; *арванхоёрт*, энгийн ард иргэдэд учрах аюул, суурин газар гэмт этгээд энгийн ард иргэдийн эсрэг том хэмжээний үйл ажиллагаа явуулах, үүнд мөргөлдөөний дараах өшөө авалт, босогчид, жендерийн хүчирхийлэл, Засгийн газрын хэлмэгдүүлэлт, геноцид зэрэг байх талтай; *арвангуравт*, үй олноор дүрвэгсэд, эдийн засгийн хямрал, нийгмийн тэнцвэргүй байдал, зэвсэгт мөргөлдөөн, байгаль орчны доройтол зэргээс шалтгаалан дүрвэж бусад улс оронд их хэмжээгээр орж ирэх нь Засгийн газарт хүндрэл учруулах талтай; *арвандөрөвт*, халдварт өвчний тархалт хүн амын



ихэнх хувьд нөлөөлснөөр үндэстэн, нийгэмд онц байдалд хүргэж болзошгүй байдалтай, *арвантавд*, байгалийн болон хүний оролцоотой гамшиг их хэмжээний хохирол учруулж үндэсний иргэний онц байдалд хүргэгтэй холбож байна<sup>93</sup>.

Дээрх тогтворгүй байдлын нөхцөл, үүсэхэд НАТО хариу арга хэмжээг авахын тулдөөр хоорондоо харилцан уялдаатай 3.4 дүгээр зурагт харуулсан үндсэн чадварын хамрах хүрээг авч хэрэгжүүлдэг байна.




### 3.8 дугаар зураг. НАТО-ийн тогтворжуулах ажиллагаанд үндсэн чадварын хамрах хүрээ

Дээрх үндсэн чадварын хамрах хүрээг НАТО цэргийн операцын үйл ажиллагаанд оролцохын тулд онолын дараах хүснэгт дэх диаграммыг ашиглаж байна.

3.1 дүгээр хүснэгт

НАТО-ийн цэргийн оролцооны онолын муруй

<sup>93</sup> Framework for Future Alliance Operations. 2018. Pg 15;



Дээрх хүснэгт дэх онолын муруйг цэргийн операц, ажиллагааг явуулахад заавал мөрдөх шаардлагагүй, зарим тохиолдолд нэг хамрах хүрээ нь ажиллагаанаас шалтгаалж бүх шатанд явагдах тохиолдол гарч болох талтай гэж үзэцгээж байна.

**Их Британи:** Операцын түвшин дэх нэгдсэн ажиллагааг үндэсний, эвсэл, холбооны стратегийн зорилгыг хангахаар зохион байгуулагдаж байх учиртай гэж үздэг. Иймээс операцын түвшний удирдлага нь операцыг явуулахын тулд кампанит төлөвлөгөөний дагуу бүх төлөвлөгөө, байлдааны үе шат, хангалтыг зохион байгуулахаас гадна нэгдсэн номлол нь операцын түвшинд тактикийн нэгдмэл ажиллагааг төвлөрүүлэхэд чиглэж байна. Энэ нь гал, маневраас гадна мэдээллийн хэрэгслээр зорилгодоо хүрэхэд оршиж байна. Тактикийн түвшинд байлдааны ажиллагаа нь тактикийн нэгж анги, салбарын тусламжтай өгөгдсөн даалгаврыг төлөвлөгөөний дагуу биелүүлж цэргийн зорилгодоо хүрэх явдал гэж үздэг байна.

Их Британи улсын армийн номлол нь НАТО-ийн операц болон тактикийн код, ангиллыг мөрдлөгө болгодог бөгөөд энэ нь холбоотонтой харилцан ажиллах нөхцөл бололцоог олгодог гэж үздэг. Хуурай замын цэргийн операц, тактикийн ажиллагааны ерөнхий зураглалыг 3.5 дугаарт харуулсан бүдүүвч зургаар харууллаа.




### 3. 9 дүгээр бүдүүвч зураг. Их Британи Улсын цэргийн операц, тактикийн ажиллагааны ерөнхий зураглал

Дээрх бүдүүвч зургаас харахад, орчин үеийн операцын төлөвлөлт, түүний онолын асуудал нь уламжлалт дайн, байлдаан буюу цэргийн хүчнүүд хоорондоо тулахаас эрс өөр улс төр, эдийн засаг, энхийг дэмжих ажиллагаа зэрэг цогц хүчин зүйлүүдээс шалтгаалж байгаа тул операцын ажиллагааны үеийн давуу болон сул тал, операцын чиглэл, шийдвэрийг гаргахад ихээхэн хүндрэлтэй нь тодорхой байгаа юм.

Улс төрийн зорилго, зааварчилгаатай явагдах зарим операцын ажиллагаа нь шууд цэргийн номлолын дагуу явагдах боломжгүй байдаг. Үүний нэг тод жишээ бол НҮБ-ын мандаттай явагддаг энхийг сахиулах ажиллагаа бөгөөд төвийг сахих, шударга байх зэрэг зарчим нь зорилгодоо хүрэхэд ихээхэн саад болдог гэсэн дүгнэлтийг гаргаад байна<sup>94</sup>.

Иймээс операцын төрөл, тактикийн ажиллагааг дараах хүснэгтэд харуулснаар тэнцвэржүүлэх нь зүйтэй гэж үздэг байна.



<sup>94</sup> Alexander Mattelaer. ‘The Crisis in Operational Art’ 11 Nov 2009. Pg 8;

3.10 дугаар бүдүүвч зураг. Их Британи улсын цэргийн  
операцын төрөл, тактикийн ажиллагааг тэнцвэржүүлсэн байдал

**АНУ:** 2017 оны 10 сард АНУ-ын армийн операцын ажиллагааны хээрийн гарын авлага “**FM 3-0 Operations**” болон АНУ-ын нэгдсэн ажиллагааны “**(JP) 3-0 Joint Operations**”-ыг батлан гаргасан байдаг.

АНУ-ын армийн хээрийн гарын авлагын 1 дүгээр бүлэгт операцын урлагийн талаар тодорхой заасан байдаг бөгөөд захирагч, штаб нь урлаг, ухааныг хослуулан төлөвлөгөөг боловсруулж, цэргийн хүчийг хэрхэн зөв хуваарилсанаар эрсдэл дор зорилгодоо хүрэхийг эрмэлзэх, үүний тулд дор дурдсан асуултад хариултыг олж байх нь зүйтэй гэж үздэг байна. Үүнд:

- Ямар нөхцөлд, хэзээ зорилго, зорилтоо тодорхойлох вэ?
- Цэргийн хүчин хэрхэн энэхүү зорилгод хүрэх вэ?
- Энэхүү нөхцөлийг гүйцэтгэхэд шат дараалсан ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?
- Шат дараалсан арга хэмжээ авахад ямар хүч, хэрэгсэл шаардлагатай вэ?
- Шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд ямар эрсдэл учирч болох, түүнийг хэрхэн даван туулах, багасгах арга зам байна вэ?

Операцын урлаг бол захирагч, даргад эсрэг талыг системтэйгээр устгаж, дарахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг төдийгүй юуны өмнө оюун ухаандаа төвлөрүүлэх, дараа нь энэхүү төвлөрлөө бодитоор гүйцэтгэх нь чухал гэж үздэг байна. Бодлоо зөв, системтэй төвлөрүүлэх нь ирж болзошгүй аюулыг цагийн байдалдаа зөв тусгах, тогтоосон цаг хугацаанд дайсны үйлдлийг мэдсэнээр хэрхэн таслан зогсоох нь системтэйгээр устгахад чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй байна.

Операцын урлагийн элемент нь зорилго, нөхцөл, давуу болон сул тал, шийдвэр, операц болон чармайлтын чиглэл, хамрах хүрээ, үе шат, шилжилт болон эрсдэл зэргээс бүрдэж байна<sup>95</sup>.

Стратеги, операцын хамрах хүрээ нь богино хугацаанд дэлгэн байрлах, байрламагц байлдаанд шууд орох, нэгдсэн болон олон улсын хүчний хамтарсан кампаний ажиллагааг явуулах чадамжтай байх явдал байна. Үүний тулд төлөвлөлт, хамгаалалт болон бүх талын хангалт, дэмжлэгийг зөв зохион байгуулах дадлага, туршлага шаардагддаг байна.

Стратегийн хамрах хүрээний хувьд дэлхийн хаана ч аюулын эсрэг ажиллагааг явуулах чадвартай байх явдал бөгөөд ямар холын зай туулах, ямар цэргийн хүчнийг илгээх нь

---


<sup>95</sup> FM 3-0 Operations, headquarters, department of the army, October 2017, pg 1-20;

стратегийн хамрах хүрээнд хамааралтай байна. Энэ нь газар, агаар, ус, сансар болон тусгай ажиллагаа, кибер орон зай болон мэдээлэл зэрэг холимог нэгдсэн цэргийн ажиллагааны чадавхаас гадна үндэсний бусад хүч хэрэгсэл болох улс төр-дипломат, эдийн засаг болон мэдээлэл зэргээс бүрдэж байна.

АНУ-ын арми нь энэхүү стратегийн хамрах хүрээнд АНУ-аас хол газар оронд аюулгүй байдлыг хангах зэрэг үүргүүдийг өөрсдийн байрласан баазын хүрээнд явуулж байна.

Операцын хамрах хүрээний хувьд ямар зай, ямар хугацаанд цэргийн чадавхыг амжилттай хэрэгжүүлэх талаар авч үздэг байна.


Цэргийн нэгдсэн ажиллагаа, операцыг явуулахын тулд АНУ дараах 3.7 дугаар зурагт харуулсан загварчлалаар явуулдаг байна.



3.11 дүгээр зураг. АНУ-ын цэргийн нэгдсэн операцын үе шатын загварчлал

Дээрх зураг дахь үе шатуудад АНУ-ын армийн стратегийн үүрэг нь бүх үе шатанд давуу эрхтэй байснаар санаачилгыг гартаа авах, ноёрхох үе шатуудад том масштаб дээр хуурай замын цэргийн ажиллагааг явуулахад чиглэж байна.

Операцын нэгдсэн ажиллагааг явуулахын тулд операцын хөдөлгөөн буюу маневрыг 3.8 дугаар зурагт харуулснаар явуулах бөгөөд энэхүү жишээ нь операцын шийдвэртэй ажиллагааг ямар ч зогсолтгүйгээр явуулахад чиглэгдэж байдаг байна. Операцын хөдөлгөөн, маневрыг амжилттай хэрэгжүүлснээр өөрсдийн байршил, тулгуурт цэгийн аюулгүй байдлыг хангах, хамгаалахаас гадна бусад төхөөрөмжлөлийг цаг алдалгүй бий болгоход чухал байна.



3.12 дугаар зураг. АНУ-ын цэргийн операцийн хөдөлгөөн, маневр хийх зураглал

Операцийн хөдөлгөөн, маневрын хамгийн хүнд, хэцүү хэлбэр нь АНУ-ын нутаг дэвсгэрээс ажиллагааны газар оронд шилжин байрлах явдал бөгөөд үүний нэг тод жишээ нь 1942 оны Хойд Африк руу хийсэн халдлага болон 1992 оны Сомали руу хийсэн довтолгоо бөгөөд тухайн үед завсрын дамжих бааз байгаагүй учраас ихээхэн хүндрэлтэй байсан байна. Энэхүү сургамжаасаа туршлага хуримтлуулж завсрын дамжих баазыг бий болгосноор операцийн маневрыг зохион байгуулахад ихээхэн дэмжлэгтэй болсон байна.

Операцийн урлаг, тактикийн ажиллагааг АНУ хуурай замын цэрэг, ай төрлийн нэгдсэн операцийн ажиллагааны хээрийн гарын авлагад тусгасан дээрх заавраар операц, тактикийн түвшний байлдааны ажиллагааг явуулж байгаагаас гадна агаар, сансарын ганцаарчилсан операц, тактикийн ажиллагаа мөн эх газрын, далай тэнгисийн болон бага эрчимт театр, кампанит ажиллагааны операц, тактикийн ажиллагааг явуулж байна.

Дэлхийн улс орнуудын цэргийн операцийн урлагт гарч буй хувьсал, өөрчлөлтөд хийсэн шинжилгээгээр зарим улс орны операцийн урлагийн онол, практикийн талаарх ойлголтод шинжилгээ хийснээс гадна орчин үеийн цэргийн техник, технологийн дэвшил, аюулгүй байдлын орчны өөрчлөлт зэргээс шалтгаалан цэргийн операц, тактикийн ажиллагааг явуулахад ихээхэн өөрчлөлт гарч буй төдийгүй цаашдаа уламжлалт цэргийн операцаас уламжлалт бус цэргийн операцийн хэлбэрээр явагдах хандлага илүү болоод байна.

Операц, тактикийн ажиллагааны үед ай төрлийн болон төрөл мэргэжлийн цэргүүдийн байлдааны ажиллагааны хурд харьцангуй нэмэгдэхийн хэрээр тэдгээрийн харилцан

ажиллагааны түвшинг нэмэгдүүлж байна. Үүний тулд удирдлага, мэдээллийн системийн автоматжуулалтад анхаарлаа хандуулж байна.

Мэдээлэл, сэтгэл зүйн ажлыг эрчимтэй явуулснаар эсрэг талын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, ард иргэдэд нөлөө үзүүлэх зорилготой байна.

Байлдааны ажиллагааны орон зайн хүрээ нэмэгдэж тэлэхийн хэрээр агаар-сансарын орон зайнаас, газар, уснаас дайсанд нэгэн зэрэг цохилт өгөх боломж бий болсны дээр мэдээллийн хэрэгсэл, электрон соронзон орны тусламжтай операцын байгууламжийн бүх гүнд, бүх чиглэлд явуулах боломжтой болсон байна.

Операцын зорилгоос шалтгаалж хуурай замын цэргийн хүчний үүрэг, роль харьцангуй багасч, өндөр цэцтэй зэвсэг, агаар, тэнгис, сансрын болон радио электрон тэмцлийн цэргийн үүрэг, роль нэмэгдэх хандлагатай болоод байна.

### **§ 3.4. Дэлхийн улс орнуудын цэргийн тактикийн туршлага, сургамжийн харьцуулсан судалгаа**

Цэргийн тактик нь салбар, анги, нэгтгэлийн байлдааныг бэлтгэж явуулах онол, практикийг хамаарна. Тактик нь ерөнхий тактик, тусгай тактикуудад ангилагдана. Ерөнхий тактик нь бүх төрөл, мэргэжлийн салбар, анги, нэгтгэлийн нэгдсэн нэг бодлого төлөвлөгөөгөөр явагдах байлдааны онол, практик юм. Энэхүү нэгдсэн нэг бодлого төлөвлөгөөгөөр явагдах байлдааныг ерөнхий цэргийн байлдаан гэж үздэг.

Орчин үед техник, технологийн дэвшил, зэвсэглэлийн хөгжлөөс шалтгаалж ерөнхий цэргийн байлдааны тактикийн ажиллагаанд ихээхэн өөрчлөлт гарах болоод байна. Энэ нь сүүлийн үед явагдсан орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлагаас байлдааны шинж чанар, явуулах зарчимд ихээхэн өөрчлөлт гарч байгаа нь тодорхой байна. Иймд эдгээр өөрчлөлтийг бүх шатны захирагч, дарга, штабууд нарийн судалж, байлдааны бэлтгэл, сургалтдаа харгалзан үзэх шаардлага тулгараад байна.

Сүүлийн үед явагдсан дайн, байлдааны ажиллагааны туршлага, сургамжаас тактикийн ажиллагааны төрөл, аргуудад дараах өөрчлөлтийг оруулсан гэж судлаачид үзэж байна. Үүнд:

1. Партизаны буюу босогчдын ажиллагааны тактикийг хэрэглэсэн байнгын бус бүлэглэлүүдийн эсрэг байлдааны ажиллагаа явуулах үзэл баримтлалын систем бүрэлдэн тогтсон;
2. Хүчний бусад байгууллагуудын бүлэглэлүүдтэй хамтран хэрэгжүүлсэн тагнуул-хайгуул, цохилт-дайралт, түйвээлт-таслан хаалт зэрэг тактикийн ажиллагааны шинэ арга, хэлбэр үүсч гарсан;

3. Зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэгдэх ажиллагааны отряд-бүлгийн тактик баталгаажиж, ерөнхий цэргийн нэгтгэл, ангиудын байлдааны журмын багагүй элементүүд шинээр үүссэн;
4. Голомтын шинж чанартай тэмцлийн үед дайсанд үзүүлэх галын хөнөөлийн систем улам сайжирсан;
5. Тогтоон барьж-тогтворжуулах ажиллагаа хэмээх хориглолтын шинэ арга үүссэн;
6. Ерөнхий цэргийн байлдааны зарчимд бодитой хөгжил гарч, түүнийг бэлтгэж явуулах, цэргийг удирдах, харилцан ажиллагаа, бүх талын хангалтыг зохион байгуулах талаарх захирагч, штабуудын ажлын агуулга, арга баяжсан гэж үзэж байна.

ОХУ-ын судлаач Ю.Б. Торгованов “Ерөнхий тактик” номондоо АНУ, Герман, Хятад, Япон зэрэг улс орны мотобуудлагын анги, салбаруудын давших байлдааны сонгодог тактикийн норматив, боломжийг судлан дараах хүснэгтүүдэд харуулснаар авч үзсэн байна. Энэ нь орчин үед явагдаж буй жижиг дайны тактикаас өөр, өөрөөр хэлбэл том хэмжээний дайнд хэрэглэгдэх сонгодог тактикийн тухай ойлголт гэж үзэж болно.

3.2 дугаар хүснэгт

АНУ-ын армийн салбарын давшилтын тактикийн боломж<sup>96</sup>

| Давшилтын үзүүлэлтүүд:        | АНУ-ын армийн салбарууд |                  |                   |                 |
|-------------------------------|-------------------------|------------------|-------------------|-----------------|
|                               | Мбб                     | Мбр              | Мбс               | мбт             |
| Давшилтын өргөн               | 2-3,5 км                | 1-1,5 км         | 400 м<br>хүртэл   | 100 м<br>хүртэл |
| Байлдааны журмын гүн          | 3 км хүртэл             | 1-1,5 км         | 500 м<br>хүртэл   | -               |
| Байлдааны үүргийн гүн:        | 6-8 км                  | 3-4 км           | 1-1,5 км          | -               |
| Ойрын                         | 3-4 км                  | 1,5-2 км         | 1-1,5 км          | -               |
| Дараагийн                     | 3-4 км                  | 1,5-2 км         | -                 | -               |
| Объектад атаклах зай          | -                       | -                | -                 | 100-150 м       |
| 2 цувраанаас атаклах зай      | 1-2 км                  | 600 м<br>хүртэл  | 300-400м          | -               |
| ХБ (КХБ)-ын зай               | 2,5 км<br>хүртэл        | 2-3 км<br>хүртэл | -                 | -               |
| Хүч хуралдуулах районы хэмжээ | 2-2,5 км <sup>2</sup>   | 1км <sup>2</sup> | 400м <sup>2</sup> | -               |

<sup>96</sup> Ю.Б. Торгованова. “Общая тактика”. Красноярск, СФУ. 2013;



|  |  |        |        |  |
|--|--|--------|--------|--|
|  |  | хүртэл | хүртэл |  |
|--|--|--------|--------|--|

Энэхүү ном, сурах бичигт давших байлдаанд мотобуудлагын тасагт давших чиглэл, атаклах объектыг (галын цэг, нуувч, траншей г.м) зааж өгөх бөгөөд дайсны хориглолтын өвөр эгнээнээс 500-1000 м зайд байна. Давшилтыг журам мэт ЯЦБМ-аар үйлдэх бөгөөд газар орон, нөхцөл байдлаас шалтгаалж явгалж болдог байна.

Мбс-нд гүнээрээ 1-1,5 км, цааш хөгжүүлэхэд 3-4 км давших чиг заагддаг

Мотобуудлагын тасагт хөдөлгөөнт, маневрын бүлэг болон галын бүлгийг тус тус томилох бөгөөд галын бүлгийн дэмжлэгтэйгээр маневрын бүлэг урагш давшилтыг хөгжүүлж өгдөг.

Хориглох байлдаанд мбс нь журам мэт фронтоороо 400м, гүнээрээ 200м тулгуурт цэгт байрлах бөгөөд өөр хоорондоо 200м зайтай байна.

3.3 дугаар хүснэгт

АНУ-ын армийн салбарын хориглолтын тактикийн норматив

| Хориглолтын үзүүлэлтүүд:                     | АНУ-ын армийн салбарууд |             |          |           |
|----------------------------------------------|-------------------------|-------------|----------|-----------|
|                                              | Мбб                     | Мбр         | Мбс      | мбт       |
| Хориглолтын өргөн:                           |                         | 2 км хүртэл | 400 м    | 100-120 м |
| Район                                        | 2-3,5 км                |             | хүртэл   | хүртэл    |
| Байлдааны журам                              | 5-8 км                  |             |          |           |
| Тулгуурт цэг                                 | 5 км хүртэл             |             |          |           |
| Байлдааны журмын гүн:                        | -                       | 1,5 км      | 300 м    | 100 м     |
| 8-12 км районд                               | -                       | хүртэл      | хүртэл   | хүртэл    |
| 5 км хүртэл байлдааны журам,<br>тулгуурт цэг |                         |             |          |           |
| 2 цувраа хүртэлх зай (резерв)                | 3-10 км                 | 1 км хүртэл | 100-200м | -         |
| ХБ (КХБ)-ын зай                              | 2-5 км                  | 0.5-1 км    | 100-200м | -         |
| Хүч хуралдуулах районы хэмжээ                | 2-4 км                  | 0.5-1 км    | -        | -         |

Мотобуудлагын тасаг хориглолтод үндсэн болон бэлтгэл 1-2 тургуурт цэгийг төхөөрөмжилсөн байх бөгөөд тулгуурт цэг болон завсар үзүүрүүдийн өмнө 50 м-ийн зайд

минэ-ийн болон утсан саадыг тавих, нуувч хооронд 10 м, хос нуувч хооронд 20 м-ийн зайтай байхаар тооцож бэлтгэдэг байна.

Герман улсын хувьд хуурай замын анги, салбар нь нийт бие бүрэлдэхүүний 78 хувийг эзэлж байгаа бөгөөд бэлэн байдлыг дээд зэргээр хангасан зэвсэгт хүчний нэг юм.

Давших байлдаанд мбс нь 200-300 м-ийн өргөнд, 500-700 м-ийн гүнд, цаашид хөгжүүлэхэд дайсны өвөр эгнээнээс 1-1,5 км-ийн гүнд атаклана. Давших заагийг эзэлмэгц салаа нь тойрог хэлбэрийн хориглолтыг зохион байгуулж дайсны сөрөг атакиг няцаахад бэлэн байна.

### 3.4 дүгээр хүснэгт

#### Германы армийн салбарын давшилтын тактикийн боломж<sup>97</sup>

| Давшилтын үзүүлэлтүүд:        | АНУ-ын армийн салбарууд |                            |                                  |            |
|-------------------------------|-------------------------|----------------------------|----------------------------------|------------|
|                               | Мбб                     | Мбр                        | Мбс                              | мбт        |
| Давшилтын өргөн               | 3-5 км                  | 1-2 км                     | 200-400 м                        | 100 -150 м |
| Байлдааны журмын гүн          | 3-5 км                  | 1-1,5 км                   | 500 -600 м                       | -          |
| Байлдааны үүргийн гүн:        | 8-10 км                 | 4-6 км                     | 1,5 км хүртэл                    | -          |
| Ойрын                         | 4-6 км                  | 2-3 км                     | 1,5 км хүртэл                    | -          |
| Дараагийн                     | 4 км хүртэл             | 2-3 км                     | -                                | -          |
| Объектад атаклах зай          | -                       | -                          | -                                | 100-150 м  |
| 2 цувраанаас атаклах зай      | 2-3 км                  | 1км хүртэл                 | 400м хүртэл                      | -          |
| ХБ (КХБ)-ын зай               | 20-30 км                | 2-3 км                     | -                                | -          |
| Хүч хуралдуулах районы хэмжээ | 2-4 км <sup>2</sup>     | 1км <sup>2</sup><br>хүртэл | 400-500 м <sup>2</sup><br>хүртэл | -          |

### 3.5 дугаар хүснэгт

#### Германы армийн салбарын хориглолтын тактикийн норматив

| Хориглолтын үзүүлэлтүүд: | АНУ-ын армийн салбарууд |        |        |        |
|--------------------------|-------------------------|--------|--------|--------|
|                          | Мбб                     | Мбр    | Мбс    | мбт    |
| Хориглолтын өргөн:       | 4 км хүртэл             | 1-2 км | 400 м  | 100 м  |
| Район                    | 5 км хүртэл             |        | хүртэл | хүртэл |
| Тулгуурт цэг             | 2 км хүртэл             |        |        |        |

<sup>97</sup> Ю.Б. Торгованова. "Общая тактика". Красноярск, СФУ. 2013,

|                                                                                         |          |                  |                 |                 |
|-----------------------------------------------------------------------------------------|----------|------------------|-----------------|-----------------|
| Байлдааны журмын гүн:<br>8-12 км районд<br>5 км хүртэл байлдааны журам,<br>тулгуурт цэг | -<br>-   | 1,5 км<br>хүртэл | 300 м<br>хүртэл | 100 м<br>хүртэл |
| 2 цувраа хүртэлх зай (резерв)                                                           | 1,5 -4км | 1 км хүртэл      | 150 м           | -               |
| ХБ (КХБ)-ын зай                                                                         | 1-3 км   | 0.5-1 км         | 150 м           | -               |
| Хүч хуралдуулах районы хэмжээ                                                           | 1-2 км   | 0.5 км           | -               | -               |

Дээрх хүснэгт дэх ерөнхий цэргийн байлдааны тактикийн норматив, боломжууд нь тухай нь улсын байлдааны дүрэм, заавруудад тусгагдсан хэмжээсүүд бөгөөд сүүлийн үеийн зэвсэг, техникийн хөгжлөөс шалтгаалан цаг үеэ даган өөрчлөгдөх нь ойлгомжтой билээ.

Орчин үед явагдаж буй дайн, байлдаан нь тактикийн түвшинд ихэвчлэн жижиг бүлгээр, богино хугацаанд явагдаж байгаа боловч стратегийн түвшинд авч үзвэл Ирак, Афганистан, Сири зэрэг улсуудад удаан хугацаагаар хэдэн арван жилээр үргэлжилсээр байна. Жишээ нь АНУ дээрх улсуудад явуулсан байлдааны ажиллагааны тактикийг авч үзвэл байлдааны дүрэм (FM 3-24.2)-д босогчид буюу партизаны эсрэг явуулах тактикийн ажиллагааны талаар тодорхой авч үзсэн байдаг бөгөөд давших операцад тулгаралт, атак, давшилтыг хөгжүүлэх, мөрдөн хөөх гэсэн тактикийн төрлүүдэд хуваан **“Цэвэрлэх буюу байлдааны ажиллагаа, тогтоох, барих буюу сэргээн босгох ажиллагаа”** (Clear, Hold, Build) гэсэн зарчмаар явуулдаг байна.

Явдлаас тулгарах ажиллагаанд тэдний байршил, хүн хүч, чадавх болон бодол санаа зэргийг сайтар судлах нь чухалд тавигддаг байна. Тулгарах ажиллагааг нэгжин атаклах, бүслэн нэгжих ажиллагаануудаар явуулдаг байна.

Атаклах ажиллагаа нь босогч нарыг устгах, дарахын тулд өөрийн хөдөлгөөнт байдлыг хадгалах, босогчдын хөдөлгөөнт байдлыг хязгаарлах арга хэмжээ болон шууд ба шууд бус галын дэмжлэг дор явагддаг. Атаkyг төлөвлөлт, бэлэн байдал зэргээс шалтгаалан төлөвлөгөөт эсвэл гэнэтийн байж болдог байна.

Атакийг цаашид хөгжүүлэх нь давшилтыг амжилттай явуулахад чухал хэдий ч босогчид байршлаа өөрчлөн алга болох, эсвэл энгийн ард иргэдтэй холилдон алга болсон тохиолдолд боломжгүй болох магадлал өндөр байна.

Мөрдөн хөөх ажиллагааг босогчид ухрасан тохиолдолд тэдгээрийг устгахын тулд явуулдаг бөгөөд амжилттай явуулах үндэс нь тагнуул, мэдээллийн хэрэгсэл, эргүүл мөн тухайн улсын аюулгүй байдлын хүчинтэй хамтран явуулснаар бий болно гэж үздэг.

Үүнээс гадна террористууд, босогчид болон тэрс үзэлтнүүдийн байршлыг тогтоосноор бүслэн нэгжих ажиллагааг явуулдаг бөгөөд удирдлагаас гадна бүслэх, нэгжих болон нөөц багаас бүрддэг байна<sup>98</sup>.

ОХУ-ын хувьд Афганистанд явуулсан байлдааны ажиллагааны тактикийн туршлага, сургамжийн талаар Богдановын “Афганская война” бүтээл дэх хуучин ЗХУ-ын зэвсэгт хүчний 40 дүгээр армийн талаарх судалгааг “Хүч тэнцвэргүй дайн, байлдаан” бүтээлд дэлгэрэнгүй дурдсан байгаа билээ. Эндээс зарим нэг тактикийн ажиллагаанд нөлөөлж байсан онцлог, сургамжийг нь авч үзвэл дараах нөлөө үзүүлж байлаа. Үүнд:

1. Мотобуудлагын ба шүхэр-десантын нэгтгэл, ангиудын гүйцэтгэж байсан байлдааны үүрэг үндсэндээ ялгагдахааргүй ижилхэн байв.
2. Мотобуудлагын ба шүхэр-десантын цэрэг Афганистанд салаа, рот, батальоны жижиг бүлгээр байлдааны үүрэг гүйцэтгэж байлаа. Зөвлөлтийн цэргийн харуулын застав нь тасаг, салааны бүрэлдэхүүнтэй байжээ. Бүрэн бус ротоор харуулын заставыг бүрдүүлж байсан тохиолдол цөөн байв. Эдгээр харуулын застав нь үндсэн ангиас алсад удаан хугацаагаар (6 сар) үүрэг гүйцэтгэж байсан нь тэдний ажиллагааны онцлог байжээ. Харин отолтын бүлэг салаанаас, цөөн тохиолдолд ротоос бүрдэж байсан бол байлдааны жижүүрийн салбаруудад рот, батальоныг томилон гаргаж байсан байна.
3. Бие даан байлдааны үүрэг гүйцэтгэж байгаа аль ч батальон байлдааны ажиллагаагаа дэмжүүлэхээр артиллерийн ба армийн авиацийн гал дуудах эрхтэй байжээ. Батальон байлдааны ямар ч үүрэг гүйцэтгэж байснаас үл хамааран артиллерийн хянагч, авиацийн чиглүүлэгч батальоны командын байранд байнга байрладаг байжээ.
4. Зөвлөлтийн цэргийн салбарууд байлдаанд ихэвчлэн явганаар оролцож байсан тул рот, батальоны бүх ЯЦБМ, ХТ-ийг жолооч, 1-2 цэрэгтэйгээр үлдээж, “хуягт бүлэг” нэрээр нэгтгэн нэг удирдлагад оруулан байлдааны үүрэг гүйцэтгүүлж байсан нь үндсэндээ байлдааны журмын бие даасан нэгж болж байсныг өвөрмөц онцлог гэж үзнэ.
5. Зөвлөлтийн цэргийн танкийн анги, салбарууд байлдааны ажиллагаа явуулж байсан Афганистаны онцлог нөхцөлийн улмаас цэргийн цохилтын хүч болж чадаагүй бөгөөд зөвхөн ил харааны галын хэрэгсэл болгон эсхүл хуягт бүлгийн бүрэлдэхүүнд оруулан ашиглаж байжээ<sup>99</sup>.

Дэлхийн улс орнуудын цэргийн тактикийн туршлага, сургамжийн харьцуулсан судалгааны үр дүнд тактикийн жижиг олон бүлгийг агаарын дэмжлэгтэй хамтран явуулснаар дайсныг бут цохих боломжийг нэмэгдүүлэх, давшилтын гол цохилтыг дайсны алсуур тойрох, агаарын цохилтуудыг гүнд хийх замаар тэдгээрийг бут цохиход, байлдааны тактикийн

<sup>98</sup> БХЭШХ, “Хүч тэнцвэргүй дайн, байлдаан” УБ,2018, т-128-129;

<sup>99</sup> БХЭШХ, “Хүч тэнцвэргүй дайн, байлдаан” УБ,2018, т-108;

бүлгүүдийн байлдах чадварыг хадгалж байхын тулд нисдэг тэрэгний агаарын хөдөлгөөнт бүлгийг өргөн ашиглах, байлдааны ажиллагааг үргэлжилсэн фронтгүйгээр эрчимтэй хөгжүүлж, түүний хөдөлгөөнт байдлыг дээшлүүлэх, хөдөлгөөнт байлдааны бүлгүүдийг давшилтад орох үед өндөр маневрлаг шинж чанараа алдахгүй байх, аль болох алсын зайн ажиллагаа, ойрын байлдаанаас илүүтэйгээр явуулах, дайсны ар талд агаарын хөдөлгөөнт отряд болон бүлгүүдээр түйвээх ажиллагаа явуулах, агаарын байлдаанд нисэх онгоц, нисдэг тэрэгний салбаруудын холимог бүрэлдэхүүний гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, дайсны удирдлага, тагнуул, РЭТ-ийн сүлжээний объектод агаараас нөлөөлөх, дайсны хорлон сүйтгэх-алан хядах ажиллагаатай байнга тэмцэхэд бэлэн байх, объектуудыг тагнан илрүүлж, түүнд цаг тухайд нь цохилт хийх чадвартай, хурдан ажиллагаатай цохилтын бүлэглэлтэй байх зэрэг асуудлууд тавигдаж байна.

**ДӨРӨВ ДҮГЭЭР БҮЛЭГ**  
**ЦЭРГИЙН ОПЕРАЦЫН УРЛАГ, ТАКТИКИЙН**  
**ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА**

Дэлхийн олон улс орны цэргийн урлаг, түүн дотроо операц, тактикийн урлагийн өнөө үеийн хөгжлийн ерөнхий хандлагыг цэрэг, техникийн хувьд өндөр хөгжилтэй, хүчирхэг гүрнүүдийн болон буурай, жижиг улс орнуудын дайн, байлдааны ажиллагааны туршлага, сургамж үндсэндээ тодорхойлж байна. Манай улсын ЗХ-ний цэргийн операц, тактикийн урлагийн хөгжлийн хандлагад дэлхий нийтийн хандлага нөлөөлөхөөс гадна хойд хөршийн операцын урлаг, тактикийн нөлөө онцгой учир холбогдолтойгоос гадна хөгжил буурай, жижиг улс орнуудын дайн, байлдааны ажиллагааны туршлага, сургамж ач холбогдолтой юм.

Өнөө үеийн дэлхийн олон улс орны цэргийн операц, тактикийн урлагийн хандлага нь цэргийн аюулын шинж, цэрэг-улс төрийн бодлогын үр дагавраас хамааралтайгаас гадна Ойрх Дорнод, Европ, Хойд Африкийн бүс нутагт явагдаж байгаа дайн, зэвсэгт мөргөлдөөнүүдээр илэрхийлэгдэж байна. Эдгээр дайн, байлдааны ажиллагаа дахь операц, тактикийн урлагийн шинж нь тэдгээрт хэрэглэж буй хүч, хэрэгсэл болон арга тактикийн онцлогоор тодорхойлогдож байна.

Монголын үндэсний цэргийн операц, тактикийн урлагийн онол, практик шинэ зуунд бодит (объектив) болон субъектив нөлөө дор хөгжих хандлагатай байна.

**§ 4.1. Операцын урлагийн хөгжлийн чиг хандлага**

Цэрэг-техникийн хувьсгал нь зэвсэгт хүчнийг эрс шинэчлэхийг нөхцөлдүүлж байна.

Оросын цэргийн мэргэжилтнүүд (тухайлбал, маршал Н.Огарков) өнгөрсөн зууны 80-аад оноос эхэлж буй цэрэг-техникийн хувьсгал нь ердийн зэвсгийг цөмийн тактикийн зэвсэгтэй эн зэрэгцэхүйц бүтэмжтэй болгоно гэж үзэж байв. Үүнийг цаг хугацаа, практик ажиллагаа нотолсоор байна.

Сүүлийн үед АНУ-ын цэргийн шинжээчид ойрын үед байлдааны ажиллагааны шинж чанарт зарчмын өөрчлөлт гарна гэж төсөөлж байна. Тэдний төсөөллөөр цэрэг-техникийн хувьсгал нь америкийн батлан хамгаалах тогтолцоо, армийн зохион байгуулалтын бүтцэд хийх өөрчлөлт, шинэчлэлийг эхлүүлж, цэргийн тоог эрс хорогдуулах бөгөөд харин шинжлэх ухааны судалгаа, шинэ зэвсэг, техникийг зохион бүтээх хөтөлбөр, төсөл үлэмж хэмжээний зардал шаардах болно гэж үзэж байна.

Дэлхийн өндөр хөгжилтэй, зэвсэглэл, цэргийн техникийн хувьд хүчирхэг зарим улсад физикийн шинэ зарчимд үндэслэсэн зэвсгийг зохион бүтээх ажил эрчимтэй явагдаж байна. “Физикийн шинэ зарчимд үндэслэсэн зэвсэг” гэсэн нэр томъёо ерөнхий, хийсвэр бөгөөд цэргийн практик дахь уламжлалт зэвсгийн хөнөөх үйлчилгээнээс огт өөр үйлчиллээр хөнөөх

чадвартай зэвсгүүдийг харьцуулан хамааруулсан ойлголтыг илэрхийлдэг. XX зууны төгсгөлөөр физикийн шинэ зарчимд үндэслэсэн дараах зэвсгийг судалж, зохион бүтээхэд анхаарч байна:

- Эрчим хүчний цацрагийн бөөмнөрлөөр хөнөөх үйлчилгээ үзүүлдэг - чиглүүлэгт энергийн зэвсэг<sup>100</sup>;
- Гэрлийн квантын хүчирхэг үүсгэвэр (генератор)-ийг ашигласан, чиглүүлэгт энергийн - лазерын зэвсэг<sup>101</sup>;
- Цэргийн радиоэлектрон хэрэгслийн өртөнг, эмзэг байдлыг ашиглан тэдгээрийг хөнөөх цахилгаан-соронзон цацрагийг ашигласан – цахилгаан-соронзон зэвсэг<sup>102</sup>;
- Цэргийн бие бүрэлдэхүүн, зэвсэг, байлдааны техникт янз бүрийн нөлөөлөл үзүүлж, байлдах чадварыг тодорхой цаг хугацааны заагт алдагдуулах – үхэлд үл хүргэх зэвсэг<sup>103</sup>;
- Цэнэгт болон цэнэггүй саармаг эгэл хэсгийн бөөмсийн нарийвчилсан чиглэлд үндэслэсэн – хурдасгуурт зэвсэг<sup>104</sup>;
- Нам үезэлийн дууны долгионыг ашигласан – хэт нам дууны зэвсэг (инфразвуковое оружие)<sup>105</sup>;
- Биологийн объектод цахилгаан-соронзон цацрагаар үйлчлэл үзүүлэх – радио давтамжийн зэвсэг<sup>106</sup>;
- Асар их хэмжээний энерги ялгаруулдаг эгэл хэсгүүдийн харилцан шилжилтийн үйлчлэлд үндэслэсэн – устгах зэвсэг<sup>107</sup>;
- Урьд өмнөх үед сум, пуужинд хурдатгал өгдөг арга - дарь, хийнээс огт өөрөөр хурдатгал өгдөг аргыг ашигласан - хэт хурдны кинетик зэвсэг;
- плазм болон богино долгионы гал асаах артиллерийн систем;
- хөөх шингэн түлш болон хөнгөн хийд суурилсан артиллерийн систем гэх мэт.

---

<sup>100</sup> Оружие направленной энергии // Военная энциклопедия / С. Б. Иванов. — Москва: Военное издательство, 2002. — Т. 6. — С. 160;

<sup>101</sup> Оружие на новых физических принципах // Военная энциклопедия / С. Б. Иванов. — Москва: Военное издательство, 2002. — Т. 6. — С. 158.

<sup>102</sup> Оружие на новых физических принципах // Военная энциклопедия / С. Б. Иванов. — Москва: Военное издательство, 2002. — Т. 6. — С. 158.

<sup>103</sup> Мөн дээрх эх сурвалжид;

<sup>104</sup> Мөн дээрх эх сурвалжид;

<sup>105</sup> Антоненчик Н. Н. Оружие на новых физических принципах // Интерэкспо Гео-Сибирь : журнал. — 2012. — Февраль (т. 5);

<sup>106</sup> Антоненчик Н. Н. Оружие на новых физических принципах // Интерэкспо Гео-Сибирь : журнал. — 2012. — Февраль (т. 5);

<sup>107</sup> Антоненчик Н. Н. Оружие на новых физических принципах // Интерэкспо Гео-Сибирь : журнал. — 2012. — Февраль (т. 5);

Мөн түүнчлэн онолын хувьд, байгалийн янз бүрийн гамшигт хүргэх үзэгдлийг ашиглаж дайсан этгээдийн операц, байлдааны ажиллагаа чадварт хохирол учруулах зэвсэг болгон ашиглаж болох талтай болсон байна. Тийм хэрэглэгдэхүүн, хэрэгсэлд:

- Хүрээлэн буй орчны физик үзэгдлийг удирдан залахад үндэслэсэн – геофизикийн зэвсэг;
- Литосферийн энергийг ашигласан - газар хөдлөлт, геофизикийн зэвсэг;
- дайсны объект байрласан хүрээлэн буй орчинд хохирол учруулах хүчин зүйлсийг ашигласан – экологийн буюу геофизикийн зэвсэг;
- Дайсны объектын байрлал дахь цаг уурын байдлыг өөрчлөхөд үндэслэсэн – цаг агаарын зэвсэг (климатическое оружие) буюу геофизикийн зэвсэг;
- Дайсан байрласан нутаг дэвсгэрийн дээрх агаар мандал дахь озоны давхаргыг ихэсгэж, түүний амьд организмыг хөнөөх үйлчилгээг ашигласан – озоны зэвсэг буюу геофизикийн зэвсэг;
- Микроорганзмыг ашигласан – хүний генетикт нөлөөлөгч зэвсэг г.м.

Дээр дурдсан шинэ зэвгүүдээс цахилгаан соронзон их буу, лазерын зэвсэг, хэт өндөр хэлбэлзлийн зэвсэг, хэт авианы зэвсэг цэргийн урлаг, тактикийн ажиллагаанд онцгой нөлөө үзүүлэх болж байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин өөрийн парламентад илтгэл тавих үеэрээ Оросын армийн зэвсэглэлд нэвтэрсэн зургаан төрлийн шинэ зэвсгийг танилцуулсан байдаг.

Стратегийн зориулалттай, дуунаас хэт хурдан физикийн шинэ зарчимд тулгуурласан орчин үеийн зэвсгүүд нь эсрэг талын хамгаалалтын системд өртөхгүйгээр цөмийн болон цөмийн бус цохилтыг дэлхийн аль ч цэгт өгөх боломжтой гэдгийг В.Путин онцолсон юм. Ингэснээр ОХУ-ын аюулгүй байдал ойрын 10 жилд баталгаатай хангагдлаа гэж зарим шинжээчид үзэж байна. Зэвсэгт тэмцлийн шинж чанарт өөрчлөлт оруулж буй эдгээр зэвсгүүдэд:

1. “Сармат” тив алгасагч стратегийн хүнд пуужин орж байна. Энэхүү пуужин нь 1970-аад оны үед байлдааны жижүүрлэлтэд гарч байсан Р-36 ОРБ буюу барууныхны нэрлэснээр “Сатан” пуужингийн сайжруулсан хувилбар юм. Сатаны тусгал нь 11000 км байсан бол Сармат пуужингийн цогцолборын хувьд тусгалын хязгаар нь эрс нэмэгдэж, хаана ч хүрэх боломжтой болжээ. Энэ пуужин Хойд болон Өмнөд туйлыг даван нисч, онилсон целээ устгах чадвартай юм. “Сармат”-ын гол давуу тал бол дууны хурднаас хэт давсан хурдтай бөгөөд алсын удирдлага бүхий салдаг блокуудтай юм. Энэ давуу байдал нь дайсны АДХ системийн радарт өртөхгүй, 10 байг зэрэг устгах чадвартайд оршдог.

2. Авиацийн пуужингийн Х-47М2 “Кинжал” цогцолбор. Дууны хурднаас 10 дахин хурдтай, энэ пуужинг амдан сөнөөгч Миг-31 онгоцноос харваж газар дээр болон усан доор, дээр байршилтай объект (далайн хөлөг онгоц: онгоц тээвэлэгч далайн хөлөг, крейсер, эсминц



болон фрегат)-ыг устгах чадвартай бөгөөд нислэгийн явцад хүнд хэцүү маневруудыг хийх чадвартай, уг пуужин нэг ёсондоо агаарт байрлалтай “Искандер” пуужингийн цогцолбор бөгөөд 1980-аад онд бүтээгдсэн хөлөг онгоц эсэргүүцэх Х-32 пуужингийн нэлээд сайжруулсан загвар юм. Энэ пуужинг 2017 оны 12 дугаарын эхнээс Өмнөд цэргийн тойргийн онгоцны буудал дээр туршилтын жижүүлэлтэд ажиллуулсан<sup>108</sup>, 2018 оны гурав, дөрөвдүгээр саруудад энэ пуужингийн цогцолборыг цэргийн ашиглалт туршисан байна<sup>109</sup>. ОХУ-ын цэргийн шинжээчдийн үзэж буйгаар “Кинжал” хэмээх авиацын пуужин нь “далавчит пуужин биш бөгөөд асар өндөр (12000-15000 метр)-т хэт их хурдаараа «аэробаллистик» нислэг – хөдөлгөөний даялалыг хийдэг, агаарын эсэргүүцлийг давах чадвар нь стратосферт нислэг нь хийгддэгтэй холбоотой”<sup>110</sup> байна.

3. Нисэгчгүй шумбагч төхөөрөмж. Энэ бол усан доогуур шумбагч аппарат бөгөөд усны хэт гүнд маш хол зайд асар өндөр хурдтайгаар байндаа хүрч устгах ба дуу чимээ багатай, маневрлах өндөр чадвартай учраас эсрэг талын хамгаалалтын системд огт анзаарагдахгүй, түүнийг даван гарах чадвартай байна. Энэ төхөөрөмж нь цөмийн цэнэгт хошууг тээж чадах учраас дайсны нисэх онгоц тээгч далайн хөлөг онгоц, түүнийг хамгаалан явж буй цэргийн хүчний бүлэглэл, эргийн хамгаалалтын бэхлэлт, дэд бүтцийг устгаж чадах ажээ. Хамгийн орчин үеийн шумбагч хөлөг онгоц, торпед, хөлөг онгоцноос хэд дахин давуу хурдтай уг аппаратыг эсэргүүцэн сөнөөх аргыг ямар ч улс орнууд олж чадаагүй байна.

4. Дуунаас хэт хурдан “Авангард” пуужингийн цогцолбор. Энэ цогцолбор нь тив алсгагч баллистик пуужингээр цель рүү хөөргөх, дууны хурднаас хэт их хурдтай, далавчит салдаг блок /хэсгүүд/-уудтай бөгөөд байг чиглэх үедээ дээшээ болон хажуу тийш огцом маневр хийдэг учраас пуужингийн довтолгооноос хамгаалах болон агаарын довтолгооноос хамгаалах системийн радарт өртөгдөхгүй ажээ. Уг пуужингийн хурд 20000 км/ц-аас давж байгаа бөгөөд ердийн баллистик траектороор нисдэггүй, нислэгийн явцад санаанд оромгүй маневрууд хийдэг учраас түүнийг устгах гэсэн ямар ч оролдолго амжилтгүй болох нь ойлгомжтой асуудал юм. Ийм аппаратыг устгаж чадах систем дэлхий дээр одоогийн байдлаар байхгүй байна.

5. Цөмийн хөдөлгүүр бүхий далавчит пуужин. «Буревестник» (Индекс ГРАУ-9М730, НАТО-гийн кодон тэмдэглээ - SSC-X-9 “Skyfall” “Небопад») хэмээх ямар ч алсад тусах чадвартай, асар өндөр хүчин чадалтай, мегаваттын түвшний хүчинтэй цөмийн эрчим хүчний

<sup>108</sup> Газета.ru (1 марта 2018). Дата обращения 12 марта 2018;

<sup>109</sup> Послание Президента Федеральному Собранию (рус.), Президент России. Дата обращения 6 мая 2018; ВКС России принимают гиперзвуковые ракеты «Кинжал». naukatehnika.com. Дата обращения 6 мая 2018;

<sup>110</sup> Эксперты: ракета «Кинжал» — результат модернизации «Искандера», *Русская служба BBC* (11 марта 2018). Дата обращения 11 мая 2018;

хөдөлгүүр (төхөөрөмж)-тэй<sup>111</sup> далавчит пуужин нь ойрын ирээдүйд ОХУ-ын үндсэн зэвсэглэлийн нэг болох төлөвтэй байна. Оросын эрдэмтэд далавчит пуужин байрлуулж болох, овор хэмжээ багатай боловч асар их хүчин чадалтай цөмийн хөдөлгүүр зохион бүтээсэн байна. Ингэснээр пуужингийн тусгалын зай хязгааргүй хол болох ба дайсны агаарын довтолгооноос болон пуужингийн довтолгооноос хамгаалах системд баригдахгүй аж. Ийм пуужинг, дайснаас занал учруулж эхэлмэгц хөөргөж, өгөгдсөн районд байрлуулан дайсны нэн чухал объектод цохилт өгөх боломжийг олгоно гэж гаднын (оросын бус) мэргэжилтнүүд үзэж байна. Уг пуужин нам өндөрт нисдэг бөгөөд цөмийн цэнэг тээгч энэ пуужингийн нислэгийн чиглэлийг /траектор/ тодорхойлох боломжгүйгээс гадна дайсны радарын системийн хамрах хүрээнээс “бултаж” чаддаг давуу тал нь одоо ашиглаж байгаа болон ирээдүйд зохион бүтээгдэх ямар ч пуужингийн довтолгооноос хамгаалах системийн галд өртөхгүй байх боломжийг олгоно. Харин оросын цэргийн шинжээч Владислав Шурыгин шинэ “цөмийн пуужин” нь давшилт, довтолгооны байлдааны хэрэгсэл биш бөгөөд гагцхүү “тогтоон барих” батлан хамгаалах зориулалтай зэвсэг хэмээн үзэж байна.

6. Лазерын зэвсэг. Энэ зэвсгийн талаар хойно дэлгэрүүлэн бичнэ.

ОХУ-ын цэргийн зэвсэглэлд нэвтэрч буй шинэ зэвсэглэл нь ойрын ирээдүйд явагдах зэвсэгт тэмцлийн шинж чанарыг өөрчлөх нь тодорхой байна.

*Ийнхүү алсын зайн нэн өндөр цэцтэй зэвсгийн хөгжил нь* операцын урлагийн онол, практикийн хөгжлийн XXI зууны чиг хандлагыг тодорхойлогч нэг хүчин зүйл болж байна. Америкийн цэргийн шинжээчдийн хэлснээр бол 1991 онд зэвсэглэл дэх НӨЦЗ дөнгөж 7 хувийг эзэлж байсан бол өнөө үед 95 хувийг эзэлдэг болсон байна<sup>112</sup>. Ийм зэвсэглэлтэй нөхцөлд явагдах аливаа операцын төлөв хандлагыг тодорхойлоход тийм ч их хүндрэл байхгүй болжээ. НӨЦЗ нь зэвсэглэлийн цогцолбор бөгөөд өөртөө тагнуул, удирдлагын, хөнөөгч галт болон тээвэрлэгч хэрэгслийг өөртөө нэгтгэсэн, хөнөөлийн радиусаасаа бага хэмжээний хазайлттай онох нарийвчлалтай юм. НӨЦЗ-ийг сүүлийн хориод жилд нэн хурдтай, түргэн хөгжүүлж, АДХ хэрэгслийг галаараа дарангуйлж, дэлхийн аль ч өнцөг, хязгаар дахь объектыг, цаг агаарын ямар ч нөхцөлд, өдөр шөнийг ялгалгүй цохилт өгөх боломжийг нь дээшлүүлсээр байна. НӨЦЗ-ийг хөөргөх зааг улам бүр алслагдаж, илрүүлэхэд хүндрэлтэй болж, нислэгийн хурд нь нэмэгдэж, удирдлага, чиглүүлгийн системийн төрөл, хослол нь олон янз болж өөрчлөгдөж байна. НӨЦЗ-ийг цохилт өгөгч хэрэгслийн галын боломжийг нэмэгдүүлэх шийдлийг технологийн их өөрчлөлтөөр хангаж байна. Өндөр

<sup>111</sup> Lendon, 2018: «Burevestnik nuclear-powered cruise missile»; Trevithick, 2018; Cooper, 2018, Long range nuclear powered cruise missile 'Burevestnik', pp. 8—10;

<sup>112</sup> Единное отчество. <http://otechestvoua.org/main/20089/0213.htm>. Игорь Быков. Высокоточное оружие: перспективы развития и борьбы с ним;

хөгжилтэй улсуудад НӨЦЗ-ийг хэрэглэх бүтэмжийг дээшлүүлэх нөхцөл, боломжийг сайжруулах дэд (суурь) бүтцийг хөгжүүлж байна. АНУ-д агаар-газрын давших операцад оролцогч бүх хүч, хэрэгслийн бүтэмжийг дээшлүүлэх тагнуул, холбоо, удирдлага, чиглүүлгийн бүхэл бүтэн тогтолцоог бүрдүүлсэн байна.

НӨЦЗ-т өндөр ач холбогдол өгч байгаа нь түүний дараах шинж чанартай холбоотой хэмээн үзэж болно:

Нэгдүгээрт, энэ зэвсгийг хэрэглэгч талд цэргийн операцын үед өөрт ямар ч хохирол үзэхгүй байх боломжийг олгож байгаад;

Хоёрдугаарт, дайсны нэн чухал тогтолцоог бүрдүүлэгч объект, түүний үндсэн бүрдэл хэсгийг сонгон устгах боломжийг хэрэглэгч талд олгож байгаад;

Гуравдугаарт, дайсны нэн чухал объектыг устгаснаар түүний байлдах чадварыг бууруулж, бага хохиролтой ялалт байгуулах эдийн засгийн үр өгөөжтэйд;

Дөрөвдүгээрт, дайсны зөвхөн байлдааны объектыг сонгон устгах нөхцөлийг бүрдүүлж өгдөг учраас энгийн ард иргэд, тэдний амьдралын нэн чухал объектыг үй олноор нь хөнөөхгүй байх боломжийг олгодогт;

Тавдугаарт, НӨЦЗ нь операц, байлдаанд хэрэглэхэд бүтэмжээрээ цөмийн зэвсэгтэй дүйх түвшинд хүрч буйн зэрэгцээ байгаль, экологийн хувьд хорт үр дагавар багатай зэрэгт оршиж байна.

**НӨЦЗ-т** одоогоор далавчит пуужин, удирдлагат пуужин, авиацийн удирдлагат бөмбөг, танк болон авиацийг эсэргүүцэгч пуужин зэрэг багтаж байна.

Далавчит пуужин шинэ үеийн дайны үндсэн зэвсэглэл болж буйг орон нутгийн дайн, байлдааны ажиллагааны практик харуулж байгаа бөгөөд тийм зэвсэглэл байхгүй улс орны зэвсэгт хүчний зүгээс өөрт нь ямар ч хохирол учруулахааргүй алс занаас түүнийг хэрэглэж байна. Үүнийг АНУ болон НАТО-гийнхны Ирак (1991, 1998, 2003 оны)-т, Югослав (1999 он)-д явуулсан дайн, операц, байлдааны ажиллагаа харуулдаг.

Далавчит пуужингийн давуутай тал нь: *нэгд*, түүнийг дайсны нутаг дэвсгэрээс хэдэн зуу, мянган км алслагдсан хуурай газар, далай тэнгис, агаараас хэрэглэх боломжтойг; *хоёрт*, түүний гадаргуугийн илрэгдэх талбай жижиг, газар орны гадаргуугийн аясыг ашиглан дээд зэргийн нам өндөрт нислэгээ үйлдэж, дайсны АДХ хэрэгсэлд илрэгдэхгүй, гал, цохилтын хэрэгсэлд хөнөөгдөхгүй байх шинжтэйд; *гуравт*, далавчит пуужингийн байлдааны хэсгийн жин нь эх биетэй нь харьцуулахад их; эвдлэн хөнөөх хүчин чадалтай зэрэгт агуулагдаж байна.

Өнөө үед НӨЦЗ-ийн цоо шинэ төрөл болох дууны хурднаас хэт өндөр хурдтай далавчит пуужинг зохион бүтээж, боловсронгуй болгоход онцгой анхаарал тавьж байна.

АНУ-ын Батлан хамгаалах яамны захиалгаар 1200 км алсын тусгалтай, дууны хурднаас зургаа дахин илүү хурдтай пуужинг зохион бүтээгээд байна.

НӨЦЗ-ийг цаашид дараах чиглэлд хөгжүүлэхээр судалгаа, шинжилгээний ажлыг явуулж байна:

- НӨЦЗ-ийн галын хөнөөлийн хүчин чадал, тусгалын алслалтыг нэмэгдүүлэх, цельд хүргэх хэрэгслийн цэцийг улам дээшлүүлэх;

- НӨЦЗ-ийн автоматжуулалт бүхий удирдлага, чиглүүлгийн системийг “буудлаа-мартлаа” гэсэн зарчимд шилжүүлэх автомат болгох;

- байлдаанд хэрэглэхэд бэлтгэх үйл ажиллагааг автоматжуулах;

- байлдааны авиац, зэвсгийг удирдахад электрон-гооцооллын техник, автоматжуулсан удирдлагын хэрэгслийг ашиглах хүрээг нэмэгдүүлэх;

- зэвсэглэл, түүний бүрдлийг хэлбэр, төрөл, ангиллынх нь хувьд жигдлэх хандлагатай байна.

НӨЦЗ-ийн бас нэг төрөл нь авиацын удирдлагат бөмбөг (АУБ) юм. АУБ нь маш олон янз боловч газрын болон далай, тэнгис дээр байрлалтай дайсны объектыг бүтэмж өндөртэй устгах чадвартай авиацын зэвсгийн нэг болоод байна. Сүүлийн үед явагдсан дайн, операц, байлдааны ажиллагаанд хэрэглэсэн туршлага, сургамжид дүгнэлт хийсэн гадаадын цэргийн мэргэжилнүүд АУБ-ын бүтэмжийг олон үзүүлэлтээр үнэлж үзээд түүнийг авиацын НӨЦЗ гэж дүгнэсэн нь бидний дээрх дүгнэлтийг бататгаж байгаа юм. Өнөө үед АНУ, Израиль, Франц, Их Британи, Чили, Аргентин, ӨАБНУ зэрэг улс АУБ-ийг боловсруулан үйлдвэрлэж байгаа бөгөөд Австрали, Япон, Бразил, Саудын Араб зэрэг улсын зэвсэглэлд нэвтрээд байна.

АУБ нь авиацын ердийн бөмбөгний адил хүчин чадалтай, “агаар-газар” ангиллын удирдлагат пуужингийн адил цельд чиглэл авах удирдлагатай, масс жингийн хувьд хөдөлгүүр, шатахуун хэрэглэдэггүй учир хөнгөн, тиймээс удирдлагат пуужингийн анхны гарааны жинтэй тэнцэх хэмжээний хүнд бөмбөг нь хүчин чадлын хувьд түүний хийх цохилтоос илүү их хүчин чадалтай байдаг байна. Иракийн дайнд АУБ-ыг зөөгч үндсэн хэрэгсэл нь РЛС-д илэрдэггүй F-117 онгоц байж, гол цохилтыг түүгээр хийжээ. Энэ загварын 50 онгоцыг байлдааны ажиллагаанд хэрэглэсэн нь олон үндэстний авиацын дөнгөж 2,3 хувь, нийт онгоц-нислэгийн 3 хувийг эзэлж байсан ч Иракийн нутаг дэвсгэр дээрх хөнөөвөл зохих объектын 40-43 хувийг түүгээр устгасан байна. АУБ бүхий F-117 онгоц хэрэглэсний байлдааны бүтэмж 95 хувь (Вьетнамын дайнд хэрэглэсэн цохилтын авиацын энэ үзүүлэлт 33 хувь)-д хүрч байжээ. F-117 онгоцны онгоц-нислэгийн 80 хувийг хүчтэй хамгаалалт хийгдсэн объектод цохилт өгч, тэдний 97 хувийг устгаж чаджээ.

Хэдийгээр АУБ-ийг операц, байлдааны ажиллагаанд хэрэглэхэд дээрх эерэг сайн үзүүлэлт багаа ч нэлээд хэдэн үзүүлэлтээр удирдлагат пуужингээс доогуур байгаа юм.

Тухайлбал, АУБ тээвэрлэгчийн дундаж хурд далавчит пуужинтай харьцуулахад бага, АУБ-ийг хаях (харвах) үед болон хэт ачааллаас хамаарч чиглүүлэгт алдаа гаргах эрсдэлтэй ажээ. Хэрвээ урьдчилсан тусгай арга хэмжээ аваагүй бол тээвэрлэгч онгоц нам өндрөөс АУБ-ийг хаях боломж нь хязгаарлагддаг байна. Энэ бүхэн нь АУБ нь далавчит пуужинтэй харьцуулахад НӨЦЗ-ийн хувьд түүнтэй өрсөлдөх түвшинд хүрэхээргүй юм.

НӨЦЗ-ийн дээр дурдсан шинж чанар, сүүлийн үеийн дайн, операц, байлдааны ажиллагаанд түүнийг хэрэглэсэн туршлага, практик, энэхүү зэвсгийг хөгжүүлэхээр ажиллаж буй чиг хандлага энэ бүхэн нь ойрын 10-15 жилд үүсэж болзошгүй дайн, агаар сансрын болон агаар-газрын операц, байлдааны ажиллагаанд түүнийг хэрэглэх хэтийн хандлагын талаар ерөнхий дүр төрхийг гаргах боломжийг олгож байгаа юм. Хамгийн түрүүнд энэхүү НӨЦЗ нэн заналт зэвсэг мөн болохыг харуулж байна.

Дайн, агаар сансрын болон агаар-газрын операц, байлдааны ажиллагаанд НӨЦЗ-ийг хэрэглэхдээ хамгийн түрүүнд АДХ хэрэгслийг, арми, түүнээс дээших хэмжээний удирдлагын байруудыг, сөрөг цохилт хийх пуужинг хөөргөх байр, авиаци хөөрөх буудлыг, улс, армийн нэн чухал стратегийн объектыг устгах бөгөөд энэ ажиллагаа хэдэн цагаас хэдэн өдөр үргэлжлэх төлөвтэй байна.

НӨЦЗ-ийг алсын зайнаас, дайсан этгээдийн бүх нутаг дэвсгэр, операцийн бүх гүнд хэрэглэх учир дөрөв дэх үеийн зэвсэгтэй улс, Зэвсэгт хүчинтэй армийн хувьд урдчилан сэргийлэх, шууд хамгаалалтын арга хэмжээ стратегийн ач холбогдолтой байх болно.

“Алсын зайн байлдааны гүнийг тактикийн гүний тагнуулын болон алсын тусгалтай хэрэгслээр дайсанд үзүүлэх нөлөөллийн бүс (50-80км хүртэл); талуудын цэргийн ойртолт, дунд зайны тусгалтай галын хэрэгслийн ажиллагаанд дэс дараатай орох бүс (10-15 км); ойрын зайн байлдааны бүс (10 км хүртэл); резерв болон ар талын байрласан ар талын бүс (талуудын зах нийлсэн байлдааны шугамаас 30-50км гүнд); зам харилцааны бүс (талууд зах нийлсэн байлдааны шугамаас 80км-ийн гүнд) гэсэн таван бүсэд”<sup>113</sup> явагдах төлөвтэй.

Дэлхий дахинаа *лазерын зэвсгийг* АНУ 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Персийн буланд туршсаныг CNN агентлагийн мэдээ дүрст бичлэгээр харуулсан байдаг<sup>114</sup>. Лазерын зэвсгийг АНУ-д агаараас довтолох пуужингээс хамгаалах чиглэлд сансрын зэвсэг болгон ашиглах хандлагаар боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна. Америкчууд лазерын зэвсгийн давуутай талыг:

- Лазерын зэвсэгт сум, галт хэрэгсэл хэрэглэхгүй, зөвхөн цахилгаан л хэрэгтэй;
- Галт зэвсгээс лазерын зэвсгийн онч илүү, гаднын нөлөөд автагдахгүй онцлогтой;
- Хөнөөл үзүүлэх магадлал нь өндөр, бараг баталнгаатай;

<sup>113</sup> Г.Бүлтэн. Тактикийн суурь онол.т.24;

<sup>114</sup> <http://fb.ru/article/343863/lazernoe-orujie-ssha-preimuschestva-nedostatki-i-perspektivy/>;

- Бөмбөгдөлт хот суурингийн ард иргэд, иргэний дэд бүтцийг хөнөөдөг бол, лазерын зэвсэг зөвхөн хөнөөх объектдоо үйлчилдэг ба хүрээлэн буй орчинд нөлөөгүй;
- Лазерын зэвсэг буудалтын үед ямар нэгэн дуу, шуугиан дэгдээдэггүй, энэ нь операц, байлдааны үед өнгөлөн далдлалт хийхийг шаарддаггүй;

Америкчууд лазерын зэвсгийн дутагдалтай талыг:

- Эрчим хүч ашиглалт асар өндөртэй;
- Лазерын төхөөрөмжийн хэмжээ, багтаамж их, хөдөлгөөнт чанар муу;
- Эх газар, агаарын нягтрал өндөртэй орчинд ашиглахад тохиромжгүй, шингэлт ихтэйгээс цэц, бүтэмж нь буурдаг;
- Өндөр хөгжилтэй улсууд, тухайлбал, БНХАУ лазерын туяаг үнэ хямд бүтээгдэхүүн, материалаар хааж саатуулах боломжтой болсон байна.

Гэсэн хэдий ч лазерын туяагаар амьд органзмыг хөнөөхөөс гадна зэвсэг, байлдааны техникийн радио хэрэгслийг устгах, хүний харааг сохлох, алсын зайнаас минэ-гүйжүүлэх зэрэг цэрэг дайны зориулалтаар ашиглах боломжтой шинж чанарыг ашиглахаар судалгаа, зохион бүтээх ажлыг явуулсаар байна. Лазерын зэвсгийн давуутай байдлыг америкчууд хэрхэн үзэж буйг өмнө дурдсан, уламжлалт зэвсгээс ялгарах давуутай бас хэд хэдэн онцлог тал байдгийг дурдвал:

- лазерын туяа гэрлийн хурдаар тархдаг учир 300000 км-ээс бага зайд буудах үед целийн хөдөлгөөнийг тооцоолох, урьдчилан сэргийлэх шаардлага байхгүй. Тиймээс энэ нөхцөлд лазерын “буудлага”-аас ихэнх тохиолдолд зайлсхийх боломж арга байхгүй юм. Агаарт болон газрын гадаргуу дээр явагдах байлдааны үед лазерын туяаны цацрагаас хамгаалах, зайлсхийх боломжгүй байна;
- Лазерын туяа газрын татах хүчний нөлөөд автахгүй ч хар нүхний ойрын хүрээнд хазайлт үүсгэх ба тэнд дайн байлдаан явагдахгүй нь ойлгомжтой юм.
- Кинетикийн зэвсэг (буудлагын зэвсэг)-ээр хөнөөх объектын хэмжээтэй харьцуулахад лазерын зэвсэг хөнөөх үйлчилгээг идэвхтэй үзүүлэх хэсэг, цэгийнхээ хэмжээг багасгаж төвлөрүүлэх, ихэсгэж томсгох үйлчилгээ үзүүлэх боломжтой байна;
- Лазерын “байлдааны иж” (Боекомплект) нь зөвхөн энергийн эх үүсгэвэрээс хамаардаг байна;
- Гэрлийн “импульсийн энерги” практикийн хувьд тэгтэй тэнцүү учраас лазер мэдрэгдэхүйц энергийн үйлчлэл үзүүлдэггүй байна;
- Лазерын зэвсгийг ашиглах хүрээ (диапазон) уламжлалт зэвсэг (кинетик, баллистик, тийрэлтэт)-ийнхээс олон дахин давамгайлах бөгөөд гагцхүү агаарын

орон зай (атмосфер)-н нөхцөл, энергийн үүсгэврийн хүчин чадлаас хамаардаг байна.

Дэлхийн хөгжингүй улс орнууд *нисэгчгүй нисэх аппаратыг* зэвсэглэлд нэвтрүүлэх явдал цаашид эрчимтэй явагдах тодорхой байна. Одоогоор 30 орчим улс 150 гаруй загварын нисэгчгүй нисэх аппаратыг зохион бүтээж, үйлдвэрлэн гаргаж буйгаас 80 орчим загварыг 55 улсын армийн зэвсэглэлд нэвтрээд байна. Нисэгчгүй нисэх аппарат байлдааны талбар дахь тагнуулын үүргийн 67 хувийг, цэргийн хамгаалалтыг хангах үүргийн 50 хувь, байлдааны хөнөөлийн 25 хувийг гүйцэтгэх боломжтой болохыг 2003 онд АНУ-ын хуурай замын цэрэгт явуулсан харьцуулсан туршилтын дүн<sup>115</sup> харуулсан байдаг. Нисэгчгүй нисэх аппарат харьцангуй хямд үнэтэй, дайсанд “цохилт өгөх” хэрэгсэл болохын хамт өндөр үнэтэй авиацийн техник болон бие бүрэлдэхүүний үлэмж хохирлыг бууруулах боломжийг олгож байна. Нисэгчгүй нисэх онгоц целийг өөрөө хараалах, чиглүүлэг авах галт хэрэгсэлтэй, цохилт өгөх цэц нь өндөр учир операц, байлдаанд түүнийг хэрэглэхэд бүтэмж өндөртэй юм.

Нисэгчгүй нисэх хэрэгсэл цэргийн хэрэгт нэвтэрсэн явдал нь зэвсгийн удирдлага, чиглүүлэг, локац, теленэвтрүүлэг, сансрын хэрэгсэлд мэдээлэл дамжуулах – торсион (бодис, эгэл хэсэггүй хоосон орчин) холбоонд үндэслэх<sup>116</sup> болно. Ялангуяа стратеги, операцын төдийгүй тактикийн түвшинд торсион холбоог ашиглах болно. Энэ *холбоо удирдлага, тагнуулын хэрэгслийн* нууцлал нь өндөр, найдвартай, тасралтгүй явагдах нөхцөлийг бүрдүүлж өгөх юм.

Шинэ нөхцөлд явуулах байлдааны ажиллагаа нь улс гүрнүүдийн хооронд стратегийн түвшинд *мэдээллийн дайны хэлбэрт шилжиж* байгаа нь илэрхий болж байна.

Дайсны компьютер-мэдээллийн болон цахим тооцоолох системийг жагсаалаас гаргах цэргийн тусгай ажиллагааны үр дүнд авиацийн болон пуужин-артиллерийн анхны цохилтыг гэнэтийн бөгөөд үр дүнтэй болгох байлдааны ажиллагааны шинэ хэлбэр бий болж байна.

Хүн нэгдмэл мэдээллийн орон зайн нэг хэсэг мөнийн хувьд мэдээллийг асар их алс зайд дамжуулах боломжтой юм. Энэ үзэгдлийг нээснээр хүний өөрийнх нь тухай мэдээллийг авах боломжтой болж байна. Мөн байлдааны зэвсэг, техник, хамгаалалтын хэрэгслийн “металлын хайлшийг торсион цацрагаар үйлчлүүлж, бат бөх чанарыг нь 1,5 дахин, уян хатан чанарыг нь 3-5 дахин нэмэгдүүлж, чанарыг нь сайжруулж байна. Металлын боловсруулалтын ийм арга нь урьд өмнөх бат бөх, уян хатан чанарыг нэгэн зэрэг бүрдүүлэх боломжгүй байсныг нэгтгэж чаджээ<sup>117</sup>.

<sup>115</sup> Независимое военное обозрение. 4 Марта 2016 года. “Боевые работы в будущих войнах: выводы экспертов”.

<sup>116</sup> Акимов А.Е. - Облик физики и технологий в начале XXI века. 4.2.3. Непосредственное использование свойств торсионных излучений;

<sup>117</sup> Акимов А.Е. - Облик физики и технологий в начале XXI века. т.29;

Шинэ зууны зэвсэгт тэмцэл тэр дундаа операцын урлаг шинжлэх ухаан, технологийн хөгжилд тулгуурлах тул XXI технологи болох **торсионны технологи** шийдвэрлэх нөлөө үзүүлэх болно. ОХУ физикийн шинэ зарчимд үндэслэсэн - торсион технологийн судалгаагаар дэлхийд анхдагч, тэргүүлэгч болж байна. Энэ чиглэлд олсон амжилтаас цэрэг, дайны зорилгод ашиглаж болох торсион технологийн заримыг дурдвал: **нэгд**, торсион орон зай үүсгэгч генераторыг зохион бүтээж, мэдээллийг нэн богино хугацаанд, алс зайд түргэн тараадаг болохыг тогтоосон; **хоёрт**, энэ генераторын тусламжаар цоо шинэ, ер бусын шинж чанартай металл (зэвсэглэл ашиглах)-ыг хайлуулж гаргаж авсан; **гуравт**, эд юмсын зураг авалтаар тухайн юмсын гүнд агуулагдаж буй мэдээлэл (цэргийн тагнуулд ашиглах)-ийг олж болохыг тогтоосон; **дөрөвт**, уламжлалт шатахуун хэрэглэдэггүй, шавхагдашгүй эх нөөцтэй, хөдөлгөөний цоо шинэ зарчимд үндэслэсэн, шинэ энергийн хэлбэрийг ашигласан үл мэдэгдэх нисэх объект – нисдэг тавагийг туршсан; **тавд**, нөөц, энерги нь шавхагдашгүй дулааны төхөөрөмж (мөнхийн хөдөлгүүрийг бий болгосон)-ийг туршсан байна.

Физик вакуум нь эрчимшилт хэлбэлзэлтэй динамик систем бөгөөд энерги үүсгэгч болдог. Дээр дугаарлан дурдсан бүхнийг цэргийн хэрэгт нэвтрүүлэх ажил эрчимтэй явагдаж байна.

Торсион цацрагийн тархалт физик вакуум (хоосон)<sup>118</sup> орчинд явагддаг бөгөөд энэ нь торсион долгионы хувьд голографийн орчин (юмсыг орон зайн багтаамжаар дүрслэх долгион) лугаа байдалтай болдог. Энэхүү үндэслэл бологч физик хүчин зүйлс нь дохиолол (сигнал) дамжуулах мэдээлэл (энергийн биш)-ийн шинж<sup>119</sup>, түүний тархалт нь гэрлийн хурднаас хэт давсан хурдаар явагдахыг тайлбарлах үндэс болдог. Торсион холбоо дахь торсион дохиолол ямар ч орчинд шингэдэггүй, сулардаггүй онцлогтой байна<sup>120</sup>. Торсион холбоо нь модулжуулсан цахилгаан дохио (сигнал)-г торсион болгосноор явагддаг бөгөөд энэхүү хөрвүүлгийг торсионын генератор гүйцэтгэдэг байна. Ердийн радиоэлектрон аппаратын дохио хүч өсгөгч болон антеннаар дамждаг бол түүний дохиог гагцхүү торсионын генератораар дамжуулдаг ажээ. Энэ дохионы тархалтын хурд, цаг хугацаны тухай ярих хэрэггүй бөгөөд дохио гармагцаа хаа сайгүй, газар бүхэнд бүрхээстэй оршиж байдаг. Гагцхүү түүнийг хүлээн авах апартур нь дээрх үйл явцыг эсэргээр нь явуулдаг, торсионын дохиог цахилгаан дохио болгох чадвартай байх учиртай ажээ.

Ертөнцөд мэдээллийг ямар ч объектод дамжуулах боломж бүрдэж байгааг цэргийнхэн анхааралдаа аваад байна Мэдээлэл дамжуулах үзэгдлийг-мэдээллийн үйлчлэлийг шилжүүлэх

<sup>118</sup> Акимов А.Е. - Облик физики и технологий в начале XXI века. 2.3 Физический вакуум;

<sup>119</sup> Акимов А.Е. - Облик физики и технологий в начале XXI века. 3.5.4 Информационное поле.

<sup>120</sup> А.Е.Акимов, Г.И.Шипов. “Торсионные поля и их экспериментальные проявления”. т.12; 5 Торсионные средства коммуникации и передачи информации;



нөлөө (МҮШ-нөлөө) (оросоор ПИД-эфффлекта-переноса информационного действия; англиар: effect-transfer informational action) гэдэг.

**Нанотехнологийн хөгжил нь** дэлхийн өндөр хөгжилтэй улсуудын зэвсэгт тэмцлийг явуулах хэрэгслийн шинэ хандлагыг тодорхойлоод зогсохгүй, тэдний технологит ч хувьсгал авч ирэх болно. Нанотехнологийн нээлт нь өнөө үеийн мэдээллийн технологийн хөгжилтэй дүйцэх түвшинд хүргэх бололтой. “2010-2013 онд дэлхийн нанотехнологийн бүтээгдэхүүний зах зээлийн хэмжээ жил бүр 18 хувиар өсөж, бараг 1,6 их наяд ам.долларт хүрч байжээ”<sup>121</sup>. Нанотехнологийн хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг цэргийн зориулалттай эд зүйлсийн үйлдвэрлэлд зориулж байна. Цэргийн салбарт өнгөлөн далдлалтын бүрхүүл, цохилтод нэн тэсвэртэй хучлага, оптикийн, хэт ягаан туяаны, миллиметрийн цар хүрээнд зэвсэглэл, цэргийн техникийг өнгөлөн далдлах материал гарган авах; нано ялтас, нано нийлэг эдлэл (эрчим хүчний систем, цэргийн алба хаагчийн агсамжийн нэн хөнгөн элемент, нисэгчгүй нисэх аппарат, микро хиймэл дагуул); бие даасан байлдааны роботжуулсан систем; хүний эд эрхтний нано суулгац; бусад нано байгууламж; нано электроник; хими, биологийн болон цөмийн зэвсгийн хэрэглээнээс илүүдэлтэй бохирдлын түвшинг тодорхойлох нано мэдрэгч зэргийг бүтээж бий болгох чиглэлээр цаашид нанотехнологийг хөгжүүлэх хандлагатай байна.

Ийнхүү эрчим, нано, био, мэдээллийн шинэ технологи цэргийн хэрэгт нэвтэрч, зэвсэглэл, цэргийн техникт хувьсгалжуулах өөрчлөлт оруулж байгаа нь цэргийн операцын урлагт ч цоо шинэ хандлагыг бий болгож байна. Энэ өөрчлөлт хувьсал тасралтгүй явагдахын зэрэгцээ, зэвсэглэл, цэргийн техникийн шинэчлэл богино хугацаанд явагдах, түүнийг дагаад цэргийн операцын урлаг, тактик хурдан өөрчлөгдсөөр байх төлөвтэй болжээ.

Дайн, цэргийн операц явуулах арга, хэлбэрийн энэ мэт өөрчлөлт нь урьд өмнө хэрэглэж байсан арга хэлбэрийг бүрэн үгүйсгэж буй хэрэг огт биш болно. Цэргийн хэрэгт гарч буй хувьсгалын энэ үед цөмийн зэвсэг бүхий улс, гүрнүүд цөмийн зэвсэг хэрэглэхээс татгалзаагүй хэвээр, улс, орнуудыг партизаны дайны тактик хэрэглэхгүй, террорист операц явуулахгүй болгож буй хэрэг биш болох нь тодорхой байгаа юм.

Операц, тактикийн урлагийн хөгжлийн **хэтийн төлөв нь зэвсэглэл, цэргийн техник, хэрэгслийн шинэ загвар, технологийн шинэчлэл, тэдгээрийн хэрэглэх арга, стратегиэр тодорхойлогдох** болж байна. Цэргийн хэрэгт кибернетик (залуур зүйн)-ийн ухаан, синергетик (нээлттэй системийн бүтэц, загвар өөрөө зохион байгуулагдах, үүсэх тухай ухаан), нанотехнологи (миллиметрын саяны нэгээр хэмжигдэх, тусгай молекул, атомын хэмжээтэй дүйх хэмжээст эгэл хэсэгт суурилсан бүтээгдэхүүнийг зохион бүтээх, үйлдвэрлэх

---

<sup>121</sup> Независимое военное обозрение. №7. 2015. Астужев С. “Применение нанотехнологий в военном деле за рубежом”;

ухаан), мэдээлэл зүй (мэдээлэл дамжуулах шинэ хэлбэр – торсион холбоо бий болсон), биологи (), сэтгэлзүйн ухаан (сэтгэлзүйд шууд нөлөөлөгч радио болон хэм нам долгионыг ашигласан зэвсгийг зохион бүтээж байгаа) болон физикийн болон сэтгэлзүйн шинэ зарчим дахь шинэ нээлтүүд нэвтэрч байгаа нь зэвсэглэл, цэргийн техник, хэрэгслийг улам боловсронгуй болгох тодорхой боллоо.

Цэргийн операц байлдааны ажиллагаанд “тагнуул-цохилт”-ын болон “тагнуул-гал”-ын цогцолборын гүйцэтгэх үүрэг эрс өсөн нэмэгдэх болно.

Алсын зайн операц, байлдаан асар өргөн уудам орон зайд явагдах болж буй бөгөөд дайтагч талуудын тэмцлийн алсын хязгаар нь хэрэглэх зэвсгийн тусгалаар хязгаарлагдана. “Жишээ нь: өнөө үеийн дивизийн галын хэрэгслүүд нь дайсанд үзүүлэх ажиллагааны байлдааны нөлөөллийн бүсийг 50-70 км, түүнээс их; хорооных – 15-20 км; батальоных – 7-10 км хүртэл өргөтгөх боломж олгож байна. Эндээс харахад байлдааны орон зайн цар хэмжээ 5-10 дахин нэмэгдэж, байлдааны талбарын бүтэц ч өөрчлөгдөнө”<sup>122</sup>.

Эдүгээ цагт цэргийн хэрэгт гарч буй хувьсгал нь зэвсэгт хүчинд нэгд, цэргийн командлалын бүх түвшинд удирдлагын тогтолцоог шинэчлэхийг шаардаж байна, хоёрт, зэвсэгт хүчний байгуулалтыг өөрчлөн хөгжүүлэхийг дэвшүүлж байна, гуравт, шинэ төрлийн зэвсэглэл зохион бүтээх, үйлдвэрлэх, ашиглахыг нөхцөлдүүлж байна.

Шинэ үеийн зэвсэгт хүчинд цэргийн зэвсэглэл, техникт гарч буй дэвшилтэт технологийн нөлөөгөөр уламжлалт хуурай замын, агаарын цэргийн, тэнгисийн цэргийн гэсэн ай цэргийн аль нэгийнх нь хүчээр бие даасан операцыг явуулах практик үеэ өнгөрөөж байна. Харин ай цэргийн болон төрлийн цэргийн нэгдэл, нэгтгэлээс бүрдүүлсэн цэргийн бие даасан нэгдсэн байнгын бүтцийг байгуулах хандлага давамгайлах болов.

Орчин үед цэргийн үндсэн зэвсэглэлд алсын зайн тусгалтай нэн өндөр цэцтэй пуужин, ухаалаг сум нэвтэрч байгаа нь анхны цохилтыг өндөр бүтэмжтэй болгож, эдгээр зэвсгийн хөнөөлөөс хамгаалах, халхлах, далдлах боломжгүй шахам болгож байна. Энэ байдал нь байлдааны ажиллагааг дайтагч талуудын хоорондын галын хөнөөлийн тэмцэл болгон хувиргах хандлага бий болгов.

Тэд мэдээллийн тэмцлийн тэргүүн шугамын мэргэжилтнүүд зэвсэгт хүчний шилмэл (элит) бүрэлдэхүүн болж, цэргийн удирдлагын шинэ цөм болно гэж харж байна.

Орчин үеийн зэвсэгт мөргөлдөөний хамгийн түгээмэл хэлбэр нь хүч тэнцвэргүй операц, байлдаан болж байна. Хүч тэнцвэргүй операцыг цэргийн шинжээчид шинэ хэлбэрийн дайн гэж үзэх болов. Хүч тэнцвэргүй операц бол дайнд хэрэглэж буй цэргийн хүч, зэвсэглэл, цэргийн техникийн төдийгүй, хэрэглэж буй цэргийн стратеги, операц, тактикийн

---

<sup>122</sup> Г.Бүлтэн. Тактикийн суурь онол.т.23;

түвшинд ч тэнцвэргүй хүчнүүдийн хооронд явагдаж буйн илрэл юм<sup>123</sup>. Хүч тэнцвэргүй өнөө үеийн операцын үндсэн шинж нь түүнд нүүр тулсан том тулалдаан бараг байхгүй, алсын зайнаас явагдах операц байх бөгөөд тэр тусмаа дайны үр дүнг илэрхийлэх шийдвэрлэх тулалдаан, операцын цар хүрээ илт бага болоход орших болно гэж барууны судлаачид үзэж байна.

Орчин үед цэргийн операцад дайсныг галын болон радиоэлектроны хэрэгслээр алсын зайд хөнөөх явдал тэргүүн зэргийн үүрэг болох бөгөөд байлдааны ажиллагаанд агаар-сансарын давшилтын цэрэг, агаарын цэрэг, нэн өндөр цэцтэй зэвсгийн цогцолбор, сайтар хамгаалагдсан мэдээлэл-тагнуулын болон агаарын довтолгооноос хамгаалах хүч хэрэгсэл гол үүрэг гүйцэтгэх болно.

Харин хүч сул талынхан хүч тэнцвэргүй операцын төрөлд юуны өмнө партизануудын явуулах операц, байлдааны ажиллагаа болон олон улсын терроризмын дайныг хамааруулж үзэж байна.

Өндөр хөгжилтэй, хүчирхэг Зэвсэгт хүчинтэй улс орнуудын өнөө үеийн операц, тактикийн ажиллагаанаас цэргийн *урлагийн хөгжилд дараах төлөв хандлага* ажиглагдаж байна:

- Операцын түвшинд зэвсэгт тэмцлийн хүрээ, орон зайн далайцыг нэмэгдүүлэх, дайтаж буй улсуудын бүх нутаг дэвсгэр дэх дэд (суурь) бүтцийн объект, цэргийн объектод цохилт өгөх эрмэлзлийн дагуу дайн, операц, байлдааны ажиллагааны хүрээг тэлж, сансар (сансрын тагнуулын болон холбоо, удирдлагын хэрэгсэл, ойрын ирээдүйд сансарт байрлуулсан байлдааны цохилтын хэрэгслийн систем)-ыг ашиглах, ерөнхий цэргийн операцыг, ялангуяа, цэргийн тойргуудын тоо, бүрэлдэхүүнийг хураангуйлсан нөхцөл дэх анхны хориглох операцыг гурван хэмжээст багтаамжид явуулах, энэ шинжийг цэргийн нэгдэл, нэгтгэлийн хариуцлагын бүсийн өргөнийг нэмэгдүүлж хангахын зэрэгцээ дайсны хамтарсан хүчний давамгайллыг няцаахад шаардагдах байлдааны бүрэлдэхүүн, цэргийн бүлэглэл байгуулж хориглолтын тогтвортой байдлыг хангах зэргээр ээдрээ түвэгтэй олон асуудлыг шийдсэнээр хангах төлөвтэй болоод байна.

- Цэргийн операц, тактик, байлдааны ажиллагаа явуулагч цэргийн хүч, хэрэгслийн үндсэн зорилгыг эрс шийдэмгий дээшлүүлэхийн тулд, дайсны нутаг дэвсгэрийг эзлэн авахад биш, шинэ төрлийн зэвсгийн хүчээр улс орны амьдралын болон цэргийн нэн чухал объект, систем, тэдгээрийн ажиллагааг алдагдуулахад анхдагч үүргийг тавьдаг болоод байна.

- Цаашид асар өндөр маневрлах чадвартай хүчин, хорлон сүйтгэх бүлгийн хүчээр дайсны цэргийн үндсэн бүлэглэлийг бутцохих ажиллагааг явуулдаг болох гэж байна.

---

<sup>123</sup> Хүч тэнцвэргүй дайн, байлдаан. УБ., 2018 он. - х;

- Орчин үеийн агаар-сансрын довтолгооны хэрэгслийн боломж өсөн нэмэгдэхийн хэрээр зэвсэгт тэмцлийн үндсэн хүч агаар-сансрын орон зайд шилжиж, дайсан улсын болон түүний цэргийн удирдлагын хэрэгслийн ажиллагааг асар богино хугацаанд алдагдуулах, Зэвсэгт хүчний дэлгэн байгуулах боломжийг таслах, улсын эдийн засаг, холбоо харилцаа, хангамжийн дэд (суурь) бүтцийн хэвийн ажиллагааг бусниулдаг болж байна. Үүнтэй зэрэгцээд БАТ-т пуужин эсэргүүцэх хамгаалалтын системийг үр өгөөжтэй байгуулж, агаар-сансрын довтолгооныг няцаах асуудалд хүндрэл тохиолдох төлөвтэй байна.

- Ирээдүйн төлөв байдлыг ажиглахад, байлдааны ба цэргийн нэгдсэн ажиллагааны шинэ хэлбэр нь: цохилт-галын кампани (операц); сансрын цохилтын (хиймэл дагуулыг эсэргүүцэх) операцын галын тулалдаан; электрон – галын, мэдээллийн цохилт; сансрын орон зайд тасралтгүй явагдах байлдааны ажиллагаа, тактик зэрэг болох гэж байна.

- Цэргийн операцын бүлэглэл, хүчний ажиллагаанд: агаарын байлдаан дахь байлдааны нисдэг тэрэг, нисэгчгүй нисэх аппаратын анги, салбарын цохилт; алсын тусгалтай нэн өндөр цэцтэй зэвсгийг тээвэрлэгч болон тээвэрлэгч бус авиацийн байлдааны байнгын ажиллагаа; физикийн шинэ зарчимд үндэслэсэн зэвсэглэлээр хангагдсан цэргийн анги, салбарын тактикийн ажиллагаа чанарын цоо шинэ шинжийг нэвтрүүлэх болоод байна.

- Цаашид, тусгай зориулалтын хүчний ажиллагаа – тусгай операц, тактикийн шинжтэй болж хөгжих бололтой байна.

- Операцын түвшний үүргийг биелүүлэхдээ операцын бүх гүнд галын хүчтэй цохилтыг байлдагч талууд өгдөг болсон, цэргийн болон галын маневрыг хурдтай хийдэг болсон зэрэг нь давшилт, хориглолт дахь цэрэг, хүчний байлдааны ажиллагааны аргууд ойролцоо, адил төстэй болох үндэсийг бүрдүүлж байна.

- Операц, байлдааны талбар дээрх авиац, пуужинт цэргийн цохилт (нэн өндөр цэцтэй зэвсэг болон тусгай зориулалтын галт хэрэглэл)-ын маневр хийх ажиллагаа, алсын тусгалт артиллериар дайснаа галаар хөнөөх үүргийг биелүүлэх ба галын цохилт өгөх нь дээшилсэн явдал бол шууд байлдааны талбар дээр тактикийн галын давамгайлыг бүрдүүлэх асуудлыг хүндрүүлэх болжээ.

- Операцын өнгөлөн далдлалтын арга хэмжээ, мэдээллийн давамгайлын ач холбогдол мэдэгдэхүйц өсөж байна.

- Дотоодын зэвсэгт мөргөлдөөний үед цэргийн нэгдсэн бүлэглэл үүргээ биелүүлэх үеийн харилцан ажиллагааг зохион байгуулахад олон хүндрэл, бэрхшээлтэй тулгардаг боллоо.

- Операц (байлдааны ажиллагаа), тактикийн амжилт цэргийн удирдлага, бүх талын хангалт, даргалах болон нийт бие бүрэлдэхүүний ёс суртахуун, сэтгэл зүйн бэлтгэлээс ихээхэн хамаардаг болжээ.

#### **§ 4.2. XXI зууны тактикийн хөгжлийн хэтийн төлөв.**

Тактикийн хэтийн хөгжлийг тодорхойлогч хүчин зүйл нь тактикийн шинэ зэвсэглэлийн төрлүүд гарч ирж байгаа явдал юм. Байлдааны шинэчлэгдсэн материалаг үндсийн нөлөөлөл дор байлдааны зэвсгийн шинэ загвар аль хэдийн бүрэлдэж эхлээд байна. Үүнд нэн өндөр цэцтэй зэвсэг гол үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд мөдхөн энэ зэвсэг “үндсэн хүч”-ний үүргийг гүйцэтгэх төлөвтэй байна.

Үүний зэрэгцээ, зэвсэглэлийн “сонгодог” төрлийг сайжруулах үйл явц эрчимтэй өрнөх бололтой. Жишээ нь ойрын ирээдүйд артиллери нь тагнуул-галын цогцолбор (ТГЦ)-ын горимд ажиллах нөхцөл бүрэлдэх бөгөөд тагнуул – цохилтын цогцолбор (ТЦЦ) нь зэвсэглэлийн систем байхаа больж, цэргийн зохион байгуулалтын хэлбэрлүү орж, “оператив-тактикийн цоо шинэ систем” болох хандлагатай байна.

Хуурай замын цэргийг хуягжуулах үйл явц үргэлжлэхээр байна. Танктай хийх тэмцэл бүр өнөөдрийн байдлаар ойрын зайны байлдаан /дунджаар 600-800м/-наас 2000-2500м, түүнээс их алсын зай дахь галын байлдаанд шилжих шинж чанартай болоод байна. Гэвч танк эсэргүүцэх хэрэгслийн хэрэглээний бүтэмж нь танкийн хамгаалалтын шинж чанараас өнөөдөр түрүүлж яваа учраас өндөр цэцтэй зэвсэг хэрэглэн байлдааны ажиллагаа явуулах үед танк голлох үүрэгтэй хэвээрээ байх уу? үгүй юу? гэдэг нь одоогоор эргэлзээтэй байна. Мөн түүнчлэн, танк эсэргүүцэх хэрэгслийн хөгжлийн энэхүү давамгайлал нь цаашид өсөх хандлагатай байна.

Ерөнхий цэргийн байлдааны чадавхын цаашдын динамик өсөлтөд олон зориулалтын, тагнуул-цохилтын, амдан сөнөөгч-нисдэг тэрэг, тусгай зориулалтын дагалдагч нисдэг тэрэг, саад тавигч нисдэг тэрэг болон бусад төрлийн шинэ загварын нисдэг тэргээр тэдгээрийн тактикийн ажиллагааг дэмжиж байгаа нь нөлөөлж байна. “Лонгбоу” хэмээх шинэ радар тавьсан “Апач” загварын нисдэг тэрэг нь 200 гаруй хөдөлгөөнт целийг нэгэн зэрэг хянах, эдгээрийн талаарх өгөгдөхүүнийг бие биедээ дамжуулах чадалтай байна. Тэдгээрийг тактикийн ажиллагаанд нэмэгдүүлэн ашигласнаар, ерөнхий цэргийн байлдааны боломжийг эрс дээшлүүлэх бөгөөд үүгээр нь өнөөдөр ч тактикийн хөгжлийн хандлагыг шинжилж болохоор байна. “Стелс” технологийг ашиглан хийсэн “Команч” загварын нисдэг тэрэг нь тэдгээрийг хоёроос-гурван хамгийн дээд зэргийн компьютераар тоногдсон тохиолдолд тагнуул хийх, цельд цохилт өгөх, газрын цэрэгт өгөдөхүүнийг дамжуулах боломжтой болно гэж гадаадын мэргэжилтнүүд үзэж байна.

Нисдэг тэрэгний зэрэгцээгээр хөнгөн моторт “москитная” авиац цаашид хөгжих бололтой. Өнөөдөр энэ бяцхан-онгоц өөрийн нислэгийн болон техник-ашиглалтын боломжоороо ерөнхий цэргийн тактикт өргөн ашиглагдах болж байгаа юм. Тэдгээр нь “алга

дарам” газраас ч, ердийн хээрийн буудлаас ч, шороон зам дээрээс ч хөөрөх чадвартай. Нэн хөнгөн онгоц “газар орны гадаргуугийн дагуу” хийх нислэг, өндөр маневр, удаан зогсолт, дуу чимээ гаргадаггүй болон үл харагдагч байдал зэрэг шинж чанар нь хуурай замын цэргийн байлдааны ажиллагаа явуулах тактикт багагүй нөлөөлөл үзүүлэх бололтой.

Агаарын довтолгооноос хамгаалах хэрэгслийг сайжруулах ажиллагаа ерөнхий цэргийн тактикийн хөгжлийн цаашдын хандлагад их нөлөө үзүүлэх төлөвтэй байна. Цэргийн байлдааны журмын шууд дээр болон агаарын дайралтын хэрэгслийн алсын болон ойрын дөхцөөс, бага, дунд, алсын өндрөөс хийх атакийг няцаах зорилгоор хуягт суурилсан зенитийн пуужингийн хөдөлгөөнт цогцолборыг бүтээгээд байна. Хэтдээ зенитийн цогцолборыг лазерын зэвсгээр тоноглохоор төлөвлөж байна. Энэ нь нисэгчийн харах эрхтэнг 30 км хүртэл алсын зайнаас сохлох, харин 15-30 км-ийн зайнд пуужин, бөмбөгний бүхээгийн чиглүүлэгийн оптик-электрон хэрэгслийг жагсаалаас гаргах боломжийг тэдгээрт олгохоор байна. Лазерын зэвсэгтэй зенитийн пуужингийн цогцолбор нь 3-5 км-ийн зайнд агаарын дайралтын хэрэгслийн бүтцийг нь алдагдуулах чадвартай байх бололтой.

Ирээдүйн байлдааныг электронжиж-роботжсон байлдаан байх болно гэж төсөөлж болохоор байна. Ойрын жилүүдэд цэрэг нь “хиймэл сэхээтний” түвшинд хүрсэн роботжсон хэрэгслээр хангагдах бололтой. Гадаадын цэргийн мэргэжилтнүүд ерөнхийдээ биеэ дааж “сэтгэх”, биеэ дааж “ажиллах” чадвартай байлдааны робот машин бүтээхэд роботын техникийн ирээдүй оршино гэж үзэж байна. Тухайлбал АНУ-ын армид өвөр эгнээнд тагнуул хийх зориулалттай экипажгүй тээврийн хэрэгсэл; хяналт үйлдэж, цель заах газрын роботжуулсан хэрэгсэл; робот тагнуулчин; хяналт үйлдэж, цель заах нисдэг аппарат; минэ-ийн талбайг илрүүлэх нисэгчгүй нисдэг аппарат; минэ тавигч робот; утаан хөшиг болон минэ-ийн талбайд гарц гаргах робот хэрэгсэл; усан саадыг тагнах робот тагнуулчин; газрын робот тавцан /платформ/; антен дэлгэх робот хэрэгсэл; саад тавихад туслах робот хэрэгсэл; нисдэг робот тавцан; байлдааны техникт ариутгал, идэвхжил сулруулалт, хагас цэвэрлэгээ хийх роботжсон систем; байлдааны техникт засвар хийх болон артиллерийн сумыг зөөхөд туслах роботжсон хэрэгсэл; олон зориулалтын болон галт хэрэглэл ачаалах роботжсон жижиг ачигчууд; робот цэнэг түгээгч; онгоцонд пуужинг ачигч робот; танканд галт хэрэглэл ачигч роботжсон хэрэгсэл; хуягт техникийн үйлчилгээ, хангалтын роботжсон систем болон цөмийн галт хэрэгслийг ачигч роботыг ойрын ирээдүйд хэрэглэхээр төлөвлөж байна.

“Сэтгэдэг”, “хардаг”, “сонсдог” роботыг бүтээснээр цэргийн чадавх, цохилтын хүч, биеэ даасан болон хөдөлгөөнт байдал нь огцом өсч, “тагнах-цель заах-хөнөөх” үйл явц дахь хүний оролцоо буурч, байлдааныг явуулах аргын хөгжилд үсрэлт гаргах болж байна.

Үүний үр дүнд байлдааны “автоматжсан” хүнгүй талбар бий болж, түүн дээр хүн хүнийхээ эсрэг бус харин нэг автомат систем нөгөө автомат системийнхээ эсрэг байлдах болж байна.

Роботжихийн зэрэгцээгээр хиймэл дагуулын холбооны хээрийн систем удирдлагын тактикийн хэсэгт нэвтрэн орох, орон нутгийн холбооны систем болон электрон тооцоолох машиныг ашиглан мэдээллийг буулгах, тэдгээрийн хэлхээнд дээд шатны командлалын мэдээлэл солилцох хэлхээг холбох нь бодит зүйл болно.

Тактикийн ажиллагааны аргын хөгжилтөд цэрэг, зэвсгийн удирдлагын автоматжуулалт ихээхэн нөлөөлөл үзүүлж байна. Ойрын ирээдүйд энэ нь тактикийн хүрээн дэх удирдлагын үйл явцын бүх элементийг хамрах болно. Зургаа-долоо дахь үеийн компьютер хийгээд мэдээллийн оптик боловсруулалтын олон процессорт, нейрорхэлхээний, нейрокомпьютрыг ашигласан мэдээл цуглуулах, боловсруулах үйл явцын хөгжил нь шийдвэр гаргах ажиллагааг хурдасгаж, түүний чанарыг нэмэгдүүлэн, байлдааны үүрэг тавих, харилцан ажиллагаа, хяналтыг зохион байгуулах ажиллагааг түргэтгэх болно. Урьдчилан таамаглаж буй мэдээллийг тухайн тэр агшинд нь бодит байдлаар захирагчийн ажлын байрын дэлгэцэн дээр лавлах, график, хүснэгт байдлаар дамжуулдаг болох нь удирдлагын үр ашгийг дээшлүүлэх болно. Цогцолбор автоматжуулалт, тоон сүлжээний холбоо, компьютерын коммутаторын хэрэглээний болон шилэн кабелийн зарчим дээр тулгуурласан автоматжсан нэгдсэн системд нэвтрэх нь технологийн тэмцлийг хурдасгах болно. Цэрэг, зэвсгийн удирдлагын зохион байгуулалтыг алдагдуулах байлдааны ажиллагааны цоо шинэ бие даасан хэлбэр тактикийн хүрээнд гарч ирэхээр байна. Физикийн шинэ зарчимд үндэслэсэн зэвсэг нь тактикийн хөгжилд онцгой ач холбогдолтой болно. Тийм зэвсэг нь дайсанд маневр хийх хугацаа өгөхгүй. Тийм зэвсэг нь цаг агаараас үл хамааран, нэг болон бүлэг целийг устгах чадвартай ба түүний эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээнд тогвортой байдагт түүний давуу тал нь оршдог байна.

Зэвсэглэл, цэргийн техникийн хөгжлийн өнөөгийн чиглэлээс харахад алсын тусгалтай хөнөөлийн хэрэгсэл цаашид улам хөгжих бололтой. Иймд ойрын үед байлдааны шилжилт нь эхний ээлжинд түүний гүнийг хөгжүүлэх шугамаар явах бололтой байна. Энэ үеийн байлдаан нь “алсын зайн” (контактгүй) байлдаан байх бөгөөд зэвсэгт тэмцлийн хэрэгсэл хөгжихийн хэрээр ойрын зайн байлдааныг шахан гаргах ба эцэст нь алсын зайн байлдаан давуу явагдах болно.

Алсын зайн байлдааны гол ялгагдах шинж нь асар удам орон зайд явагдах чанар бөгөөд талуудын тэмцлийн алсын хязгаар нь хэрэглэж байгаа зэвсгийн тусгалаар тогтоогдох тул цэргийн нэгтгэл, ангиудын хоорондын хязгаарлах шугам, тэр бүү хэл, тэмцэлдэгч

талуудын фронтын шугам нь ердөө нэрийн төдий болох бололтой. Жишээ нь өнөө үеийн дивизийн галын хэрэгсэл нь дайсанд үзүүлэх ажиллагааны байлдааны нөлөөллийн бүсийг 50-70 км, түүнээс их, хорооных 15-20, батальоных 7-10 км хүртэл өргөтгөх боломж олгож байгаа юм. Эндээс харахад байлдааны орон зайн цар хэмжээ 5-10 дахин нэмэгдэж, байлдааны талбарын бүтэц ч өөрчлөгдөх төлөвтэй. Одоогоор байлдааны талбарыг өргөн, гүн, өндөр гэсэн гурвалсан хэмжигдэхүүнээр хэмжиж байгаа бол мөдхөн түүн дээр мэдээллийн, электрон, эфирийн гэсэн байлдааны орон зайн шинэ хүрээ нэмэгдэх бололтой. Алсын зайн байлдааны гүнийг тактикийн гүний тагнуулын болон алсын тусгалтай хэрэгслээр дайсанд үзүүлэх нөлөөллийн бүс /50-80 км хүртэл/; талуудын цэргийн ойртолт, дунд зайны тусгалтай галын хэрэгслийн ажиллагаанд дэс дараатай орох бүс /10-15 км/; ойрын зайн байлдааны бүс /10км хүрэл/; резерв болон ар тал байрласан ар талын бүс /талуудын зах нийлсэн байлдааны шугмаас 30-50 км гүнд/; зам харилцааны бүс талуудын зах нийлсэн байлдааны шугмаас 80 хүртэл км-ийн гүнд/ гэсэн байлдааны таван бүсэд хувааж болохоор болжээ. Байлдааны ажиллагаа нь бүх бүсэд дэс дараалан явагдахгүй, харин нэг зэрэг явагдаж болохоор хуваах нь нэлээд хийсвэр байж болох юм.

Операцын болон тактикийн хэрэгслээр дайсныг илрүүлэх хамгийн алсын зайд түүнд хөнөөл учруулах, тэрчлэн, агаар-газрын цохилтын цувраа болон гүний ажиллагааны цуврааг буулгаснаар ерөнхий цэргийн бүлэглэлийг аль болох бага оролцуулан, давшилт, хориглолтын үед дайсныг бут цохих үүргийг зарчмын цоо шинэ аргаар шийдвэрлэх урьдчилсан нөхцөл бүрэлддэгт алсын зайн байлдааны давуу тал нь оршиж байна.

Түүнээс гадна, алсын зайн байлдааныг зохион байгуулж, явуулах ажиллагаа нь хүндрэл багатай байх төлөвтэй.

Алсын зайн байлдааны ойрын зайн байлдаанаас ялгагдах ялгаа нь хяналт үйлдэх, газар орны туршуул явуулах, салбарт байлдааны үүрэг тавих, харилцан ажиллагааг шууд газар орон дээр уламжлалт аргаар зохион байгуулах боломж захирагч нарт байхгүй болно гэж үзэж байна. Алсын зайн байлдааны эхний шатанд мотобуудлага, танкийн анги, салбарын бүрэлдэхүүн дэх ойрын зайн байлдааны ихэнх галын хэрэгсэл дайсанд үзүүлэх галын хөнөөлд оролцдоггүй учраас галын цохилтын чадавхыг бууруулна. “Байлдааны талбар өргөжсөн” нөхцөлд ялангуяа, тагнуул, цэргийн удирдлагыг зохион байгуулахад ихээхэн хүндрэл тохиолдох бололтой.

Эдгээр нь захирагч, штабын байлдааныг зохион байгуулах үеийн ажлын аргад мэдэгдхүйц ул мөр үлдээдэнэ. Захирагч, штаб цагийн байдлын талаар, ялангуяа, дайсны тухай хязгаарлагмал мэдээлэлтэй байх үед алсын зайны (контактгүй) байлдааныг зохион байгуулахад хүрнэ. Ийм учраас захирагч, штабын цагийн байдлыг урьдчилан харж чадах



урлаг, хүч хэрэгслийн харьцааны өөрчлөлтийн динамикийг тооцох, нөгөө талын ажиллагааг тааж мэдэх чадвар урьд өмнө байгаагүйгээр чухал байх болно гэж харж байна.

Алсын зайн байлдааны төлөвлөлт, харилцан ажиллагааны зохион байгуулалт нь ямар нэгэн загварчилсан бүдүүвч байхгүй. Тэдгээрийг шат шатаар хэрэгжүүлэх хэрэгцээ гарна. Үүнд:

Нэгдүгээр шатанд: - дайсныг хүч хуралдуулах районоос гарах болон хөдөлгөөн үйлдэж байх үед агаар, сансрын хиймэл дагуул болон гүний тагнуулын хэрэгслээр илрүүлэх, дайсны тагнуулд эсрэг ажиллагаа явуулах, радиоэлектрон тэмцлийн хэрэгсэлтэй тэмцэх хийгээд электрон-галын цохилтыг таслах арга хэмжээг нэгэн зэрэг хэрэгжүүлэнэ;

Хоёрдугаар шатанд: - алсын районд цохилт-галын болон электрон бүлэглэлийг тусгай районд хүчийг задлах; ажиллагааны нууцлаг болон гэнэтийн байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх; дайсны агаарын болон агаарын хөдөлгөөнт десант, тагнуул-хорлон сүтгэх отряд, бүлэгтэй тэмцэнэ;

Гуравдугаар шатанд: - дайсанд электрон-галын цохилтыг нэгэн зэрэг болон дэс дараалалтай хийх, түүний удирдлага, агаарын довтолгооноос хамгаалах системийг алдагдуулах, дайсны ар талд агаарын цохилтын цуврааг буулгах нөхөлийг бүрэлдүүлнэ.

Алсын зайн байлдаан нь мэдээлэл - сэтгэл зүй, электроны давуу байдлыг олж авах нууц хэлбэрээр эхлэх магадлал өндөртэй байна. Мэдээлэл-сэтгэл зүйн давуу байдал нь операц, тактикийн түвшинд анхны цохилтыг хангах байдлаар илэрнэ. Атаклагч талын үндсэн чармайлт нь эхлээд дайсны цэрэг, зэвсгийн удирдлагыг нь алдагдуулахад чиглэнэ. Цэрэг, зэвсгийн удирдлагыг нь алдагдуулах зарчмын цоо шинэ зүйл нь түүний компьютерын төхөөрөмжийн системд нь нөлөөлөл үзүүлэх явдал мөн. Электрон тооцоолох машины программ хангамжийн элементийг жагсаалаас гаргах чадвартай “вирусийн пушек” хэмээх алсын удирдлагат зэвсэг бүтээхээр судалгаа, шинжилгээний ажлыг эрчимтэй явуулж байна.

Энэ пушекийн ажиллагааг мэрэгжилтнүүд “алгуур устгал” хэмээн нэрлэж байна. Энэ зэвсэг нь хуурамч дохиоллын генераторын тусламжтайгаар компьютер руу вирус нэвтрүүлэн, бодлого бодох үед алдаа, гажуудал гаргана. Дайсны удирдлагын системийн электрон-мэдээллийн орон зай дахь ажиллагааны алдагдуулалтыг физик аргаар биш, харин зохион байгуулалтын замаар гаргах боловч, байлдааны ажиллалгааны эхэн дэх ажиллагаа үүгээр дуусахгүй электроны хийгээд галын болон цохилтын нөлөөллийн бүх хэрэгсэл явцынх нь үед ч ажиллагаанд орно.

Хамгийн хурц тэмцэл эфирт өрнөнө гэж үзэцгээж байна. Тактикийн түвшинд энэ нь дайсны цэрэг, зэвсгийн удирдлагын системийг илэрүүлэх, тэдгээрт радиоэлектрон даралт хийх, түүнчлэн, өөрийн цэрэг, зэвсгийн удирдлагын системд радиоэлектрон хамгаалалт хийх,

дайсны тагнуулын техник хэрэгсэлд сөрөг ажиллагаа явуулахаар хэрэгжүүлж буй зорилго, үүрэг, байр, цаг хугацаагаар нь зохицуулсан арга хэмжээний цогц болсон “радиоэлектрон байлдаан”-д хувьсан шилжинэ.

Радиоэлектрон тэмцэл дэх амжилт нь аль ч талын хувьд радиоэлектрон тэмцлийн шинэ хэрэгслийг үр ашигтай, цаг тухайд нь хэрэглэх; эфир дэх ноёрхлын санаачилгыг өөрт авах; радиоэлектрон хэрэгслийн ажиллагааны горимыг нээх; тэдгээрийн бүлэглэл, өгөгдэхүүн, байлдааны зориулалтыг тодорхойлох; дайсны радиоэлектрон хэрэгслийн цацрагын талаар өөрийн радиоэлектрон хэрэгслийн тоотыг сэрэмжлүүлэх; өөрийн удирдлагат зэвсгийг хэрэглэх, пуужин хөөрсөн тухай мэдээлэх; дайсны тагнуулын техник хэрэгслийг төөрөгдөлд оруулах; түүний радиоэлектрон даралтын удирдлагын шугамд саатуулга хийх; өөрийн радиоэлектрон хэрэгслийн нууцгай байдлыг хангах, саатуулгаас хамгаалдах талаар арга хэмжээ авах зэргээс шалтгаалах болно.

Радиоэлектрон тэмцэл нь гал, цохилт, маневрын нэгэн адилаар ерөнхий цэргийн байлдааны агуулгын салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь байх болно. Энэ бүгд нь радиоэлектрон цагийн байдлыг урьдчилан нягталж харах, дайсны радиоэлектрон тэмцлийн хүч, хэрэгслийн боломж болон түүний хамгийн чухал радиоэлектрон хэрэгслийг тодорхойлох, тэдгээрийн радиоэлектрон даралтыг цаг тухайд нь зохион байгуулах, радиоэлектрон тэмцлийн системийн зохион байгуулалтыг алдагдуулах арга болон өөрийн хүч, хэрэгслийн удирдлагын журмыг тогтоохыг захирагч, штабаас шаардах болно.

Мэдээлэл- сэтгэл зүйн тэмцэл идэвхтэй өрнөсөн нөхцөлд захирагч, штабууд нь физикийн шинэ зарчимд үндэслэсэн, роботжсон техник, өндөр цэцтэй зэвсгийг ашиглан, дайсны ажиллагааг зөн билэгээрээ удирдах урлагийг эзмшсэн байх учиртай болж байна.

Лазер, “сэтгэдэг”, “сонсдог”, “ хардаг” робот ашигласан, радиоидэвхт саад болон агаарын хөдөлгөөнт ажиллагаа нь “тогтоон барьж, цохих”, “хуурч, цохих”, “бага цуцалт”, “бага эргэлт”-ийг харуулах; “харилцааны шуурхай загварчлал”, “шийдвэрийн ойлгомжтой байдал”-ыг үзүүлэх; өөрийн цэргийн санаа бодлын талаар дайснаа албадан төөрөгдүүлэх /хоёр хууралт/; чухал мэдээллийг нуух эсвэл гажуудуулах /чухал мэдээллийн хамгаалалт/; дайсанд олзборлосон радио өгөгдөхүүндээ эргэлзээ төрүүлэхийн зэрэгцээ хуурах бодлогыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх; бэлтгэсэн зангуу, галын уутанд оруулж, галын отолт, минэ-ийн саадууд руу татан оруулахын тулд дайсны ажиллагааг урьдаас төлөвлөж бүрэлдүүлэх зэрэг тактикийн ажиллагааны хууран мэхлэх аргуудыг нэлээд өргөн хэрэглэх боломж олгоно.

Дайсанд үзүүлэх галын хөнөөлийн агуулгад багагүй өөрчлөлт гарах нь харагдаж байна. Дэс дараалсан галын нөлөөллөөс нэгэн зэргийн галын хөнөөлд, талбайн хөнөөлөөс сонгосон галын хөнөөлд шилжих нь алсын зайн байлдааны онцлог шинж байх болно. Ирээдүйд галын

байлдаан нь өндөр цэцтэй зэвсгийн галын тэмцэл болон хувирах ба энд цаг хожих, дайснаас өрсөх, целүүдийг илрүүлж, тэдгээрийг устгах нь нэн чухал ач холбогдолтой байх болно. Сонгож-хязгаарлах, бүсчлэх, галаар таслан хаах, галаар-саатуулах болон галаар тусгаарлах гэх мэт галын хөнөөлийн янз бүрийн аргыг нэлээд өргөн хэрэглэх нь төсөөлөгдөж байна.

Физикийн шинэ зарчимд үндэслэсэн зэвсгийг цэргийн хэрэгт нэвтрүүлсэнээр галын хөнөөлийн цогцолбор систем нь лазер, цацраг, хэт өндөр үелзлийн, кинетик, хэт нам дууны цохилтын шинэ төрлөөр баяжина. Галын хөнөөлийн бүсийг бүрдүүлэхийн зэрэгцээгээр дайсанд энергийн хөнөөл үзүүлэх боломж гарч ирнэ.

Маневр нь шинэ шинж чанарыг агуулах бөгөөд ирээдүйн байлдаанд ноёлох үүрэг гүйцэтгэх болно. Түүний шинэ хэлбэр нь: чиглэсэн энергийн зэвсгийн маневр, роботжсон хэрэгслийн маневр, радиоэлектрон тэмцлийн хэрэгсэл болон алсын зайн минэ-ийн маневр, өндөр цэцтэй зэвсэг, тагнуул-цохилтын болон тагнуул-галын цогцолборын маневр, мэдээлэлийн зэвсгийн маневр байх болно.

Цэргийн хамгаалалтын ач холбогдол, гүйцэтгэх үүрэг улам бүр өсөх болоод байна. Хамгаалалт нь голлох шинж чанартай болно. Довтолгооны хэрэгслийн болон аргын олон төрөл нь хамгаалалтын аргыг нэн ялангуяа, физикийн шинэ зарчимд үндэслэсэн өндөр цэцтэй зэвсэг, үй олноор хөнөөх хэрэгслээс хамгаалах олон аргыг бий болгоно. Хамгаалалт нь байлдааны бүх агуулгыг илэрхийлэх ба харин хамгаалалтын арга хэмжээ нь довтолгооны аргатай дүйх, адил, тэнцүү байх болно.

Шинжлэх ухаан-технологийн дэвшил, хөгжлийн үр өгөөжөөр зохион бүтээгдэж буй зэвсэг нь ирээдүйн зургаа дахь үеийн дайны шинж чанарыг илэрхийлэх болно гэж гадаадын цэргийн эрдэмтэд үзсээр байна. Энэ нь АНУ тэргүүтэй өндөр технологи эзэмшсэн тэргүүлэх улс гүрнүүдэд “ухаалаг”, “нэн өндөр цэцтэй” зэвсгийг зэвсэгт тэмцэлд өргөн ашиглаж эхэлсэнтэй холбоотой юм. Сүүлийн хорь гаруй жилийн туршид явагдсан дайн, зэвсэгт мөргөлдөөнд нэн өндөр цэцтэй зэвсгийг жилээс жилд, дайнаас дайнд шилжих тутамд улам бүр өргөн, олноор ашиглаж ирлээ. Өнгөрсөн зууны 90-ээд оноос хойш орон нутгийн дайнд авианыг ашигласан байдлыг шинжилж үзэх юм бол, түүнд хэрэглэсэн хөнөөх хэрэгслийн ерөнхий тоо хэмжээнд нэн өндөр цэцтэй зэвсгийн эзлэх хувь хэмжээ тогтмол өссөөр иржээ. Америкийн шинжээчдийн гаргасан мэдээллээр бол 1991 оны үед хөнөөх хэрэгслийн ерөнхий тоо хэмжээнд нэн өндөр цэцтэй зэвсгийн эзлэх хэмжээ 7 хувь байсан бол 2008 онд 95 хувь болж өссөн байна. Ийм зэвсгийн нөөц нь орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэх зэвсэг нь нэн өндөр цэцтэй зэвсэг байхыг түвэггүй хэлээд өгч байна. НӨЦЗ нь зэвсэглэлийн цогцолбор бөгөөд түүнд зөөвөрлөгч, тагнуул, удирдлага, хөнөөлийн хэрэгсэл багтаж буй бөгөөд онч нь хөнөөл үзүүлэх радиусаас бага зайн хазайлттай галт хэрэгслийг асар богино

хугацаанд чиглүүлэх удирдах үйл ажиллагаатай юм. НӨЦЗ оньч мэргэн чанараас гадна дайсны агаарын довтолгооноос хамгаалах хэрэгсэлд өртөгдөхгүй, түүний галын дарангуйлалд орохгүй байх чанартай, цаг агаарын ямар ч нөхцөлд, өдөр шөнийн аль ч үед дэлхийн аль ч өнцөг буланд хүрч чадах чадвартай юм.

## ТӨГСГӨЛ:

Дэлхийн цэргийн урлагийн хөгжлийн асуудал нь өнөө үед хөгжлийнхөө шинэ шатанд гараад байна. Орчин үеийн цэргийн урлагийн хувьсал өөрчлөлт нь дотоод, гадаад хүчин зүйлстэй ихээхэн холбоотой байна.

Түүний хөгжилд улс, үндэстний түүхэн уламжлал, иргэншил, ахуй нөхцөлийн онцлог, байгаль, цаг уурын байдал, нийгэм, улс төрийн байгуулалт, үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байна.

Хорьдугаар зууны Монголын цэргийн урлаг, 1990-ээд оны дунд үе хүртэлх хугацаанд Зөвлөлтийн цэргийн урлагийн онол, практикт тулгуурлан хөгжиж ирсэн бөгөөд гагцхүү өөрийн цэргийн хүч чадавх, төрийн байгуулал, байгаль, нийгмийн хүчин зүйлсийг харгалзсан зарим тодотголыг хийж иржээ.

Эндээс үүдээд Монголын төр, нийгмийн байгуулалт өөрчлөгдөж, улсын эдийн засгийн хэлбэршилд чанарын хувьсал явагдаж, монголын ард түмэн, үндэстний язгуур эрх ашиг шинээр илэрхийлэгдэх болж, манай зэвсэгт хүчний зориулалт, гүйцэтгэх үүрэг шинээр тодорхойлогдсон юм. Дээрх хүчин зүйлсийн нөлөө дор монголын цэргийн урлаг, түүний бүрэлдэхүүн хэсэг болох операцын урлаг, тактикийн онол, аргазүй шинэ агуулга, хэлбэрээр хөгжих үндэс бүрдсэн байна.

Өнөөгийн манай улс орны үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин, эдийн засгийн чадавх, цэргийн зэр зэвсэг, байлдааны техник, хэрэгслийн тоо, чанар, цэргийн урлагийн онолын боловсруулалт, түүний бодит чанар, шийдвэр гаргагчдын оюуны чадавх, зохион байгуулах ур чадвар, хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон эх орноо хамгаалах арга ажиллагаанд суралцсан цэрэг дайчдын дадлага, ур чадвар, эр зориг, эрэмгий чанар зэрэг нь юун түрүүнд цэргийн операц, тактикийн урлагт нөлөөлөх гол хүчин зүйлс болж байна.

Хэдийгээр операцын урлаг нь цэргийн стратеги, тактикийн завсрын хүрээний асуудал мөн боловч зэвсэгт хүчний төрөл, тусгай мэргэжлийн цэргүүдийн оперативын нэгдэл, нэгтгэл, ангийн бие даасан болон хамтарсан байлдааны ажиллагааг төлөвлөх, явуулах, зохион байгуулах онол, практикийг хамаарах учраас зайлшгүй шинжлэх ухааны судлагдахуун болгон авч үзэх шаардлагатай байна.

Түүнчлэн манай зэвсэгт хүчин өөрийн цэргийн хүч хэрэгслээр бие дааж операцын үүрэг гүйцэтгэж болзошгүй тохиолдолд операцын урлаг нь цэргийн стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэж, тактикийн үүрэг, зорилго, хөгжлийн чиглэлийг тодорхойлох болно. Зөвлөлтийн цэргийн урлагийн үүднээс бус өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчнийхээ хэмжээ, хүч бололцоо, нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан асуудалд хандах аваас операцын урлагийг судалж, үнэлгээ, дүгнэлт өгөх нь чухал юм.

Туршлага, сургамж дээр тулгуурлан холбоотны цэрэгтэй хамтран сонгодог арга, тактикаар операц явуулах тохиолдолд энэхүү операцын урлагийн онол, практик хэрэгжих үндэстэй байна. Иймээс операцын урлагт нөлөөлж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлсийг судлах нь зүйн хэрэг юм.

Үүний хамт өөрийн зэвсэгт хүчнээс цэргийн тусгай бүлэглэл гаргаж цэргийн операц явуулах тохиолдол гарч болно. Ийм операц нь операцын урлагийн зүй тогтол, зарчимд захирагдаж явагдана.

Харин тактик нь цэргийн урлагийн доод шатны асуудал бөгөөд төрөл, тусгай мэргэжлийн цэргийн нэгтгэл, анги, салбаруудыг байлдаанд бэлтгэх, түүнийг явуулах онол, практикийн асуудлыг хамаарч операцын зорилтыг хэрэгжүүлэх үндсэн арга нь болж байна. Сүүлийн үеийн цэргийн хэрэгт гарч болзошгүй өөрчлөлт, нөлөөлөх хүчин зүйлс, шинжлэх ухаан технологийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзсэнээр XXI зуунд үүсэж болох хүч тэнцвэргүй дайн, байлдаан, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар тактикийн урлагийн онол, онцлогийг урьдчилан тогтоож байна.

Өнөө үеийн манай цэргийн тактик нь ерөнхий тактикийн сонгодог онолоос ялгагдах гол онцлог нь XXI зууны зэвсэгт мөргөлдөөнд цэргийн халз тулсан мөргөлдөөн багасаж, цохилтыг аль болох чадварлаг маневралтаар, сөрөг талын эдийн засаг, цэрэг-стратегийн гол объектод жижиг бүлэг, бага хүчээр гэнэтийн цохилт өгч, устгахад чиглэгдэх төлөвтэй байна. Цэргийн тактикийн ажиллагаа тагнуул, мэдээлэл, цохилтын орчин үеийн шинэ технологит суурилсан нэн цэцэн техник хэрэгслийн дэмжлэг дор идэвхтэй, шуурхай байдлаар явагдах болжээ. Энэ бүхнээс харахад орчин үеийн монголын цэргийн урлагийн хөгжлийн үндсэн асуудал тактикийн түвшинд явагдах төлөвтэй байна.

Өнгөрсөн зууны сүүлч, шинэ мянганы эхэн үеэс цөмийн дайны аюул заналхийлэл багассан ч их гүрнүүдийн хүчний тэнцвэр хэвээр хадгалагдан үлдэж, тав, зургаа дахь үеийн зэвсэглэлээр явуулах хүч тэнцвэргүй шинэ дайны үндэс суурь тавигдаж эхэлсэн байна. Энэ нь цөмийн зэвсгийн эзэлж байсан байр суурийг цэрэг-техникийн хөгжлийн өндөр түвшин, цэрэг-эдийн засгийн чадавхад үндэслэсэн шинэ төрлийн хөнөөлийн ердийн зэвсэг болон байлдааны хэрэгсэл тухайлбал, нэн цэцтэй зэвсэг (НЦЗ), цэргийг болон зэвсгийг удирдах автомат систем, сансрын тагнуул, холбоо, радио электрон, мэдээллийн тэмцлийн хэрэгсэл өөрчилж, цэргийн операц, тактикийн онол, арга ажиллагаанд нөлөөлсөн байна.

Иймээс өндөр хөгжилтэй, цэрэг-эдийн засгийн чадавх бүхий улс, гүрнүүдэд дэлхийн аль ч өнцөг булангаас хуурай газар, далай, тэнгис, агаарын орон зайд байрлуулсан НЦЗ-ийг алсын зайнаас хэрэглэн эсрэг талынхаа цэрэг-эдийн засгийн чадавхыг тодорхойлогч чухал объектуудад цохилт өгөх чадвар нэгэнт бий болжээ. Орчин үеийн дайн, байлдаан дахь

цэргийн урлагийн хөгжлийн өнөөгийн ийм ерөнхий дүр төрх дэлхийн олон улс орны цэргийн урлагийг өөр өөрсдийн өнгө аястай хөгжихийг шаардаж байна.

Өөрийн улс орныхоо нийгэм, төрийн байгууллын шилжилтийн зарим бэрхшээл, эдийн засгийн хөгжил, санхүүгийн чадавхаа харгалзан зэвсэгт хүчнийхээ зэвсэг, байлдааны техник, хэрэгслийн хангамж, хамгаалах хүч хэрэгслийн асуудал нь цэргийн урлаг судлалд нөлөөлөх байдлаас үнэлэлт, дүгнэлтийг хийхэд улс орныхоо цэргийн аюулгүй байдлыг хангах хүрээнд болон тайван цагт хүлээсэн үүргээ биелүүлэх боломж нь хязгаарлагдмал байна. Цаашид цэргийн урлагийн хөгжилтэй уялдуулан цэргийн зэвсэг, байлдааны техник, хэрэгслийн хангамжийн олон асуудлыг өнөө үеийн шаардлагад нийцүүлэн шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага бий болжээ.

Бид энэхүү бүтээлдээ орчин үеийн дайны хувьсал, өөрчлөлт, цэргийн урлагийн хөгжлийн хандлагыг олон улсын түвшинд судлан шинжилж, үнэлэлт дүгнэлт өгөх, туршлага, сургамжийг нь нэгтгэх, өөрийн цэргийн урлагийг хөгжүүлэх үндэслэл, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зорилго тавьсан юм.

Дайн гэдэг бол зөвхөн дайны талбар дахь зэвсэгт тэмцэл байдаггүй. Дайн эхлэхийн өмнө дайсан этгээд улс төрийн, эдийн засгийн, мэдээллийн зэрэг бүх боломжит хэрэгслийг дайсныхаа хүч чадавхыг сулруулахад ашиглана. Иймэрхүү цэргийн бус аргаар хийх тэмцэл үр дүнд хүрээгүй тохиолдолд л зэвсэгт түрэмгийллийг тэмцлийн цэргийн аргыг хэрэглэдэг. Дайныг довтлогч талын хүч чадал бус дайсан этгээдийн сул дорой байдал өдөөдөг гэх нь бий. Гэхдээ зэвсэгт хүчнийг бэлтгэх, бэхжүүлэхэд анхаарлынхаа гадна орхиж хэрхэвч болохгүй ерөнхий хандлага, зүй тогтол байна. Тухайлбал:

1. Улс орноо дайнд оруулах нөхцөл байдлын улс төрийн ба цэргийн түвшинг зөв ялган салгах. Дайсан этгээд улс төрийн эвсэл, холбоо байгуулах, эсхүл тийнхүү холбоо, эвсэл задрах, дайн явуулах улс төрийн нөхцөл бүрдэх зэрэг нөхцөл байдлын түвшинг улсын төрийн удирдлага хариуцах үүрэгтэй байдаг бол зэвсэгт хүчнийг бэлтгэх, дэлгэн байгуулах, цэргийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зэрэг зэвсэгт хүчний бэлтгэл, чадавхын түвшиний асуудлыг улсын цэргийн удирдлагын дээд байгууллага шууд хариуцан хүлээнэ. Энэ үндсэн дээр улс орны удирдлагын хариуцлагын тогтолцоо бүрддэг.

2. Дайны байдлын үеийн улс орны удирдлагын тогтолцоог тайван цагт тогтоож, хэрэгжүүлэх хууль эрх зүйн хангалтыг бүрдүүлж бэлтгэлийг хангах. (Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 1998 онд батлан мөрдүүлж байгаа “Дайны байдлын тухай” хуулиар дайны байдлын үеийн манай улсын удирдлагын тогтолцооны үндсийг тодорхойлоод байна).

3. Цэргийн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтаар цэрэгт оногдуулан бүртгэгдсэн бүрэлдэхүүнийг давтан бэлтгэж, хураангуй болон нэн хураангуй

бүрэлдэхүүнтэй цэргийн анги, салбаруудын дайчилгаагаар богино хугацаанд эмхлэн байгуулагдах нөхцлийг бүрдүүлэх.

4. Аливаа улс дайнд татагдах ороход хүрэх тохиолдолд эхлээд мэдээллийн дайны галд автагдах. Энэ байдал нь тайван цагт нийгэм, нийт иргэдээ мэдээллийн дайны нөлөөнөөс хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлага урган гарч байна.

5. Шинэ үеийн дайнд дайн өдөөгч тал дайсан улсын эдийн засагт хөнөөл учруулахыг урьтал болгох. Өнгөрсөн дайн, цэргийн мөргөлдөөны туршлага, сургамжаас “сөрөг талуудын армиуд бус эдийн засаг нь хоорондоо байлдаж байжээ” гэсэн гаргалгаа гарч байна. Улс орны эдийн засгийн тогтвортой хөгжил, эрсдэлээс хамгаалагдсан байдал бол зэвсэгт хүчнээ бэхжүүлэх тулгуур үндэс мөн болно.

6. Зэвсэгт хүчнийхээ байлдааны зэвсэг, цэргийн техникийг байнга шинэчлэн сайжруулж байх. Улс орныхоо гадаад цэрэг-улс төрийн байдал, түүний өөрчлөлттэй уялдуулан цэргийн байлдах чадварын илэрхийлэгч нэг чухал хүчин зүйл болсон зэвсэглэлийнхээ чанар байдлыг сайжруулж байх шаардлага зүй ёсоор тавигдах болов. Энэ нь зэвсэглэлийн шинэчлэлийн найдвартай арга зам, хүрэлцэхүйц нөөцийг урьдчилан бүрдүүлсэн байхыг нөхцөлдүүлж байгаа юм. Зэвсэглэл бол дайны зарлагын материал юм.

7. “Дайнд хэрэгтэй бүхэнд цэргийг сурга” гэсэн зарчим нэн чухал хэвээр байна. Сургагдаагүй цэргийг байлдаанд оруулах нь гэмт хэрэг гэх нь бий.

8. Зэвсэгт тэмцлийн хэрэгсэл нь зэвсэгт тэмцлийн арга тактикийг тодорхойлно”. Орчин үеийн дэвшилтэд технологид суурилсан шинэ төрлийн зэвсэг нь цэргийн урлагийн онол, практикт үндсэн өөрчлөлт оруулж байна. Цэргийн өндөр хөгжилтэй гүрнүүд XXI зууны 20-оод он гэхэд зургаадугаар үеийн дайн явуулах боломжтой болж байна. Энэ дайн нь урьд өмнө болсон дайнуудаас эрс өөрөөр эхлэх, төгсөх болно.

9. Нийгмийн нэгдэл нягтрал ба бат бэх ар тал бол зэвсэгт тэмцлийг амжилтад хүргэх үндэс.

10. Цэргийн нисэх хүчнийг бүх талаар хөгжүүлэхэд анхаарах. Дайн эхлэх үеэс цэргийн нисэх хүчний гүйцэтгэх үүрэг нэн өндөр болохыг орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлага, сургамж тод томруунаар харуулав. Энэ ч учраас улс орнууд зэвсэгт хүчнийхээ байгуулалтын хөгжлийн хандлагыг өөрчилж байна.

11. Агаарын довтолгооноос хамгаалах цэргийг шинжлэх ухаан, технологийн дэвшилд тулгуурлан хөгжүүлэх. Дайн, зэвсэгт мөргөлдөөнд цэргийн нисэх хүчний гүйцэтгэх үүрэг нэн өндөр болж буйтай холбогдуулан улс орнууд агаарын довтолгооноос хамгаалах цэргээ бүх талаар бэхжүүлэх арга хэмжээ авахад хүрэв. Энэ арга хэмжээ нь цэргийг төдийгүй, улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийг хамарч байгаа юм.



12. Орчин үеийн шинэ технологид суурилсан холбоо, мэдээллийн хэрэгслийг цэргийн зэвсэглэлд бүрэлдэхүүн хэсэг болгон ашиглах болсон нь дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанарт томоохон өөрчлөлт оруулж байна. Холбоо, мэдээллийн шинэ техник, технологи ашигласнаар цагийн байдлын шуурхай бөгөөд бодит мэдээллийг эрс сайжруулж, байлдааны ажиллагааны шуурхай байдлыг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлж байна. Операц, байлдаанд авиацын болон галын цохилт хийхийн өмнө радиоэлектрон тэмцэл өргөн цар хүрээтэй явуулах болов. Энэ нь операц, байлдааны амжилтын үндэс болж байна.

## ЭШЛЭЛ АВСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ:

1. Ш.Паламдорж, Л.Бямбасүрэн. Дайны тухай онол, сургамж. УБ., 2001 он. – х;
2. Ш.Паламдорж. Дайны хувьсал өөрчлөлт, цэргийн урлагийн хандлага. УБ., 2011 он. – 184 х; ISBN 978-99962-50-25-5;
3. Ш.Паламдорж. Мэдээллийн дайн, түүнээс хамгаалах. УБ., 2003 он. –162х;
4. Хүч тэнцвэргүй дайн, байлдаан. УБ., 2018 он. – 186х; ISBN 978-99978-848-3-1;
5. Ц.Дашзэвэг. Цэрэг, армийн тухай-II. УБ., 2015 он. -324; ISBN 978-99962-4-658-6;
6. Хорьдугаар зууны Монгол цэргийн урлагийн түүх. УБ., 2009 он. -240х; ISBN 978-99929-804-1-9;
7. Б.Түмэн “Цэргийн урлагт гарч буй өөрчлөлт”. УБ., 2010 он.198-199 х ; ISBN 978-99929-938-4-1;
8. Б.Шагдар. Стратеги. Б., 2018 он. – х;
9. Д.Доржготов. Цэргийн стратегийн үндэс. УБ., 2008 он. – 243х; ISBN 978-99978-922-4-7;
10. Г.Бүлтэн. Ерөнхий тактик. УБ., 2012 он. – 278х; ISBN 978-99929-804-9-4;
11. Г.Бүлтэн. Тактикийн суурь онол. УБ., 2012 он. – 198х; ISBN 978-99962-50-00-2;
12. Б.Шагдар. Тактик-I. УБ., 2011 он. – 160х; ISBN 978-99962-50-15-6;
13. Б.Шагдар. Тактик- II. УБ., 2013 он. – 214х; ISBN 978-99962-50-16-3;
14. Д.Доржготов. Операцийн онол. УБ., 2010 он. - ; ISBN 978-99929-804-6-X;
15. Батлан хамгаалах стратеги. УБ., 2017 он. – 400х; ISBN 978-99978-1-454-8;
16. Зэвсэгт хүчний стратеги. УБ., 2017 он. – 444х; ISBN 978-99978-1-455-5;
17. Операцийн урлаг судлал. УБ., 2018 он. – 130 х; ISBN 978-99978-848-4-8;
18. Ц.Дашзэвэг. Цэргийн урлагийн онолын эх сурвалжийн гурван ноён оргил. Уб., 2016 он. – 80х; ISBN-978-99929-76-63-8;
19. Большая Российская Энциклопедия. “История оперативного искусства”. Авторы: А.Д.Борцов.
20. Постигение военного искусства: Идеиное наследие А.Свечина.
21. М.В. Фрунзе. Түүвэр зохиол. УБ., 1989 он. -312х; Избранные произведения. М., Воениздат. 1951. -584с;
22. Военное искусство во второй мировой войне. (Стратегия и оперативное искусство). Учебник для слушателей Военной академии Генерального штаба. ;
23. Г.С.Иссерсон. Новые виды борьбы (опыт исследования современных войн). М., 1940г. -144с;
24. Хорьдугаар зууны Монгол цэргийн урлагийн түүх. УБ., 2009 он. -240х; ISBN 978-922-4-7;

25. Хорьдугаар зууны Монгол цэрэг. УБ., 2001 он. – 450х; ISBN 99929-4-005-0;
26. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2014. -702х; ISBN 978-99973-70-21-1;
27. Ц.Дамдинсүрэн, Л.Лувсандэндэв. Русско-монгольский словарь. УБ., Госиздат. 1982г. – 840с; т.378;
28. Большой академический монгольско-русский словарь. Четырех томах. Москва. “Academia”. 2001г. Том II. – 536с; т.486;
29. Вестн. Моск. ун-та. Сер. 25: Международные отношения и мировая политика. 2015 № 3. Стр. 3-22;
30. Кокошин А.А, Балувевский Ю. Н, Потапов В. Я. “Влияние ядерного фактора на развитие отечественной военной мысли”;
31. А.А.Свечин. Стратегия. Военный вестник. Москва. 1927. -265с;
32. Harold S. Orenstein. “Selected Readings in The History of Soviet Operational Art”. Fort Leavenworth, Kansas May 1990. Pg 10;
33. FM 100-5. Operations, 1982;
34. М.И.Слипченко. Войны шестого поколения. /Оружие и военное искусство будущего/. Москва. “ВЕЧЕ”. 2002. -384с; ISBN5-94538-036-9;
35. Военная мысль № 11/2007, стр. 34-44. А.Н.Столяров. Становление и развитие теории и практики оперативного искусства в Военной Академии Генерального Штаба;
36. Военная мысль № 12/2007, стр. 60-67. В.К. Копытко. Эволюция оперативного искусства;
37. История военной стратегии России. /под редакцией В.А.Золотарева/. М., Кучково поле полиграф ресурсы. 2000.-592С; ISBN 5-86090-064-3;
38. Г.С.Иссерсон. Новые виды борьбы (опыт исследования современных войн). М., 1940г. -144с;
39. Монгол цэргийн түүхийн товчоон. (1911-1990-ээд он). Дэд дэвтэр. **T.363-382**;
40. Монгол Улсын Их Хурлын 1994 оны 56 дугаар тогтоолын хавсралт. “Монгол Улсын Цэргийн номлолын үндэс”;
41. Монгол Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт. “Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс” ;
42. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт. “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”;
- 43. ВЭС.т.724;**
44. К.Клаузевиц. О войне. Изд. Эксмо, Мидгард. 2007. – 458с;
- 45. А.Жомини. А.Жомини. “Очерки военного искусства”. Москва. 1939. – ;**
46. Бжезинский.З. “Шатрын аварга хөлөг”. УБ. 2003. ШУА. -232х;

47. Монгол цэргийн түүхийн товчоон. Тэргүүн дэвтэр. т.9;
48. История войн и военного искусства. /Библиотека офицера/. Под редакцией П.А.Жилина. Москва-1986. – 446 стр;
49. Ленин. Зохиолын эмхэтгэл. Боть.9. т.153;
50. Ленин. Зохиолын эмхэтгэл. Боть.39. т.245;
51. М.Н.Тухачевский. Избранные произведения. М.,воениздат. 1957; т.68;
52. И.Н.Воробьев. Тактика – искусство боя. М., 2002. – 863с;
53. Паламдорж.Ш “Мэдээллийн дайн, түүнээс хамгаалах”. УБ., 2003 он. х-162;
54. Гареев М.А. Афганская страда. М., 2002 г;
55. Шагдар.Б “Гадны цэргийн түрэмгийллийг няцаахад зэвсэгт хүчнийг ашиглах нь” (Цэргийн ухааны докторын зэрэг горилсон ажил). УБ., 1999 он. х-124;
56. Besterhorn, J. (1999) ‘Freie Operationen’-zur Bedeutung eines neuen Begriffes im Rahmen der operativen Schulung des Heeres. Hamburg, Führungsakademie der Bundeswehr;
57. Свечин. А.А . Стратегия. Военный Вестник. Москва. 1927. -200с;
58. Holder, L.D. (1990) Educating and Training for Theater Warfare. MilitaryReview. 9 (1990);
59. US DoA HQ. (1986) Field Manual 100-5, Operations. Washington, D.C.,;
60. US DoA HQ. (2001) Field Manual 3-0, Operations. Washington, D.C.,;
61. Operation Anaconda: Lessons Learned or lessons observed?. Fort Leavenworth, Kansas 2009. Pg 9;
62. Контртеррористическая операция в Чечне 1999-2009 гг. Справка. 26 марта 2009;
63. Война в Чечне глазами американских военных экспертов. <https://www.svoboda.org/a/24203508.html>;
64. Чечне после отмены режима КТО произошло боестолкновение. Кавказский узел (17.04.2009);
65. Владимир Иванов, как это было?, Вторая Чеченская Война, 27 Июня 2018;
66. Красная Звезда, 24 декабря 2017г. Андрей Гавриленко, Александр Тихонов, Роман Бирюлин. “Армия останется несокрушимой”, <http://archive.redstar.ru>;
67. Chuka Euka, “Extra-Territorial Consequences of NATO’s War on Serbia”, 2018;
68. Операция НАТО «союзная сила» против союзной республики Югославии, <http://www.eurasian-defence.ru/?q=node/30100>;
69. <http://csef.ru/ru/oborona-i-bezopasnost/348/perspektivu-razvitiya-taktiki-i-operativnogo-iskusstva-form-i-sposobov-vooruzhennoj-borby-po-opytu-minuvshih-vojn-7222>;
70. “Оперативное искусство сухопутных войск” учебник, Общейвойсковая академия ВС РФ, издание академия, Москва. 2017 г;

71. <http://bvpa.ru>. Журнал "Воздушно-космический рубеж" ВКР 1-2017 22 of Август, 2017;
72. Clayton R. Newel and Michael D. Krause. "On Operational Art" Washington, D.C. 1994. Pg 120;
73. Framework for Future Alliance Operations. 2018. Pg 15;
74. Alexander Mattelaer. "The Crisis in Operational Art" 11 Nov 2009. Pg 8;
75. FM 3-0 Operations, headquarters, department of the army, October 2017, pg 1-20;
76. Ю.Б. Торгованова. "Общая тактика". Красноярск, СФУ. 2013;
77. "Хүч тэнцвэргүй дайн, байлдаан" УБ., 2018 он. – 186х; ISBN 978-99978-848-3-1;
78. Ш.Паламдорж. "Их Монгол Улсын цэргийн урлаг". 2006 он, УБ., х-354; ISBN 99929-9-181-X;
79. Ларионов В.В. и др. "Эволюция военного искусства: этапы, тенденции, принципы". М., 1987г, -246 стр;
80. М.М. Кирьян и др. "История военного искусства". М., 1986 г, -355 стр;
81. М.А. Гареев. "Афганская страда". М., 2002 г. -416 стр; ISBN 978-5-85840-301-2;
82. Гайворонский Ф.Ф. и др. "Основы стратегии и оперативного искусства". М., 1990г;
83. <https://yandex.ru> "Факторы влияющие на военные искусства"

**БАТЛАН ХАМГААЛАХ  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ЦЭРГИЙН УРЛАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ХӨГЖЛИЙН ЧИГ  
ХАНДЛАГА**

**(операц, тактикийн түвшинд)**

**Шифр: “Операцын урлаг”**

**БХЯ-ны захиалгат төслийн тайлан**

Улаанбаатар. 2019 он.